



Олон улсын
хөдөлмөрийн
байгууллага

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАНД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ: ПРАКТИК ГАРЫН АВЛАГА



Жендер, тэгш
эрх, олон талт
байдлын газар
Хөдөлмөрийн
нөхцөл, тэгш
байдлын хэлтэс

Ур чадвар,
хөдөлмөр
эрхлэлтийн газар
Хөдөлмөр
эрхлэлтийн
бодлогын хэлтэс

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАНД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮМҮҮСИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ:
ПРАКТИК ГАРЫН АВЛАГА

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага – Женев хот

Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны бүтээлүүд Зохиогчийн эрхийн тухай Түгээмэл Конвенцийн 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрхийг эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Нийтлэлийн албанд (Эрх, Зөвшөөрөл) International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар, эсхүл дараах и-мэйлээр хандана уу: pubdroit@ilo.org. Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо ийм хүсэлтийг таатай хүлээн авах болно.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.ifro.org хаягаар мэдээлэл авна уу.

Мэргэжлийн сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах нь: Практик гарын авлага / Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, 2015

Албан бус орчуулга.

978-92-2-828099-9 (хэвлэсэн)

978-92-2-828100-2 (вэб pdf)

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага: Жендер, Тэгш байдал, Олон талт байдал

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан / хөгжлийн бэрхшээл / мэргэжлийн сургалт

15.04.3

ILO Cataloguing in Publication Data

Нэгдсэн Үндэстний Байгууллагын журмын дагуу ОУХБ-аас хэвлэн нийтэлж буй бүтээлийг зохиоход ажиллуулсан хүмүүс болон түүнд дурьдсан материалууд нь аль нэг улс, газар нутаг, тэдгээрийн захиргааны эрх зүйн байдал болон хил хязгаарын талаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын зүгээс ямар нэгэн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Зохиогчийн нэрээр хэвлэгдсэн аливаа нийтлэл, судалгаа, бусад бүтээлүүдэд илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн зохиогчийн өөрийнх бөгөөд хэвлэн нийтэлсэн нь түүнд илэрхийлсэн үзэл бодлыг ОУХБ-аас дэмжиж сайшаасан гэсэн утгыг агуулахгүй.

Бүтээлд пүүс компани, арилжааны бүтээгдэхүүн, үйл явцыг дурьдсанаар тэдгээрийг ОУХБ-аас хүлээн зөвшөөрсөн хэрэг биш бөгөөд харин аливаа пүүс компани, арилжааны бүтээгдэхүүн, үйл явцыг дурьдахгүй өнгөрснөөр тэдгээрийг үл зөвшөөрснийг илтгэхгүй.

ОУХБ-аас хэвлэн нийтэлсэн материалуудыг томоохон номын дэлгүүрүүд болон олон оронд байгаа ОУХБ-ын товчоодоос, эсвэл ОУХБ-ын хэвлэлийн газраас дараах хаягаар авч болно: ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland. Шинэ бүтээлүүдийн жагсаалт буюу каталогийг дээрх хаягаар буюу pubvente@ilo.org гэсэн цахим шуудангаар хандаж үнэ төлбөргүй авах боломжтой.

Манай вэб сайтад зочилно уу: www.ilo.org/publns.

Монгол улсад 1000 хувийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр хэвлэв.

Үнэгүй тараагдана.

ӨМНӨХ ҮГ

Мэргэжлийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах нь: Практик гарын авлага нь Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-аас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн суралцах эрхийг эрүүл хүмүүсийн нэгэн адилаар дэмжихэд зориулж гаргасан гарын авлага юм. ОУХБ нь ур чадварын сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст адил тэгш хандаж, оролцоог нэмэгдүүлэхийг дэмжиж ирсэн юм. НҮБ-аас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг батлан гаргаж, түүнд улс орнууд олноор нэгдэн орж батламжлахын хирээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурах, хөдөлмөрлөх эрхийн асуудалд анхаарал хандуулах явдал улам нэмэгдсээр байна. Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ мэргэжлийн сургалтанд хамрагдах нөхцөл бололцоогоор хангаж, бусад эрхийг нь дэмжих зорилгоор хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулж байна.

ОУХБ-аас гаргасан анхны конвенц, зөвлөмжүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар гарч байсан нь тус байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд адил тэгш, боломжоор хангахад үзүүлж буй дэмжлэгийн тод жишээ юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн тухай 1955 оны 99 дүгээр Зөвлөмжид *“Боломжтой бүх тохиолдолд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл хүмүүсийн нэгэн адил ижил нөхцөлд суралцах эрхтэй”* гэж заасан байдаг. ОУХБ-аас 1955 онд тодорхойлсон энэхүү зарчмыг өнөөдөр оролцоог хангаж, тэгш хамруулах гэсэн үгнүүдээр илэрхийлж байна. 1983 оны Мэргэжлийн нөхөн сэргээлт ба хөдөлмөр эрхлэлтийн (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс) тухай конвенциор улс орнуудад мэргэжлийн нөхөн сэргээлт (ажлын чиг баримжаа олгох, сургалтад хамруулах ба хөдөлмөрт зуучлах гэх мэт), “ижил тэгш боломж олгох зарчимд үндэслэсэн” хөдөлмөр эрхлэлтийн талаар бодлого хэрэгжүүлэхийг уриалсан юм. Уг конвенцийг дагалдан гарсан 168-р зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн сургалт (болон холбогдох үйлчилгээ) нь нийт хүн амд зориулсан мэргэжлийн сургалттай аль болохоор адил төстэй байх ба “зайлшгүй шаардлагатай зарим нэг зохицуулалт хийж” болохыг заажээ. Өнөө үед эдгээр зохицуулалтад барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан өөрчилж, хүртээмжийг нэмэгдүүлэхийг хэлж байна.

Хөгжлийн бэрхшээлийн тухай тусгайлан заасан эдгээр стандартуудаас гадна ОУХБ-ын бүх конвенци, зөвлөмжүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгасан байдаг. Зарим нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар онцгойлон дурдсан байна. Энэхүү гарын авлагад Хүний нөөцийн хөгжлийн тухай, Боловсрол, сургалт ба насан туршийн боловсролын тухай 2005 оны 195-р Зөвлөмжинд оруулсан бөгөөд энэхүү зөвлөмж нь “тухайн орны хувьд үндэсний түвшинд тусгай хэрэгцээ шаардлагатай гэж үзсэн, Тухайлбал залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цагаачид, ахмад настан, уугуул иргэд, үндэсний цөөнх ба нийгмийн хувьд гадуурхагдсан гэх мэт бүхий л хүмүүст боловсрол, сургалт ба насан туршийн сургалтад хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх ёстой” гэж тэмдэглэсэн юм.

Оролцоог нэмэгдүүлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хангамж үйлчилгээтэй холбоотой эдгээр зарчмууд нь Мэргэжлийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх нь: Практик гарын авлага номын үндсэн зарчим юм. 2008 онд хэвлэгдсэн Олон нийтэд түшиглэж нөхөн сэргээх замаар ур чадварыг хөгжүүлэх нь: Сайн туршлага, Амжилтын төлөөх Сургалт: Сургагч багшийн гарын авлага зэрэг номнуудын хувьд одоо ч ач холбогдолтой хэвээр байна. Мөн 1999 онд хэвлэгдсэн Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах нь: Практик гарын авлагыг өнөөг хүртэл хэрэглэж байгаа бөгөөд интернэтээс татаж авах бүрэн бололцоотой.

Үүнээс гадна ОУХБ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн ур чадварын асуудлаар хэд хэдэн олон улсын хурал зохион байгуулсан. Тухайлбал: 2008 онд Канадын Квебек (Quebec, Canada) хотноо Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн сургалтад хамрагдах эрхийг хэрэгжүүлэх нь; Үйл ажиллагааг эрэлхийлэх семинар, Мэргэжлийн боловсрол, сургалт дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах асуудлаар 2006 онд зохион байгуулсан экспертүүдийн чуулга уулзалт зэргийг дурдаж болно. Эдгээр үйл ажиллагааны үр дүнг энэхүү гарын авлагад тусгасан бөгөөд тэмдэглэл, тайлангуудыг www.ilo.org/disability хуудаснаас авч болно.

Та Мэргэжлийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах нь: Практик гарын авлагаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг нээлттэй болгох, улмаар тэднийг амжилтанд хүргэхэд чиглэсэн бодлого стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд дөхөм болох практик санаа, арга хандлагуудыг олж мэдэж болно. Иймээс энэхүү гарын авлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах, нэмэгдүүлэх олон улсын бодлого, чиг хандлага, онол, практикийн асуудлууд, мэргэжлийн сургалтын байгууллагуудад хичээл, дадлагын үеэр ашиглаж болох тусгай арга техник зэргийг тусгаж оруулснаараа дээр дурдсан гарын авлага, материалуудаас илүү онцлог юм.

Энэхүү гарын авлагыг албан бус сургалт, орон нутгийн эсвэл олон нийтэд түшиглсэн хөтөлбөрүүд, албан ёсны гэрчилгээ олгодог төрийн өмчийн сургалтын байгууллагуудын удирдах ажилтан, багш нарт зориулав. Мөн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад зориулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх, шаардлагатай төсөв хөрөнгийг байршуулж хэрэгжилтийг хангаж ажиллахад дөхөм болохуйц санаануудыг уг гарын авлагад тусгалаа.

Сургалтыг гардан явуулж буй багш, ажилтнуудад зориулан суралцагчдыг хэрхэн татах, сургалтын найрсаг орчин бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амжилтанд хүргэхэд байгууллага, хүмүүстэй хэрхэн хамтран ажиллах тухай практик зөвлөгөө, чиглэлийг гарын авлагад тодорхой оруулсан болно. Олон улсын болон үндэсний бодлого, стандартыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн ур чадвартай багшлах боловсон хүчин чухал бөгөөд тэднээр дамжин нийт суралцагчид, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг сургалтанд бүрэн хамруулах боломжтой болдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах чиглэлээр

мэргэжлийн боловсролын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажиллаж, сурч, амьдарч байгаа газар орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж байдаг.

ОУХБ-ын зүгээс энэхүү гарын авлагыг анхлан зохиосон хатагтай Патрисиа Моррисейд талархал илэрхийлэхийг хүсч байна. Түүнчлэн Хасан Алсаффар, Ашвани Аггарвал, Раймонд Граннал, Абделхамид Калай, Хассан Ндани, Сандра Рот-боик, Горм Скжаирлэнд ба Петер Фремлин нарт, мөн ОУХБ-д урьд өмнө ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа, уг гарын авлагын өмнөх хувилбарт саналаа өгч шинэчлэхэд хувь нэмрээ оруулсан бүх ажилтан, зөвлөхүүддээ талархал илэрхийлж байна. Үүний зэрэгцээ гарын авлагын агуулга, бүтэц, жишээ ишлэлийг шинэчлэхэд хувь нэмрээ оруулж, ялангуяа ОУХБ-ын үзэл баримтлалыг тусгаж ажилласан Хөгжлийн бэрхшээлийн оролцооны ахлах мэргэжилтэн агсан Дебра Перрид ОУХБ-аас онцгой талархал илэрхийлж байна. Үргэлжлүүлэн шинэчлэхэд ажилласан хөгжлийн бэрхшээлийн ахлах мэргэжилтэн Барбара Муррейд талархал илэрхийлье.

Эцэст нь, энэхүү гарын авлагыг ашиглан мэргэжлийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангахаар зорьсан та бүгдэд ОУХБ-аас талархал илэрхийлж бүхий л хичээл зүтгэлд тань амжилт хүсье.

Крис Эванс-Клок

ОУХБ-ын Ур чадвар, хөдөлмөр
эрхлэлтийн хэлтсийн дарга

Жейн Ходжес

Жендэр, тэгш байдал, төрөлжилтийн
хэлтсийн дарга

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	5
ОРШИЛ	11
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТУХАЙ СУДАЛГАА.....	13
1.1 Бүлгийн зорилго.....	13
1.2 Нэр томъёо, хөгжлийн бэрхшээл ба хандлага.....	13
1.2.1 Нэр томъёо, тодорхойлолтууд	13
1.2.2 Хөгжлийн бэрхшээлийн тухай баримт ба бусад асуудлууд	14
1.2.3 Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, төсөөлөл	16
1.3 Оролцоо	18
1.3.1 Оролцоо - үйл ажиллагаанд хамтран оролцох нь.....	18
1.3.2 Оролцооны шинж чанар	19
1.3.3 Оролцоог хангахын ач холбогдол.....	20
1.4 Оролцоог хангах үндсэн зарчмууд.....	21
1.4.1 Түгээмэл загвар ба хүртээмж.....	21
1.4.2 Тохирох хэрэглэгдэхүүн	23
1.4.3 Хөгжлийн бэрхшээлийн тухай мэдлэг олгох сургалт	25
1.5 Багш, удирдах ажилтнуудын анхааралд.....	26
1.6 Дүгнэлт.....	37
 ХОЁРДУГААР БҮЛЭГ: ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ	 29
2.1 Бүлгийн зорилго.....	29
2.2 Хүсэл эрмэлзэл, хэтийн зорилт.....	29
2.2.1 Үндсэн хүчин зүйлс	29
2.2.2 Үүрэг хариуцлагыг бүрдүүлэх.....	30
2.3 Мэдээлэл цуглуулах	32
2.3.1 Суралцагчдын тухай мэдээлэл ба танай орчин нөхцөл	32
2.3.2 Бусад мэдээлэл.....	34
2.4 Зорилтоо тодорхойлох.....	35
2.5 Төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх.....	36
2.6 Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх	38

2.7 Удирдах ажилтан ба багш сургагч нарын анхааралд.....	40
2.8 Дүгнэлт.....	40

ГУРАВДУГААР БҮЛЭГ 3: ОРОЛЦООГ ДЭМЖСЭН СУРГАЛТЫГ ХӨГЖҮҮЛЭХ41

3.1 Бүлгийн зорилт	41
3.2 Суралцах үйл явц.....	41
3.3 Мэдлэг эзэмших явцыг дэмжих стратеги	42
3.4 Хариу санал дүгнэлт.....	49
3.5 Хөгжлийн онцлог бэрхшээлтэй хүмүүст туслах хэрэгслэлийн үйлчилгээ үзүүлэх	50
3.5.1 Үндсэн журам.....	50
3.5.2 Стратегийн жишээнүүд	51
3.6 Сургалтын туршид туслах хэрэгслэлийн үйлчилгээг хэрэгжүүлэх	53
3.6.1 Сурталчлан таниулах, элсүүлэх, хүсэлт гаргах, хүлээн зөвшөөрөх? хүлээн авах	54
3.6.2 Заах үйл явц.....	58
3.6.3 Үнэлгээ ба шалгалт, тест	59
3.7 Багш, удирдах ажилтнуудын анхааралд.....	61
3.8 Дүгнэлт.....	61
Хавсралт 1	62
Хавсралт 2	64

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙГМИЙН ОРОЛЦООНЫ АСУУДАЛ67

4.1 Зорилт	67
4.2 Нийгмийн оролцоог дэмжих харилцан үйлчлэл\нөлөөлөл	67
4.3 Нийгмийн оролцоог дэмжих нөхцөл байдал	67
4.4 Хөгжлийн бэрхшээлийн ёс зүй	68
4.5 Багш, удирдах ажилтнуудын анхааралд.....	68
4.6 Дүгнэлт.....	69
Хавсралт 3	70
Ном зүй	74

ОРШИЛ

Гарын авлагын тухай

Энэхүү гарын авлагын гол зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн ажиллах талаар мэргэжлийн сургалтын төвийн багш, удирдах ажилтнуудыг практик зөвлөгөөгөөр хангахад оршино. Удирдах ажилтан гэх нэр томъёонд мэргэжлийн сургалтын байгууллагын дарга, менежер буюу мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын удирдах ажилтнуудыг хамруулж ойлгоно.

Багш, удирдах ажилтнууд нягт хамтран ажиллаж оролцоог хангасан сургалтын орчныг бүрдүүлэх бөгөөд практик зөвлөгөөнүүдийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд төрийн зүгээс зохих шийдвэрээр дэмжиж, мэргэжлийн сургалтын тогтолцооны санхүүгийн нөөцтэй байх шаардлагатай. Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн ур чадварын сургалтад хамрагдах, адил тэгш боломж олгох, олон улсын зарчмуудад үндэслэсэн мэдээллийг энэхүү гарын авлагаас авах боломжтой. Гарын авлагад адил тэгш оролцооны талаар үндсэн нэр томъёо, ойлголтыг тайлбарласан ба тэдгээрийн зарим нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенци (UNCRPD), ОУХБ-ын конвенци зэрэг олон улсын стандартуудад туссан байдаг.

Уг гарын авлага нь бодлого боловсруулах эсвэл хуулийн төсөл боловсруулахад зориулагдаагүй. Харин төсөв, бодлогын шинж байдлаас үл хамааран аль ч түвшинд хэрэглэж болох практик зөвлөгөө юм. Гэхдээ, аливаа саад бэрхшээлийг арилгах, боловсон хүчнийг сургах, тусгай зориулалтын хэрэгсэл, технологи худалдан авах зорилгоор хөрөнгө төвлөрүүлж зарцуулах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Харамсалтай нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар нийтлэг хэвшсэн сөрөг хандлагаас улбаалж ийм иргэдийн идэвхтэй оролцоо, амжилт хязгаарлагдаж байдаг. Энэхүү гарын авлагад дээр дурдсан сөрөг хандлага, бэрхшээлийг шийдвэрлэхийг оролдов. Энэхүү хандлагыг өөрчлөхөд практик дадлага туршлага л хамгийн сайн үр дүнд хүргэнэ.

Энэхүү гарын авлагад агуулгыг тайлбарлахдаа “чи, эсвэл та” гэсэн хоёрдогч эзэн биеийг ашигласан болно. Гарын авлагын гол утга санаа нь сургалтын хөтөлбөр, хичээл, семинар, түүнчлэн ажил олгогчийг түшиглэсэн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхитэй оролцуулахын тулд та өөрөө, багш, удирдах ажилтны хувьд юу хийж чадах вэ гэдэгт чиглэж байна. Мөн таныг санаачлагатай байж анги танхим, сургалтын орчинд оролцооны зарчмуудыг хэрэгжүүлэх, бүтээлч үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах, орчиндоо тодорхой саад бэрхшээлтэй тулгарахад үүсч байгаа үр дагаварыг арилгахыг уриална.

Энэхүү гарын авлагад та хөдөө орон нутаг, төрийн болон төрийн бус, хувийн сургуулиудын сургалтын хөтөлбөр, ажлын байран дахь сургалт зэргийн алинд нь ч хэрэглэж болохуйц, мөн бодлогын ба санхүүгийн хүссэн дэмжлэгээ авч чадаж байгаа эсэхээс үл хамааран ямар ч нөхцөлд хэрэглэж болох санаа, зарчмуудтай танилцах болно.

Гарын авлагыг хэрхэн ашиглах вэ

Гарын авлага дөрвөн бүлэгтэй:

- 1: Хөгжлийн бэрхшээлийг ойлгох нь
- 2: Оролцоог төлөвлөх нь
- 3: Суралцах үйл явц, Хөгжлийн бэрхшээл ба тусламж, үйлчилгээ
- 4: Нийгмийн оролцоог хангах тухай

Дээр дурдсан товч бүтцээс бүлгүүд хоорондоо харилцан уялдаатай нь харагдаж байна. Нэгдүгээр бүлэгт хөгжлийн бэрхшээл ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх үндсэн мэдээллийг оруулсан бөгөөд энэ нь бусад бүлгүүдэд мөн адил хамаарна. Оролцоог (хоёрдугаар бүлэг) төлөвлөхдөө анги танхимд буюу сургалтын орчинд болж буй үйл явц, бодит байдлыг (гуравдугаар бүлэг) нийгмийн харилцааны хүрээнд (дөрөвдүгээр бүлэг) авч үзэж сайтар ойлгох шаардлагатай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дасан зохицож суралцах үйл явцад чухал ач холбогдолтой. Иймээс та уг гарын авлагыг эхнээс нь дуустал уншаад дараа нь сонирхсон сэдвүүдээ шаардлагатай үедээ эргэн судлахыг зөвлөж байна.

Бүлэг тус бүрт суурь мэдээлэл, практик ач холбогдол бүхий жишээг тусгасан ба эхэндээ энгийн зорилго дэвшүүлээд бүлгийн төгсгөлд сургагч багш, удирдах ажилтнуудад хандан тусгай санал, товч дүгнэлт гаргасан байгаа. Бүлэг тус бүрийн ард холбогдох хэрэглүүр буюу хянах жагсаалтыг хавсаргаж өгсөн.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТУХАЙ СУДАЛГАА

1.1 Бүлгийн зорилго

Оролцоог хангахын тулд та хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өнөөгийн байдал, тэдгээрийн эрхийн тухай бодлого хөтөлбөр, өөрийн байгууллагадаа хэрэглэж болохуйц оролцооны арга хандлагыг судлах хэрэгтэй.

Бүлгийн зорилго:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай, хөгжлийн бэрхшээлийг хэрхэн хүлээн авч ойлгож байдаг тухай суурь мэдээлэл өгөх.
2. Оролцоог хангах үндсэн зарчим, аргуудыг танилцуулах.

1.2 Нэр томъёо, хөгжлийн бэрхшээл ба хандлага

1.2.1 Нэр томъёо, тодорхойлолтууд

ОУХБ нь дэлхийн улс орнуудад хэрэглэж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээл бүхий иргэн гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Тухайлбал, Англид хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж түлхүү хэрэглэдэг ба Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын байгууллага зэрэг бие даасан төлөөллийн бүлгүүд мөн үгийг хэрэглэдэг. Харин, “хүн”-ээр эхэлсэн үг хэллэгийг зарим орнууд онцгойлон хэрэглэдэг ба “хөгжлийн бэрхшээлтэй хүн”, эсвэл “оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэх нэр томъёог илүүд тооцдог байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцахдаа тэдгээрийн өөрсдийнх нь хэрэглэдэг, тухайн оронд чухал гэж үзэх хэллэг, нэр томъёог ашиглах нь чухал.

Хөгжлийн бэрхшээлийн онцлог хэлбэрүүдийг нэрлэхдээ зарим нэр томъёог улс орнуудад өөр өөрөөр хэрэглэдэг байна. Тухайлбал, зарим оронд суралцах бэрхшээлтэй гэх нэр томъёог бусдаас ялгаатайгаар мэдээллийг хүлээн авч боловсруулдаг бөгөөд үүний улмаас суралцах арга хэлбэр нь мөн бусдаас ялгаатай байдаг хүмүүсийн хувьд хэрэглэдэг байна. Тэд дислексиа, буюу хүний унших чадварт нөлөөлдөг өвчтэй байж болох ч оюуны чадавхи нь хэвийн байдаг. Дэлхий дээр Англи зэрэг цөөн хэдэн оронд энэ нэр томъёонд оюуны бэрхшээлтэй хүмүүсийг багтааж хэрэглэдэг. Уг гарын авлагад суралцах чадвар нь бусдаас арай удаан хүнийг оюуны хөгжлийн бэрхшээлтэй гэж хэлэх ба суралцах бэрхшээлтэй гэх нэр томъёог мэдээллийг бусдаас өөрөөр хүлээн авч боловсруулдаг хүний хувьд хэрэглэнэ.

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээл гэх нэр томъёог зарим улс орнууд оюуны хөгжлийн бэрхшээл болон сэтгэл санаа-нийгмийн хөгжлийн бэрхшээлийн аль алиныг нь багтааж хэрэглэх нь түгээмэл байдаг. Харин ингэх нь төөрөгдүүлэх талтай тул уг гарын авлагад хэрэглээгүй болно. Та өөрийн ажилдаа оюуны ба сэтгэл санаа-нийгмийн хөгжлийн бэрхшээл гэх нэр томъёонуудыг онцлон хэрэглэх, эсвэл тусгайлан зааглах өөр нэр томъёог хэрэглэх нь зүйтэй.

Ингээд хөгжлийн бэрхшээл буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэрхэн тодорхойлох вэ? ОУХБ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажил хэргийн зорилгоор тодорхойлохдоо: “Зохих журмын дагуу тогтоогдсон бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл мэдрэхүйн согогийн улмаас хөдөлмөр эрхлэлтээ хэвээр хадгалах, түүндээ эргэж орох, ахиж дэвших чадвар нь эрс буурч хязгаарлагдсан хүн” гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид хөгжлийн бэрхшээлийг “хувьсан өөрчлөгддөг ойлголт” гэж үзэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл мэдрэхүйн согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг» хэлнэ гэж тодорхойлсон байна.

Тухайн оронд хөгжлийн бэрхшээлийн албан ёсны тодорхойлолт ба түүнийг хэрхэн, ямар зорилгод хэрэглэхээс хамаарч өөр хэд хэдэн тодорхойлолт байж болно. Тухайлбал, нийгмийн даатгалын тэтгэмжийг тогтоох зорилгоор хөгжлийн бэрхшээлийг тодорхойлохдоо анагаах ухааны чиглэлийг барьж болно. Харин хөдөлмөр эрхлэлтийг хангаж, мэргэжлийн сургалтад хамруулах зорилгоор мэргэжил, ажил үүргийн чиглэлтэй тодорхойлолтыг ашиглах нь тохиромжтой.

1.2.2 Хөгжлийн бэрхшээлийн тухай баримт ба бусад асуудлууд

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банкны мэдээгээр дэлхийн хүн амын 15 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна. Энэ талаарх статистик мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолтын адил улс орнуудад өөр өөр байж болох хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо таны төсөөлж байгаагаас хавьгүй олон байгаа гэж бодож болно. Түүнчлэн танай анги танхимд, яг одоо сурч байгаа суралцагчид дотор хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдоогүй хүмүүс ч байх магадлалтай.

Дараах чухал асуудлуудыг харгалзан үзэх нь зүйтэй:

- Хөгжлийн бэрхшээл нь таяг тулж яваа хүнээр төсөөлөгдөж болно.
- Хөгжлийн бэрхшээл нь ил харагдахгүй дүлий, эсвэл сурах бэрхшээлтэй гэх төрөл хэлбэртэй байж болно.
- Хөгжлийн бэрхшээлүүд тодорхой төрөлтэй байна: үүнд хараагүй, дүлий, сурах бэрхшээл, аутизм, сэтгэцийн, оюун ухааны хөгжлийн бэрхшээл гэх мэт.

Хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэр нь адил хэдий ч хүмүүсийн чадварын түвшин нь ялгаатай байдаг. Жишээ нь:

Хараагүй гэх нэг нь юу ч хардаггүй байхад өөр нэг хүн хараагүй гэх оноштой мөртлөө тодорхой орон зайд зүг чигээ олох, том үсэгтэй бичиг уншиж чаддаг байна.

Тархи нугасны саа \cerebral palsy\ өвчтэй хүн явж чаддагүй, сайн ярьж чадахгүй эсвэл гарын хөдөлгөөнөө залж удирдаж чаддаггүй байхад адил оноштой өөр нэг нь бусдын дэмжлэгтэйгээр явж чаддаг, хүнд ойлгогдохоор ярьдаг, гараа хөдөлгөж ашиглах чадвартай байна.

- Тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрөл, оношийг үндэслэн уг хүний чадварын талаар шууд дүгнэлт гаргаж болохгүй.
- Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэргэжлийн ур чадварын сургалт, хөтөлбөрт хамрагдахад аливаа зохицуулалт, нэмэлт арга хэмжээ авах шаардлага гарахгүй. Тухайлбал, ялимгүй доголж явдаг хүн нягтлан бодогч бэлтгэх сургалтад оролцохын тулд аливаа нэмэлт тусламж, хангамж авах хэрэггүй юм.
- Зарим хүнд бага зэргийн энгийн дэмжлэг хэрэгтэй болно. Тухайлбал, уншихад нь хялбар болгох үүднээс том үсэг хэрэглэх гэх зэрэг. Харин зарим тохиолдолд нэлээд дорвитой нэмэлт хангамж тусламж шаардагдана. Жишээ нь байшин барилгын ойр орчинд явах, хичээлийн явцад багшийн тайлбарлаж байгаа зүйлсийг “мэдрэх” боломжтой байх, хэвлэмэл материалын тайлбарыг буулгасан дуу бичлэгийн хальсаар хангах зэрэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүмүүс өөрт нь ямар тусламж хэрэгслэлийн дэмжлэг хэрэгтэйг сайн мэдэж байдаг тул танд хэрэгцээгээ тайлбарлан хаанаас яаж олж болохыг хэлж өгч чадна. Зарим хүмүүсийн хувьд та хэрэгцээ шаардлагыг нь тодорхойлох асуулт тавьж хариулт авах замаар ямар дэмжлэг хэрэгтэйг тодорхойлж болно. Зарим хөгжлийн бэрхшээлтэй иргэд ямар тусламж өөрт нь шаардлагатайг мэдэхгүй байж болно.
- Танай сургууль, сургалтын төвд ирж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сургалтанд бүрэн оролцох боломжийг хангахад ямар зохицуулалт, дэмжлэг хэрэгтэй байгааг тодорхойлж шийдэхэд бүрэн туслалцаа үзүүлж чадна.

Дээр дурдсан жишээнүүд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй гэх тодорхойлолтыг үндэс болгон хүмүүсийн талаар ерөнхий дүгнэлт гарган хандаж болохгүй гэдгийг харуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энгийн хүмүүсийн нэгэн адил өөрийн гэсэн өвөрмөц хүсэл эрмэлзэл, сонирхол, авьяас чадвартай байдаг. Хөгжлийн бэрхшээл нь өвөрмөц шинжийг нэмэгдүүлдэг тул та удирдах ажилтан, сургагч багшийнхаа хувьд эдгээр өвөрмөц шинж чанарыг анхаарч харгалзан үзэж байх үүрэгтэй.

Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлийн мөн чанар, хэвшмэл сэтгэлгээний улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургалтын зөвхөн тодорхой чиглэлд хамрагдах боломж олгож байдаг. Тухайлбал, хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс сууж ажиллах боломжтой учир компьютерийн мэргэжлээр суралцах, хараагүй хүмүүс иллэг, бариа заслын мэргэжилд суралцах жишээтэй.

Ийм арга хандлага нь хүмүүсийн чадвар, сонирхлыг нь үндэс болгох бус хөгжлийн бэрхшээлийг нь гол хүчин зүйл болгож сургалт, ажлын байранд хамруулдаг. Гэтэл сайн сургалтын төвүүд суралцагчийн чадвар, сонирхлыг нь судлан тодорхойлж өөрсдөд нь мэргэжил, сургалтын сонголт хийх боломж олгож байдаг. Ийм арга барилыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд нэгэн адил хэрэгжүүлэх шаардлагатай. Хэвшмэл буруу сэтгэлгээ, хандлагыг арилгаж өөрчлөх талаар ажиллаж боломжуудыг нээлттэй болгох хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хэвшмэл ойлголт нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд мөн хамаарах ч, жендерийн талаас уг асуудлыг харах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд давхар бэрхшээлтэй тулгарч байдаг нэг талаас хөгжлийн бэрхшээл, нөгөө талаас хүйсээр ялгаварлах байдал. Жирийн эмэгтэйчүүд хэвшсэн сэтгэлгээ хандлагын улмаас үсчин, тогооч гэх мэт мэргэжил сонгон суралцах нь түгээмэл байдагтай адил хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бусдын бодлоор тэдэнд илүү тохиромжтой гэж тооцдог ажил мэргэжилд суралцах хандлага зонхилж байдаг. Жишээлбэл, эмэгтэйчүүдэд илүү тохиромжтой гэж нийтлэг тогтсон үзлийн дагуу дүлий эмэгтэйг оёдолчин, гар урлалын ангид түлхүү элсүүлэх ба тэдгээр эмэгтэйчүүдийг өөрсдийнх нь илүү сонирхож хүсч буй машин засвар, гагнуурчин зэрэг мэргэжлээр төдийлөн элсүүлдэггүй байна.

Энэхүү гарын авлага нь хөгжлийн бэрхшээл гэж юу вэ, шинэ техник технологи, бусад дэмжлэгийг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ гэх зэргээр хөгжлийн бэрхшээлийн тухай асуудлаар та бүхнийг илүү нээлттэй сэтгэж, ойлгоход тань туслана гэдэгт найдаж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн өмнө сургалтын бүх боломж нөхцөл нээлттэй байх ёстойг танд сануулж байна.

1.2.3 Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, төсөөлөл

Хөгжлийн бэрхшээлийн тухай хоцрогдсон ойлголт, төсөөллүүд

Олон жилийн турш хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс голдуу гэртээ юмуу тэдэнд зориулж байгуулсан тусгай газруудад, эсвэл өөр арга хэлбэрээр нийгмээс тусгаарлагддаг байсан. Тэдэнд сургууль, сургалтын байгууллагуудад суралцах боломж олголоо гэхэд энгийн иргэдээс ялгаатай байхаас гадна цаг засвар (дугуйт тэргэнцэртэй хүн), бариа засал, хулс сүлжих (хараагүй хүнд) гэх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд илүү зохимжтой гэх ажил, мэргэжлийг сонгодог. Сөрөг төсөөлөл, ойлголтууд нь тэднийг ялгаварлах, тусгаарлах байдлын үндэс болж ирсэн. Хөгжлийн бэрхшээлийг төсөөлөх хэлбэрүүд:

- Зовлон шаналгаа
- Халдварт өвчин
- Үйлийн үрээр эцэг, эх, эсвэл тухайн хүнд тохоож байгаа шийтгэл
- Эмнэлгийн ажилтан болон бусад мэргэжилтнүүд эмчилж анагаах ёстой эрүүл мэндийн асуудал

- Энгийн иргэдийн сэтгэл санааны тэнцвэрийг алдагдуулах, таагүй үзэгдэл.

Тусгаарлагдсан орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар анхаарал халамж тавьж ганцаарчилсан болон тусгай үйлчилгээ үзүүлэх илүү тохиромжтой гэж үздэг шийдвэр гаргагчид бий. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтыг тусгайлан орчинд явуулах нь тэдгээрийн чадавхид илүү тохирно гэж үздэг бөгөөд тэдэнд илүү анхаарал тавих боломжтойгоос гадна энгийн иргэдийн сургалтын явц, ахицыг “сааруулахгүй” байх онцлогтой гэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар гаргасан зарим шийдвэрийг хөгжлийн бэрхшээлтэй тухайн хүн өөрөө бус, өөр хэн нэгэн хүн тэдний өмнөөс гаргасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийн хүсэл сонирхол, бодол мөрөөдөлд анхаарал хандуулах нь тохиолдлын шинжтэй байсан.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх орчин үеийн ойлголт, төсөөлөл:

Нийгмийн загвар

Хүний эрхийн төлөөх хөдөлгөөнийг дагалдан хөгжлийн бэрхшээлийн нийгмийн төлөв загвар үүсэн бий болжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эх орныхоо нийгэм, эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцоход нийгэм өөрөө тодорхой саад бэрхшээлийг учруулж байдаг. Нийгэм өөрөө эдгээр саад бэрхшээлийг арилгах үүрэгтэй ба хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ саад бэрхшээлийг арилгах үйл явцад гол үүргийг гүйцэтгэх ёстой. Саад бэрхшээлийг арилгахдаа хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх тухай хууль тогтоомж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх ойлголт хандлагыг өөрчлөхөд чиглэн ажиллах хэрэгтэй.

Өнөөдөр олон улс оронд хөгжлийн бэрхшээлтэй иргэд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага (ХБХБ) болон нэгдэж, нийгэмд өөрийн дуу хоолойг хүргэж байна. Өөрсдийн төлөө ингэж хамтран ажиллах нь тэдэнд гэр бүл, найз нөхөд, нийгэмд гүйцэтгэх үүргийг тодорхойлоход нь тус дөхөм болдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүчтэй дуу хоолой, нэгдэн нийлсний үр дүнд нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх ойлголт эерэг тал руу өөрчлөгдөж дараах зарчмуудыг хүлээн зөвшөөрч байна:

- хэзээ ч, хэний ч амьдралд хөгжлийн бэрхшээл тулгарч болзошгүй;
- хөгжлийн бэрхшээл бол амьдралын бодит байдал бөгөөд байгалийн жамаар тохиолдох үйл явц;
- хөгжлийн бэрхшээл нь байнгын, эсвэл түр хугацаанд үргэлжилж болно;
- тодорхой орчинд оролцоог хязгаарласан саад бэрхшээлийг арилгасан нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тухайн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хувь нэмрээ оруулах боломжтой;
- саад бэрхшээлийг арилгах, оролцоог нэмэгдүүлэх нь хүний эрх юм.

Мэргэжлийн сургалтын байгууллагад саад бэрхшээлийг арилгасан энгийн хоёр жишээг танилцуулъя.

Жишээ 1:

Педро хөдөлгөөний бэрхшээлтэй ба компьютерийн программчлалд суралцах сонирхолтой, гэтэл компьютерийн лабораторид очиход олон шаттай байлаа. Энэ саадыг арилгахын тулд компьютерийн лабораторийг шилжүүлэн байршуулах, эсвэл хэн нэг нь Педрод шатаар гарахад нь (ингэх боломжтой бол) туслах, сургалтын материалыг нь зөөж өгч болно. Хэрэв Педро дугуйт тэргэнцэрээр зорчдог бол шатнаас гадна эсвэл шатны оронд нэмэлт төхөөрөмж суурилуулах шаардлагатай.

Жишээ 2:

Хараагүй хүнд зориулсан ярианы программ ашиглах, эсвэл дүлий хүмүүст зориулсан дохионы хэлний хэлмэрч хөлслөх нь харьцангуй өндөр өртөгтэй байдаг тул сургалтын байгууллага төсвөө эдгээрт зориулж зарцуулахыг хүсэхгүй байж болох ба энэ бэрхшээлийг даван туулах боломж бий. Төсөвт боловсролын тодорхой арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгийг тусгайлан тусгаж болно. Энэ тохиолдолд багш, зааварлагчийн сургалтын материалын зардлаас хөрөнгө гаргах шаардлагагүй болно. Түүнчлэн, удирдлагын зүгээс орон нутгийн байгууллагуудтай сайн дурын үндсэн дээр, эсвэл бага өртөг зардлаар хамтран ажиллах боломжтой юм.

Саад бэрхшээлийг арилгах хамгийн сайн арга нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ярилцаж, тэдний хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж болох тухай ярилцах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн өдөр тутмын амьдралд тулгарах саад бэрхшээлийг даван туулах аргаа хэдийнээ олсон байдаг. Сургалтын орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст анги танхимаа танилцуулж хичээлийн сэдэв, зааварчилгааг судлуулна. Тэднийг хичээл сургалтанд бүрэн оролцох боломжоор хангахын тулд шаардагдах дэмжлэг, зохицуулалт, хүртээмжийн жагсаалт гаргана.

Дараах асуудлуудаар ярилцаарай.

- Тухайн орчинд уг хүн чөлөөтэй байх боломжтой эсэх (байр, анги танхимд орох, ариун цэврийн өрөөг ашиглах, зоогийн газар, дотуур байрандаа чөлөөтэй хүрэх, зорчих боломжтой эсэх)?
- Анги танхимд бусдын адилаар суралцах боломжтой эсэх?
- Хэрэв боломжгүй бол ямар саад, бэрхшээл байна вэ?
- Саад бэрхшээлийг хэрхэн арилгах вэ?
- Хэзээ арилгах вэ?
- Хэн үүнд оролцох вэ?
- Саад бэрхшээлийг арилгах төлөвлөгөө гаргах.

1.3 Оролцоо

1.3.1 Оролцоо - үйл ажиллагаанд хамтран оролцох нь

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энгийн иргэдийн нэгэн адил аливаа үйл ажиллагаанд хамтран тэгш оролцож харилцахыг оролцоо гэнэ.

Агуулгын хувьд нэг анги танхимд байх гэдгээс илүү өргөн утгатай. Оролцоо гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энгийн иргэдтэй нэг цаг хугацаанд нэг зүйлийг хийж, туршлага солилцох тухай ойлголт юм. Өдөр тутмын амьдралдаа бид оролцооны жишээнүүдийг ажиглаж байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд энгийн иргэдтэй ресторанд хамт хооллох, дэлгүүрээс юм худалдаж авах, компьютерийн өмнө сууж харилцах, хамтарч цэцэг тарих гэх мэт.

Оролцоо нь хүний амьдралын зайлшгүй нэг хэсэг юм. Оролцоо гэх ойлголтод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энгийн иргэдийн нэгэн адилаар аливаа үйл ажиллагаанд оролцуулахад шаардагдах арга хэмжээ, дэмжлэг зохицуулалт багтана. Дэмжлэг нь бодит, биет байдлаар, эсвэл заавар зөвлөгөө өгөх хэлбэрээр байж болно. Хэвлэл мэдээллийг тогтсон стандартаас ялгаатай үсгийн хэмжээгээр хэвлэж өгөх, эсвэл дугуйт тэргэнцэрээр зорчих иргэдийг бусдын адилаар үйл ажиллагаанд оролцуулахын тулд орон зай, талбайг өөрчлөн зохион байгуулах зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлж буй дэмжлэгийн нэг хэлбэр юм.

1.3.2 Оролцоог хангах нь

Хөгжлийн бэрхшээлтэй ба энгийн хүмүүсийн оролцооны талаарх туршлага, хандлага нь ялгаатай байж болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй олон хүн энгийн иргэдийн нэгэн адил боломжтой байхыг эрмэлздэг. Тэд сургуульд суралцах, мэргэжил чадвараа хөгжүүлэх, ажил хийж, орон гэртэй байхыг хүснэ. Мөн гэр бүл, найз нөхөдтэй байхыг хүснэ. Тэд бусдаас тусгаарлагдахыг хүсэхгүй. Өмнөөсөө хэн нэгнээр юу сурах, ямар ажил хийхийг шийдвэрлүүлэхийг хүсэхгүй. Тэд хаана амьдрахаа өөрсдөө шийдэхийг хүснэ. Тэд гэр бүл, найз нөхдийн хамт аливаа үйл ажиллагаанд бүрэн оролцохыг хүснэ. Энэ бүгд тэдний хувьд оролцоо ямар чухал болохыг илэрхийлэх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцооны талаар маш их тэмүүлэлтэй байдаг.

Хөгжлийн бэрхшээлийн улмаас гадуурхагдах, сөрөг хандлага доромжлолд өртөж байсан хөгжлийн бэрхшээлтэй зарим хүмүүс оролцоонд болгоомжтой ханддаг. Тэд итгэлгүй, айдастай байдаг. Бодит зүйл биш учраас “оролцож” байгаадаа айдастай байж болно. Тухайлбал, энгийн иргэдтэй нэг анги танхимд суралцаж “оролцоо” хангагдсан мэт байвч тэднээс огт өөр зүйлийг хичээл дээрээ хийнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зайлшгүй шаардлагатай дэмжлэгээ авч чадахгүй байгаа тохиолдолд бусадтай адил сургалтын үйл явцад бүрэн оролцох боломжгүй болно. Жишээ нь сонсолгүй иргэн титргүй (яриаг давтсан дэлгэцэн дээрх бичлэг) дүрс бичлэг үзэх тохиолдолд бусдаас өөрөөр хүлээж авах нь тодорхой.

Энгийн иргэдийн хувьд амьдралын туршлага, ажиглалтандаа тулгуурлан оролцоо гэж юу болохыг сайтар ойлгосон байдаг. Тэдний зарим нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн найз, төлөөлөгч, тэдэнтэй хамт байсан туршлагатай байж болно. Гэтэл “оролцоог хэрэгжүүлэх үүрэг” хүлээсэн хүмүүсийн хувьд бүрэн ойлгохгүй байх тохиолдол бий. Магадгүй та ч бас эргэлзэж байж болох юм.

1.3.3 Оролцоог хангахын ач холбогдол

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ба энгийн иргэд аливаа зүйлийг хамтарч хийхдээ аль аль талын оролцоог бүрэн хангаж байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ба энгийн иргэд мэргэжлийн сургалтанд хамтран суралцаж байх явцдаа дараах зүйлийг ойлгодог:

- Тэдний зорилго, сонирхол нэг.
- Аливаа зорилгод хүрэхэд нэгээс илүү арга зам байдаг.
- Хамтдаа ажил үүрэг гүйцэтгэхэд ашиг тусыг нь бүгд хүртдэг.
- Бусадтай адилгүй өөр байх явдлыг хүндэтгэн хүлээн зөвшөөрөх нь бүх оролцогчдын хувьд сургалтын орчинг баяжуулж өгдөг.

Сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан бага зэрэг өөрчлөн зохион байгуулах нь сургалтад хамрагдаж байгаа нийт хүмүүст бас ач холбогдолтой байдаг. Тухайлбал:

- Хичээлийн эхэнд өмнөх хичээл дээр үзсэн сэдвээ товч давтах.
- Хичээлийн агуулга хөтөлбөрийг хичээлээс хичээлд тууштай мөрдөж байх.
- Суралцагч бүрт дараагийн хичээлийн тойм танилцуулга өгөх.

Оролцооны тухай эерэг үзэл, хандлага нь анги танхимын хүрээнээс хальж гэр бүл, орон нутгийн удирдлага, ажил олгогчдод хүрч болно. Багш, удирдах ажилтнууд, суралцагчдын зүгээс оролцоог хангасан сургалтын орчинд болж байгаа үйл явцыг бусадтайгаа хуваалцсаны үр дүнд эцэг эх, гэр бүл, ажил олгогч, орон нутгийн удирдлагуудын зүгээс өөрсдөө тэрхүү үйл явцтай танилцаж дэмжлэг тусалцаа үзүүлэх санаачлага гаргаж болно.

- Гэр бүлийн гишүүн нь мэргэжлийн ур чадварт суралцаж цаашид ажил хийж орлого олох боломж нээгдэхийг эх эцэг, гэр бүл, төрөл садан нь олж харна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрэлттэй мэргэжлийн ур чадварыг эзэмших боломжтой гэдгийг ажил олгогчид харна.
- Орон нутгийн удирдлага нь ажиллах хүчний өсөлтийн чиг хандлагыг ажиглаж тухайн орон нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах боломжтойг анхаарна.
- Хүн амын амьжиргааны бүхий л асуудлыг нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгохын ач холбогдлыг олон хүн ойлгоно.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын төв, бусад байгууллагуудад тусламж дэмжлэг үзүүлж оролцоог хангаж, хамтран ажиллахыг илүү олон хүн эрмэлзэх болно.

1.4 Оролцоог хангах үндсэн зарчмууд

Оролцоо нь үйл явц юм. Түгээмэл загвар бүхий зураг төсөл, шийдлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнчлэн түгээмэл загварыг ашиглаагүй тохиодолд нэмэлт өөрчлөлт, зохицуулалт хийх замаар тухайн орчин, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгож болно. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр төрлөөс нь үл хамаарч барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд зориулсан өөрчлөлт, зохицуулалтыг хийх, тэднийг үйл ажиллагаанд бүрэн оролцуулах, барилга байгууламжид нэвтрэх боломжоор хангах нь тохирох хэрэглэгдэхүүнийг бий болгох нэг үндсэн зарчим юм. Өөр нэг чухал зарчим нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, хөгжлийн бэрхшээлийн асуудлаар зөв, эерэг ойлголт төлөвшүүлж сөрөг хандлагыг арилгахад чиглэсэн сургалт, сурталчилгааны арга хэмжээ хэрэгжүүлэхэд оршино.

1.4.1 Түгээмэл загвар ба хүртээмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид тодорхойлсноор түгээмэл загвар гэж “ямарваа нэгэн нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад хамгийн дээд зэргээр тохиромжтой байж болох бүтээгдэхүүн, байрлал, программ болон үйлчилгээний хэв маягийг” хэлнэ. Гэхдээ үүн дээр нэмээд тухайн хүний өвөрмөц хэрэгцээнд нийцсэн туслах хэрэгсэл, тохируулга шаардагдаж болох бөгөөд нийтэд хүртээмжтэй байх нийтлэг, түгээмэл шийдлийг тууштай баримтлан хэрэгжүүлсэнээр нэмэлт тохируулга, зохицуулалт тэр болгон хэрэглэх шаардлагагүй болно.

Түгээмэл загварт хашлагагүй налуу зам багтана. Тэргэнцэрээр зорчдог хүмүүс бусдын тусламжгүйгээр зам гарах боломжтой. Дугуйг тэргээр ачаа зөөвөрлөх тохиолдолд ашиглаж болно. Эцэг эхчүүд хүүхдийн тэрэг түрээд гудамж хөндлөн гарахад хялбар. Настай хүмүүсийн хөдөлгөөн удаан, дээр нь тэнцвэрээ амархан алдаж болзошгүй тул хашлагагүй налуу замаар уулзвар хөндлөн гарахад нь тохиромжтой. Хашлагагүй налуу зам нь өдөр тутмын амьдралын хэрэглээ болсон ба олон оронд хэрэгжих төлөвтэй байгаа. Энэ замыг бий болгоход түлхэц болсон анхдагч зорилго нь тэргэнцэрээр зорчдог хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зам хөндлөн гарахад зориулагдаж байв. Харин өнөөдрийг хүртэл олон хүнд ашиг тусаа өгсөн нь тодорхой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн өөр нэг зарчим нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хүртээмжтэй байх асуудал юм. Энэ нь “хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, тухайлбал мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангах”-д чиглэнэ. Нийтэд хүртээмжтэй байх ерөнхий зарчим нь хүрээлэн буй орчныг (онлайн орчныг оролцууна) хүртээмжтэй болгодог тул тухайлсан нэг хэрэгцээ, тусгай тохиолдол бүрт тааруулж зохицуулах шаардлагагүй болдог.

Түгээмэл загвар нь тухайн барилга байгууламж, түүн дотор явагдах үйл ажиллагаа, үйлчилгээний хүртээмжтэй байдал ашиглалт талаас нь харахыг шаарддаг. “Түгээмэл загвар” гэх ойлголтыг анх зөвхөн барилга байгууламжийн гадна дотор, шат, хонгил, зогсоол зэрэгт хамааруулж хэрэглэж байсан. Нийгэд хүртээмжтэй байх зарчмаар барилга байгууламжид хэн ч аль ч хэсэгт хүрэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл орцоор орох, бие засах, давхруудын хооронд шатаар явах, усан оргилуурт хүрэх, эд зүйлээ хадгалуулах, авах, аль ч дэлгүүрээр үйлчлүүлэх, ажил хэргээ явуулах боломжтой байна. Түүнчлэн барилга доторх дохиоллын систем нь хараагүй, дүлий иргэд хүрэхээр хийгдсэн байдаг.

Хүртээмжтэй байдлыг хангахын тулд санаачлагатай, урьдчилж тооцоолсон арга барил хамгийн үр дүнтэй. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгнийг ирэхээс өмнө саад бэрхшээлийг арилгаж, аливаа үүсч болзошгүй нөхцөл байдалд бэлтгэж хүн бүр хүрч ашиглах боломжтойгоор зохион байгуулахыг хэлнэ. Жишээ нь хэн нэгэнд зогсоол хадгалах, тээврийн хэрэгслийг хамгийн тохиромжтойгоор ашиглах байдлаар хийх, хаалгыг хялбар энгийнээр онгойлгох боломжтой байх, хаягийг дармалдсан том үсгээр, Брайлийн галигаар бичих, ариун цэврийн өрөөний тавиурыг ашиглахад төвөггүй болгох гэх мэт. Магадгүй энэ зорилгоор анги танхим, бизнесийн ба зөвлөгөө өгөх албадыг, мөн хурлын танхим, зоогийн газар, эмнэлэг зэргийг нэгдүгээр давхарт байрлуулах, эсвэл тэдгээрт цахилгаан шатаар хүрэх боломжтой газар байрлуулах шаардлагатай болно.

Түгээмэл загварыг анх хэрэглэж байснаасаа илүү өргөн хүрээнд хэрэглэх болсон. Уг зарчмыг компьютерийн техник хэрэгсэл, программ хангамж, мэдээлэл, үйлчилгээ, анги танхим, шүүх, цагдаа, жижиглэн худалдаа, бизнесийн бусад байгууллагуудад хэрэгжүүлдэг. Түгээмэл загварыг оюутан, сурагч элсүүлэх, шалгалт авах, хичээл заах, хэвлэмэл ба цахим хэлбэрийн материалыг танилцуулах, дадлагын ажлын болон сургалтын хөтөлбөр боловсруулахад хэрэглэж болно.

Түгээмэл загварын дагуу сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахдаа сургалтын олон төрлийн арга техникийг хэрэглэж, хүн бүр өөрийн суралцах чадвар, арга барилдаа тохируулах боломжтой байх зарчмыг баримтална. Түгээмэл зарчимд нийцсэн сургалтын хөтөлбөр нь зөвхөн агуулгын хувьд уян хатан байгаад зогсохгүй зорилго, арга хэлбэр, материал, үнэлгээндээ уян хатан зарчмаар ажиллахыг шаардана.

Түгээмэл зарчимд тулгуурласан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй холбогдох олон асуудлыг энэхүү гарын авлагад тусгалаа. Таны заадаг хичээлийн хөтөлбөр түгээмэл загварын дагуу хийгдээгүй ч та уг загварын зарим нэг элементүүдийг өөрийн хичээлд ашиглах бүрэн боломжтой (дараах шигтгээг харна уу). Эдгээр арга техникийг хэрэглэхэд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төдийгүй нийт оюутан суралцагчдад ач холбогдолтой. Эдгээр арга техникийг Гуравдугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Хүснэгт 1: Зааврыг бүх нийтээр хэрэглэх саналын загвар

- Зааврыг танилцуулахдаа олон арга хэрэглэх, жишээ нь: ямар нэг зүйлийг яаж хийж байгаагаа илэрхийлж ярилцах, харуулж үзүүлэх;
- Суралцагчдад танилцуулах хуудас болон нэмэлт мэдээлэл, тэмдэглэлийг өгөх;
- Суралцагчдын хийх зүйлсийг нь байнга дэс дараалалтай тодорхой чиглүүлж өгнө, жишээ нь: нэгдүгээрт бид нар үүнийг хийнэ, хоёрдугаарт нь бид нар үүнийг хийнэ, гуравдугаарт нь бид нар үүнийг хийнэ гэх мэт;
- Зааврыг энгийн үзэл баримтлал, үүрэг даалгавраас нь эхлэн барилгын тоосго өрж буй мэт илүү хүнд төвөгтэй загварыг ашиглана;
- Сургагч багш юу хийж байгааг ойлгон дагаж хийж чадаж байгааг суралцагчдаас үе үе батлан нягталж байх;
- Хэрэв боломжтой бол суралцагчдад сурсан мэдээллээ нэгтгэх, хадгалах, санах, дадлага хийх хангалттай цаг хугацааг гаргаж өгөх;
- Сургагч багш нь суралцагчдыг үнэлэхдээ уян хатан байх.

1.4.2 Тохирох хэрэглэгдэхүүн

Түгээмэл загвар, хүртээмж гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст учирч болох саад бэрхшээлийг урьдчилан арилгах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс гадна, бичиг үсэгт муу тайлагдсан, бусад онцлог хэрэгцээ шаардлагатай хүмүүст туслах ач холбогдолтой юм.

Нөгөө талаас тохирох хэрэглэгдэхүүн нь тухайн хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлж сургалтын болон ажлын орчныг тохируулахад ашиглагддаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн тодорхойлсоноор тохирох хэрэглэгдэхүүн гэдэг нь “тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсхүл үндэслэлгүй саад тогторыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийж өөрчилж засварлахыг хэлнэ.”

Сургалтын орчин нөхцөлд тохирох хэрэглэгдэхүүн гэж суралцагчдын онцлог хэрэгцээг хангахын тулд авах арга хэмжээ, арга хэрэгсэл, төхөөрөмжүүдээр хангахыг хэлнэ. Сургалтын байр, орчин нь анхнаасаа хүртээмжтэй байдлаар тоноглогдон зохион байгуулагдсан бол зөвхөн цөөн тооны нэмэлт өөрчлөлт шаардагдана. Гэсэн хэдий ч, арилгах шаардлагатай саад бэрхшээл нь тухайлсан онцгой хэрэгцээнд хамаатай, эсвэл нийтлэг шинжтэй эсэхээс үл хамааран дор дурдсан асуудлуудыг анхааралдаа авч харгалзан үзэх хэрэгтэй.

- Сурагчид сургалтын байр байшинд төвөггүй орж гарах боломжтой юу?
- Сурагчид анги танхим, дадлага ажил, сургалтын байранд төвөггүйгээр нааш цааш явж чадаж байна уу?
- Анги танхим, дадлага ажлын байранд байгаа эд зүйлсийг чөлөөтэй ашиглаж байгаа эсэх?
- Сургалтын материал, дадлагын хичээл дээр үзүүлж байгаа зүйлсийг бүрэн ойлгож, авч чадаж байна уу?
- Бүлгээр ажиллах үед бусадтай хамтарч ажиллаж чадаж байна уу?
- Дадлагын ажлаа бусдын адил хийж чадаж байна уу?
- Мэдлэг чадвар эзэмшсэн байдлаа илэрхийлэхдээ (шалгалт, үнэлгээний үеэр) бусад суралцагчдын адил харуулж чадаж байна уу?
- Шалгалтын үед ямар дэмжлэг хэрэгтэй вэ?

Дээр дурдсан, түгээмэл загварыг нэвтрүүлж хүртээмжтэй байдлыг хангах явцдаа гарцан дээр хашлагагүй налуу зам барих, орцны хаалгыг өргөн болгох, ариун цэврийн өрөөг хэрэглэхэд илүү дөхөмтэй болгох зэргээр хүрээлэн буй орчинд байгаа зарим саад бэрхшээлийг арилгах боломжтой байдаг. Түүнчлэн суралцагчийн хувьд урьдчилан харж тооцоолоогүй саад бэрхшээл анги танхимд тулгарч болдог. Жишээлбэл ажлын өрөөний ширээнүүдийн өндөр нам, эгнээ хоорондын зай, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмжийн байршил, ашиглах хэлбэр (зогсоод хоёр гараараа ажиллах тохиодолд) зэрэг нь тухайн суралцагчийн хувьд бэрхшээлтэй байж болно.

Сургалтын материал, сургалтын арга хэлбэртэй холбоотой саад бэрхшээлийг хүн тус бүрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж арилгахыг хичээх хэрэгтэй. Хэрэв хичээлийг үзүүлж харуулах байдлаар явуулах бол харааны бэрхшээлтэй хүмүүст зориулж нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай. Ийм хүмүүст том үсгээр бичсэн материал бэлтгэж тараах, тэмдэглэл хийх хэрэгслээр хангах, мөн дүрс бичлэг, зураг зэргийг ашиглахдаа аман тайлбар хийж байх хэрэгтэй юм. Ямар хэрэгсэл, дэмжлэг шаардлагатай байгааг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй уулзахаасаа өмнө тодорхойлох боломжгүй учраас тухайн хүмүүстэй уулзаж сургалтыг ямар байдлаар явуулж болох, ямар дэмжлэг туслалцаа хэрэгтэй байгаа талаар ярилцсаны дараа шийдвэр гаргах хэрэгтэй.

Сонсгол муутай буюу дүлий хүмүүс, харааны бэрхшээлтэй, хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагч нь тэдний суралцах үйл явцад шаардлагатай ямар нэмэлт хэрэгсэл, дэмжлэг сургалтад шаардагдах нэмэлт арга хэмжээг тодорхойлж шийдвэр гаргахад танд хамгийн бодитой мэдээлэл өгнө. Гэхдээ заримдаа тодорхой хариулт өгөхөд айдастай эсвэл бэлтгэлгүй байж болно. Энэ тохиолдолд дараахь байдлаар ажиллавал тэд илүү нээлттэй, итгэлтэй хамтран ажиллах боломжтой.

- Сургуулийн барилга байгууламжтай танилцуулах
- Анги танхим, дадлагын өрөөг танилцуулах
- Хичээл ямар байдлаар явагддаг, суралцагч ямар байдлаар оролцох ёстойг танилцуулах.

Анги танхимаас дадлагын байр, сургуулиас ажлын байр луу шилжих зэрэг сургалтын орчин өөрчлөгдөхөд сургалтын шинэ орчинд өмнөхтэй адил зохицуулалтууд хийгдсэн байх шаардлагатайг анхаарах хэрэгтэй. Тухайлбал зочид буудалд дадлага хийж байгаа хөгжлийн бэрхшээлтэй оюутан ослын дохиолол, эсвэл төв байрны дуудлагыг чичиргээ бүхий тусгай холбооны хэрэгслээр дамжуулан хүлээн авч болно. Зарим газарт дүлий хүмүүст зориулан анивчдаг гэрлэн дохиоллыг ашигладаг.

Шалгалт үнэлгээний явцад тулгарах саад бэрхшээлийг арилгахдаа хүн тус бүрийн онцлогийг харгалзах хэрэгтэй. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй оюутанд шалгалт авах журам зарчимаа урьдчилан танилцуулснаар шалгалтанд хэрхэн бэлтгэх, өөрсдөө юу хийх шаардлагатайг ойлгуулах бөгөөд таны зүгээс шалгалтын үр дүнг сайжруулахад ямар арга хэмжээ авах хэрэгтэйг тодоройлоход дөхөмтэй байдаг.

1.4.3 Хөгжлийн бэрхшээлийн тухай мэдлэг олгох сургалт

Бусдын сөрөг хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хамгийн том бэрхшээл болж байдаг бөгөөд үүнээсээ болж хууль тогтоомж, хүртээмж өөр бусад асуудлаа шийдвэрлэхэд нь сөрөг нөлөө үзүүлж байдаг. Тийм учраас энэхүү сөрөг хандлагыг өөрчлөх гол арга зам бол хөгжлийн бэрхшээл, адил тэгш байх зарчмын талаарх ойлголт мэдлэгийг дэлгэрүүлэх явдал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай мэдлэгтэй байх ёстой хүмүүст энэ тухай мэдээллийг нэн тэргүүнд өгөхийг хичээгээрэй. Өөрийн ажилчдаа, ажил олгогчдыг, орон нутгийнхаа нөлөө бүхий хүмүүсийг сургаж болно. Эдгээр хүмүүст илүү итгэл үнэмшил төрүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дотроос мэргэжил боловсролтой, амжилтанд хүрсэн хүмүүсийг сургах үйл явцад татан оролцуулж тэдний хүрсэн амжилтанд бусад нь ч бас хүрч болох юм гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Хүний эрхийн талаас нь харвал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэдэнтэй холбоотой бүхий л асуудалд шууд ба шууд бусаар оролцуулж байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургалтанд хамруулах нь тэдний оролцоог хангаж байгааг харуулах тод жишээ юм.

Ихэнх оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах эрх зүйн орчин бүрдсэн байдаг ба үүнийгээ сургалтын хөтөлбөртөө нэвтрүүлэх нь зүйтэй. Хууль эрх зүйн ийм орчинд мэргэжлийн боловсролын сургуулиуд нь нийгмийн гишүүн бүрт хүрч үйлчлэх үүргийг зорилтоо болгон ажиллах хэрэгтэй. Хэрэв та нийгмийн нийт хүн амд хандсан, эсвэл ажил олгогчийг түлхүү татан оролцуулах зорилготой бол тэдэнтэй хамтран ажиллаж буй жишээ гаргаж танилцуулах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй олон хүн ядуу амьдарч байна. Та энэ хүмүүсийг өнөөдөр эрэлттэй байгаа мэргэжил эзэмшүүлж, хөдөлмөр эрхлэхэд нь тусалснаараа орон нутгийн эдийн засгийг дэмжиж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэтгэхэд гэр бүл ба нийгмийн зүгээс гарах зардлыг хэмнэж, нөөц бололцоог өөр чиглэлээр ашиглах боломжийг олгож байна. Бизнесийн байгууллагууд ур чадвартай ажилтантай болохын зэрэгцээ, үйлчлүүлэгчийнхээ хүрээг өргөжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хууль тогтоомжийг биелүүлэх, тогтоосон квотыг хангах боломж нэмэгдэх болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүлийн хамт мэдлэг олгох сургалтад хамруулах хэрэгтэй байж болох юм. Дээр тэмдэглэснээр хөгжлийн бэрхшээлтэй зарим хүмүүс сургалтын байгууллагуудад тэднийг үнэхээр хүлээн авах эсэхэд итгэлгүй байхаас гадна зарим эцэг эхчүүд, гэр бүлийн гишүүд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мэргэжлийн сургалтанд хамрагдахад нь итгэлгүй эргэлзэж байдаг.

Сургалтын байгууллагын багш, ажилтнуудад байнгын тусгай сургалт шаардлагатай бөгөөд юуны өмнө боломж бололцооны талаар ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх хэрэгтэй. Дараа нь ийм сургалтыг гүнзгийрүүлж заах арга, хөгжлийн бэрхшээлийн ёс журамд сургах ба зохицуулалт хийх зэрэг энэхүү гарын авлагад тусгалаа олсон бусад асуудлыг хамруулах ёстой.

Жишээ: Танзани улсын Багва Фолк Хөгжлийн Коллеж \Bagwa Folk Development College in Tanzania\ -д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэргэжлийн сургалтанд хамруулж улмаар сургалт ба ойлголт төлөвшүүлэх нь амжилтын түлхүүр болдог гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Сургагч багш нар нь оролцоог хангах талаар мэдлэгтэй болж, Брайлийн галиг, дохионы хэлд суралцаж, хөгжлийн бэрхшээлийн сэтгэл зүй нийгмийн ба бусад асуудлаар зөвлөгөө өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм, эдийн засгийн амьдралын бүх салбарт идэвхтэй оролцуулах ур чадвар эзэмшсэн байна. Орон нутгийн төрийн бус байгууллагын ажилтан, мэргэжилтнүүд хоёр долоо хоногийн сургалтад хамрагдаад, дараа нь ялгаварлан гадуурхах ба адил тэгш байдал, боловсролын ач холбогдол, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих талаар олон нийтийн анхаарлыг татах зорилгоор бусад сургуулийн ажилтан, оюутан, иргэдтэй ажиллаж эхэлжээ. Өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ сургуульд суралцах, ажил хийхийг дэмжихгүй, эсэргүүцэж байсан гэр бүлийн бусад гишүүд дээрх хэлэлцүүлгийн үр дүнд бодол хандлагаа өөрчилж хүүхэд, эхнэр, нөхөрөө сурч ажиллахыг зөвшөөрөх болсон байна.

1.5 Багш, удирдах ажилтнуудын анхааралд

Оролцоог хангах тухай үндсэн ойлголтыг сургагч багш, удирдах ажилтнууд авсан байх шаардлагатай. Оролцооны зарчим нь зөвхөн анги танхимаар хязгаарлагдахгүй ба сургалтын байгууллагын хүрээнд, цаашлаад магадгүй сургалтын нийт тогтолцоо, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай.

Сургуулийн захиргааны зүгээс мэдлэг ойлголтыг төлөвшүүлэх сургалтанд анхаарлаа хандуулах нь зүйтэй. Тухайлбал хэнд ямар сургалт шаардлагатай, сургалтыг ямар байдлаар явуулах, хэн зохион байгуулах, ямар өртөг зардалтай байх вэ гэх мэт. Мэргэжлийн сургалтын тогтолцоонд оролцоог хангахад төрийн үүрэг оролцоо их. Эсвэл сургуулийн захиргаа дангаар гүйцэтгэж ч болно. Хамгийн гол нь орхигдуулахгүй байх нь чухал. Сургагч багш ажилчид энэхүү гарын авлагатай бүрэн танилцсанаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах бүрэн мэдлэгтэй болно.

Удирдах ажилтнууд сургуулийнхаа хүртээмжийг нэмэгдүүлэх түүнтэй холбоотой саад бэрхшээлийг арилгахад шаардагдах хөрөнгө төсвийг шийдвэрлэж байх үүрэгтэй. Сургуулийн захиргаанаас хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, анги танхимд зохих өөрчлөлт, зохицуулалт хийхийн тулд тусгайлан төсөвтөө тусгах шаардлагатай. Багш, удирдах ажилтнууд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, анги танхим, дадлагын байр, бусад газруудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд ямар бэрхшээл учруулж болохыг олж тогтоож, түүнийг арилгахад шаардлагатай арга хэмжээг авна. Нэг ёсны хөрөнгийн үзлэг, бүртгэл тооллого, дүн шинжилгээг бүх ажлаа төлөвлөхөөс өмнө гүйцэтгэх нь чухал байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах байгууллагуудын ажилтан, мэргэжилтнүүд зохих ёсоор бэлтгэгдсэн эсэхийг судалгааныхаа явцад тодорхойлох хэрэгтэй.

Эдгээр саад бэрхшээлийг арилгах арга хэлбэр, явц нь танай үйл ажиллагаа сургалтын тогтолцоо, бодлогын чиглэлээс хамааралтай. Түүнчлэн санхүүгийн боломж бололцоо, багш нарын ур чадвараас хамаараад зарим нэг зүйлийг бие даан хэрэгжүүлж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, орон нутаг, иргэний нийгмийн байгууллагуудын тусламж дэмжлэг ихээхэн чухал болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Боловсролын систем орон нутгийн зүгээс үзүүлэх дэмжлэгээс үл хамараан сургуулийн захиргаа өөрийн нөөц бололцоог ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан сургуулийн анги танхимд өөрчлөлт хийх нь томоохон алхам юм.

1.6 Дүгнэлт

Энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай товч мэдээлэл, тэдний оролцоог хангах зарим арга замыг танилцууллаа. Энэхүү мэдээлэл нь мэргэжлийн сургалтыг сайжруулахад чиглэсэн цаашдын хэлэлцүүлэг, авах арга хэмжээний үндэс суурь болно гэдэгт найдаж байна. Энэ бүлэгт танилцуулсан зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Гуравдугаар бүлэгт тодорхой тайлбарласан болно. Эдгээр зарчмуудыг ойлгосноороо дараа дараагийн ажлаа төлөвлөхөд тань тус дэм болох бөгөөд төлөвлөлтийн асуудлыг дараагийн бүлэгт орууллаа.



ХОЁРДУГААР БҮЛЭГ:

ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

2.1 Бүлгийн зорилго

Ажлаа сайн төлөвлөх нь амжилт гаргахын эхлэл. Удирдах ажилтан бүр төлөвлөгөөний ач холбогдлыг ойлгож, багш бүр заах хичээлээ урьдчилан төлөвлөдөг.

Энэ бүлэгт оролцоог хангахын тулд хэрхэн төлөвлөх тухай авч үзнэ. Төлөвлөгөөнд дор дурдсан асуудлыг тусгана:

- Хүсэл эрмэлзэл, хэтийн зорилт
- Мэдээлэл цуглуулах
- Зорилтоо тодорхойлох
- Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Төлөвлөгөөнд үнэлгээ өгөх

2.2 Хүсэл эрмэлзэл, хэтийн зорилт

2.2.1 Үндсэн хүчин зүйлс

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэргэжлийн сургалтанд хамруулахад шаардагдах хүчин зүйлсийн дотор бодлого, хууль тогтоомж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажил хайх, сургуульд суралцах, бизнесийн байгууллагууд мэргэжлийн ур чадвартай ажиллах хүч хайх, багш удирдах ажилтнууд зөв зүйтэй зүйл хийхийг эрмэлзэх зэргээс гадна бусад олон тооны хүчин зүйлс танай сургалтын төв, хөтөлбөр, сургалтын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлийн оролцоог түлхүү хөгжүүлэх шийдвэр гаргахад нөлөөлж болно.

Жишээ: Танзани улсын 2004 оны Хөгжлийн Бэрхшээлийн Үндэсний Төлөвлөгөө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн сургалтын төвүүдэд суралцахад илүү дөхөмтэй болгох чиглэлд Засгийн газрыг идэвхжүүлэх түлхэц болж өгсөн байна. Ирак улсад ОУХБ-НҮБХХ-аас орон нутагт түшиглэсэн нөхөн сэргээх төсөл хэрэгжүүлснээр орон нутгийн зарим мэргэжлийн сургалтын төвүүд 1998 онтой харьцуулахад оролцоог илүү дэмжиж эхэлсэн ба уг аргыг Засгийн газрын бусад байгууллагууд ч нэвтрүүлсэн байна.

Сэдэл, түлхэц болж буй хүчин зүйлээс үл хамаарч оролцоог хөгжүүлэх зорилго, эрмэлзэл нь зохион байгуулалтын эсвэл бүр илүү үр дүнтэй байх нийгэм орон нутгийн шинжтэй ба эсвэл эрх зүйн үндэстэй байвал илүү өндөр амжилтанд хүрдэг. Зохион байгуулалтын үүрэг хариуцлага чухал байдаг. Учир нь суралцагчид мэргэжлийн

сургалтын хөтөлбөрт зөвхөн нэг курс сонгох нь ховор, гол төлөв хэд хэдийг сонгож суралцдаг. Хэрэв нэг, хоёр курс оролцооны зарчмыг баримталж байхад бусад курсүүдэд энэ зарчим хангагдаагүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдад нээлттэй байх бололцоог бүрэн ашиглаж чадахгүйд хүрдэг. Нийгэм хамт олны буюу эрх зүйн үүрэг хариуцлага нь хүний эрхийн ба практикийн гэсэн хоёр талын ач холбогдол, үр нөлөөтэй байдаг. Практик ач холбогдлын үүднээс оролцоо бүхий мэргэжлийн сургалтын арга хэмжээг амжилт үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн болон Засгийн газрын зүгээс бүх төрлийн нөөцийн, экспертизийн дэмжлэг туслалцаа шаардагдаж болно. Хүний эрхийн үүднээс эрх зүйн үүрэг хариуцлага тодорхой бол Засгийн газрын зүгээс үр дүнг баталгаажуулж, гүйцэтгэлийн хяналт тавьж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс санал хүсэлтээ гаргах тогтолцоог хөгжүүлэх магадлалтай.

Оролцоог хөгжүүлэх зорилгоо хэрэгжүүлэхдээ бодлого, хууль тогтоомжийг судалж хэн таны нэгэн адил зорилготой байгааг тодорхойлох нь зүйтэй. Хэрэв хүн бүрийн сонирхол нэгдэж байвал хурдан хугацаанд ахиц дэвшил гарах магадлал өндөр байна. Тодорхой нэгэн суралцагчийг зохицуулах зорилготой багш байсан ч та өөртөө хэрэгтэй арга хэрэгсэл, санаануудыг энэхүү гарын авлагаас олж болно.

2.2.2 Үүрэг хариуцлагыг бүрдүүлэх

Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

Зарим хэсэг нь үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөхгүй байх нөхцөлд боловсролыг сайжруулж мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай болно. Багш, удирдах ажилтны хувьд та сургалт зохион байгуулахдаа түншүүдээсээ, тухайлбал Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагаас, орон нутгийн бусад мэргэжилтнүүдээс тусламж хүсэж болно. Мэдлэг ойлголт олгох сургалтын талаар Нэгдүгээр Бүлэгт авч үзсэн. Таныг сонсогчид ямар бүлгийг илүү үүрэг хариуцлагатай болгохыг зорьж байгаагаас хамаарна. Ажилтнууд, хамтран ажиллагчид, ажил олгогчид, орон нутгийн хүн ам, эцэг эхчүүд буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө байна. Анхнаасаа оролцоо бүхий мэргэжлийн сургалтыг зорилгоо болгосон бүлгийг өргөжүүлснээр та зорилтоо тодорхойлж төлөвлөгөө зохиох, түүнийг хэрэгжүүлээд үнэлж дүгнэхэд тань туслах хүмүүсийн баг бүрдүүлнэ.

Хэтийн зорилгоо тодорхойлох

Үүрэг хариуцлагаа нэмэгдүүлэх нэг арга зам нь хэтийн зорилгоо тодорхойлох арга юм. Хэтийн зорилго гэж ирээдүйд танай байгууллага, хөтөлбөр ба тогтолцоо ямар байхаар тодорхойлсныг хэлнэ. Төлөвлөлтийн аль түвшинд байхаас хамаарахгүйгээр хэтийн зорилго тодорхой байвал зорилт, үйл ажиллагаагаа нарийвчлан боловсруулах ажилд зүг чигийг заах ач холбогдолтой. Хэтийн зорилт нь хүмүүсийг нэгтгэж үүрэг хариуцлагатай байлгах нэг арга хэлбэр болдог. Хэтийн зорилгоо зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан мэргэжлийн ур чадварын сургалт явуулж хүн бүрийг хөдөлмөр

эрхэлдэг болгох гэж тодорхойлсон байна. Энэ зорилго нь хэтийн хугацаанд танай байгууллага, хөтөлбөрийн эрмэлзэж хүрэх түвшинг илэрхийлнэ.

Хүснэгт 2: Хөгжлийн бэрхшээлийн оролцоо бүхий мэргэжлийн сургалтын дүр төрх ямар байх вэ?

Хөгжлийн бэрхшээлийн оролцоо бүхий мэргэжлийн сургалтын тогтолцоо дараах үндсэн бүрэлдэхүүнтэй байна:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ба энгийн иргэдийг нэгдсэн нэг тогтолцоонд хамруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэр тогтолцоонд бүх талаар хамруулах. Тухайлбал: хөтөлбөр боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс багш, сургагч элсүүлэх гм;
- Саадгүй орчин – бодит биет саад, сургалтын нийгмийн ба сэтгэл зүйн хувьд учрах бүхий л саад бэрхшээлийг арилгах орчин. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртэмжтэй байдлаар бодож дэд бүтцийн шийдэл, барилгын ажлыг гүйцэтгэх, одоогийн дэд бүтэцдээ шаардлагатай зохицуулалт хийх. Тохируулга зохицуулалтууд хийгдэж тээврийн хэрэгсэл бусад системийг хараагүй, дүлий хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд хүртэмжтэй болгох;
- Заах аргыг батлах, сургалтын материалаар хангаж бусад зохицуулалтыг хээрэгжүүлэх;
- Ажил мэргэжлийн чиг баримжааг хөдөлмөрийн бэрхшээлтэй хүмүүс зохистой сонголтоо хийхэд нь дөхөмтэй байхаар хэрэгжүүлэх. Үүнд суралцагчдын мэргэжлийн ур чадварын үнэлгээг нарийвчилж хувь хүний онцлогийг илүү харгалзах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхахгүй байх идэвхтэй зарчмыг үндэс болгосон удирдамж орно;
- Зах зээлийн агуулга бүхий чанартай сургалт явуулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ба, ажил олгогчдыг идэвхтэй татан оролцуулах замаар мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд бүрэн нийцүүлэх;
- Эерэг хандлагыг төлөвшүүлэх нь чухал бөгөөд - үүнд багш, суралцагчдыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эерэг, найрсаг, дэмжлэг тусалцаа бүхий уур амьсгал бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хөгжлийн бэрхшээлгүй нийт суралцагчдад өөрсдийн хэрэгцээтэй мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх боломжийг хангахад чиглэсэн заах арга техник эзэмшиж буй ажилтнуудыг багшлах

боловсон хүчин, хөгжлийн бэрхшээлийн мэргэжилтнүүдийг дэмжих;

- Бүх суралцагчдын хэрэгцээг хангах нөөц боломжтой байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах зорилгоор зохих ёсоор бэлтгэх. Үүнд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ерөнхий боловсролын сургуулиуд болон мэргэжлийн сургалт, боловсролын тогтолцооны уялдаа холбоог сайжруулах асуудал хамаарна.

Жишээ нь хэтийн зорилтыг энгийн байдлаар тодорхойлж болно. Гурван жилийн дараа мэргэжлийн сургалт хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст нээлттэй, хүртэмжтэй болгож тэдгээрийг сурч боловсроход зориулсан зохих ёсны хангамж, зохицуулалт, дэмжлэгээр хангана.

Тайландын Бангкок хотноо экспертүүдийн баг уулзаж оролцоонд суурилсан мэргэжлийн сургалтын тогтолцооны тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж түүний тодорхой шинж чанарт авч үзсэн байна. Эдгээр шинж чанаруудад зах зээлд түшиглэсэн сургалт, ажил олгогчтой түншлэх зэрэг хамаарна. Үүний адилаар та бүгд өөрийн хэтийн зорилтоо тодорхойлохдоо оролцоонд суурилсан мэргэжлийн сургалтын тогтолцооны хэтийн шинж чанарыг нарийвчлан тодорхойлж болно.

2.3 Мэдээлэл цуглуулах

Төлөвлөгөөний аль үе шатанд хэрэглэхээс шалтгаалж ямар төрлийн мэдээлэл шаардагдах нь тодорхой болно. Үндэсний түвшний стратегийн төлөвлөлт ба байгууллагын төлөвлөлт хоёр хоорондоо ялгаатай байна. Энэхүү гарын авлага нь гол төлөв багш, удирдах ажилтнуудад зориулсан тул шаардагдах мэдээллээр хангагдсан байх ёстой. Үүнд: төсөв, нэмэлт санхүүжилт, орон нутгийн санхүүгийн эх үүсвэр, ерөнхий зорилт, хэрэгцээ шаардлага гм. Зарим тохиолдолд оролцоонд суурилсан мэргэжлийн сургалтын зарчимд тулгуурлан мэдээллийг шинэчлэх шаардлагатай болдог. Мөн төлөвлөгөөнд нэмэлт асуудлууд тусгах шаардлага гардаг боловч энэ тухай дараа хэлэлцэх болно. Танай хөтөлбөр, сургалтанд хамрагдах сонирхолтой суралцагчдын тухай мэдээлэл хэрэгтэй болно.

2.3.1 Суралцагчдын талаарх мэдээлэл ба орчин нөхцөл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг бүрэн хангахын тулд суралцагчдын талаар болон сургалтын орчин нөхцөл, хүчин чадлын талаар дор дурдсан мэдээлэл хэрэгтэй болно.

- Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүн оролцох сонголт хийх вэ?

- Хүртээмжтэй байдлыг хангахын тулд ямар арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай вэ?
- Элсэх хүсэлтэй хүмүүс бэлтгэлтэй байгаа юу? Хэрэв тийм биш бол ямар тусламж дэмжлэг хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боломжит тоо

Оролцоонд суурилсан мэргэжлийн сургалтыг хөгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүн оролцохыг сонирхох вэ гэдэг хамгийн чухал мэдээлэл юм. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй зөвхөн нэг хүн танай сургалтын хөтөлбөрийг сонговол нэг хэрэг. Харин хөгжлийн бэрхшээлтэй 250 хүн танай мэргэжлийн сургалтын хөтөлбөрт оролцох сонирхолтой байвал огт өөр асуудал юм. Хэрэв зарим орнуудад байдаг туршлагын дагуу квот тогтоох шалгуурууд байдаг бол квотыг хэрэгжүүлэхэд бэлтгэх хэрэгтэй.

Орчин нөхцлийг хүртээмжтэй болгох

Нийтлэг, түгээмэл шийдлийн зарчмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн болон жирийн иргэд танай барилга, байгууламжид хүрэх, нэвтрэх, доторх орон зайг ашиглах ба тэнд зохиогдох аливаа арга хэмжээ, үйл ажиллагааны үр шимийг хүртэх боломжтой байх ёстой. Суралцагчдын хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрийг урьдчилан мэдсэн тохиолдолд та өөрийн байгууллага дотроо, тоног төхөөрөмж, сургалтын арга барил, материалдаа ямар өөрчлөлт хийх шаардлагатайг тодорхойлох боломжтой.

Нэмэлт тусламж үйлчилгээ

Та ямар төрлийн нэмэлт хэрэгслэлийг суурилуулсан байх шаардлагатай вэ? Мэдээж, шийдвэр гаргахдаа тухайн хүнтэй ярилцаж хэрэгцээг нь тодорхойлох хэрэгтэй. Гэхдээ зарим асуудлаар тухайлбал сонсголын бэрхшээлтэй хүмүүс элсэж суралцах тухай мэдээлэлтэй байгаа бол дохионы хэлмэрч ажилд авах, зардлын эх үүсвэрийг судлах ба бусад ямар тусламж үйлчилгээ шаардлагатай болохыг урьдчилан судалж болно. Хэрэв компьютерийн мэргэжлээр сургалт зохион байгуулахаар төлөвлөж байгаа бол дэлгэц унших программ болон бусад төрлийн тусламж үйлчилгээг судалж болох юм. Тухайлбал тэмдэглэл хөтлөгч хэрэгтэй болохыг мэдэж байгаа бол өөрийн хамтран ажиллагчид, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, сонирхлын бүлгүүдэд хандаж сайн дурын туслагчдыг хайж судлах ажлыг эхэлж болно.

Бэлэн байдал

Танай сургалтын хөтөлбөрт оролцохыг сонирхсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс элсэлтийн шаардлага хангаж байна уу? Зарим хүмүүс хангахгүй байгаа бол тэдэнд зориулж дахин шалгалтад бэлтгэх нэмэлт курс зохион байгуулах эсэхээ та шийдэх хэрэгтэй болно.

Бэлтгэл курсийг олон арга хэлбэрээр зохион байгуулж болдог. Сонгомол нэг арга хэлбэр гэж байхгүй. Суралцагчдад дутагдаж байгаа чадварыг эзэмшүүлэхдээ сургалт эхлэхээс өмнө буюу сургалтын үеэр зэрэгцүүлэн хийж болно.

Суралцагчдын боломжит тоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл ба ямар дэмжлэг, үйлчилгээ шаардагдах, бэлэн байдал зэрэг мэдээллийг цуглуулах бөгөөд энэ нь – таны төлөвлөгөөний хүрээ, зорилт, хэрэгжилт зэрэгт шууд нөлөөлдөг.

2.3.2 Бусад мэдээлэл

SWOT шинжилгээ

SWOT шинжилгээгээр эхэлдэг төлөвлөлтийн арга танд танил байх. Энэ аргын дагуу төлөвлөлтийн үйл явцад давуу тал, сул тал, нөөц бололцоог тодорхойлох шаардлагатай байдаг. Жишээ нь давуу талыг гадаад, дотоод гэж хувааж болох ба оролцоо бүхий мэргэжлийн сургалтын тогтолцоо, квот үүнд багтана, харин хүртээмжгүй, саадтай дэд бүтэц, төхөөрөмжүүд сул талыг илэрхийлнэ. UNCRPD-тэй танай улс нэгдсэнээр хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг сайжирсан байдал давуу талд орно. Харин эдийн засгийн хямралын улмаас төсөв хөрөнгийн дутагдалтай байвал тэр нь сул талын жишээ болох юм. Энэ аргыг мэддэг бол та төлөвлөлтөндөө хэрэглэж болно. Иж бүрэн SWOT шинжилгээг ашиглахгүй тохиолдолд өөрийн байгууллага, орон нутгийн нөөц бололцоог судалж төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй.

Оролцооны зарчмыг хэрэгжүүлэх багш, ажилтнуудын чадавх

Танай сургалтын төвийн ажилтнууд оролцооны талаар ямар санал бодолтой байгааг судалж тодорхойлох нь төлөвлөлтийн нэг хэсэг юм. Тэд юу мэдэж байгаа вэ? Тэд юу гэж бодож байгаа вэ? Тэд хэрхэн туслахыг хүсч байгаа вэ? Хэн нэг нь хөгжлийн бэрхшээлийн талаар туршлагатай эсэх? Мэдээлэл авахын тулд албан ёсны судалгаа явуулах эсвэл холбогдох ажилтнуудад энэ гарын авлагыг хувийг өгөөд цаашид хэрхэн ажиллах саналтай байгаа, оролцооны зарчмыг хэрэгжүүлэх үйл явцад хүн бүр ямар үүрэгтэй оролцохыг ярилцах шаардлагатай. Аль ч аргыг хэрэглэсэн оролцооны зарчмыг хэрэгжүүлэхэд багш ажилтнуудын бэлэн байдлыг хангах арга хэмжээг төлөвлөх хэрэгтэй юм.

Орон нутгийн нөөц бололцоо

Мэргэжлийн сургалтын байгууллага, орон нутгийн хэмжээнд тоног төхөөрөмж, программ хангамж, экспертиз, бусад дэмжлэгийг хаанаас авч болохыг судлах хэрэгтэй.

Жишээ нь мужаан хүн налуу шат хийх, эсвэл ажлын ширээг намсгахад саналаараа ажиллаж болно. Ажил олгогчийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сурч байгаа мэргэжлийн ур чадвараа сайжруулахад нь тусалж дадлагажих боломж олгох саналтай байх. Компаниуд хараагүй хүмүүст зориулсан дэлгэц унших программаар хангаж дэмжлэг үзүүлэх хүсэлтэй байж болно. Сайн дурынхны байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай бол анги танхимд тэмдэглэл хийхэд нь эсвэл өөр хэлбэрээр мэргэжлийн туслалцаа үзүүлэх сонирхолтой байж болох

юм. Ингэж хаана ямар тоног төхөөрөмж, программ, мэргэжлийн дэмжлэг байгааг тодорхойлсон нөхцөлд та өөрийн төлөвлөгөө тооцоондоо тусгах боломжтой болно. Ийм байдлаар оролцооны зарчмыг дэмжих мэдлэг ойлголтыг бий болгоно. Энэ чиглэлд та ганцаараа зүтгэх хэрэггүй учир нь туслах хүсэл сонирхолтой байгууллага, хүмүүс олон байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө бүрэн мэдлэг туршлагатай байдаг. Тухайлбал Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Байгууллага \ХБХБ\ энэ чиглэлээр арвин туршлагатай. Эдгээр байгууллагууд нь өөрсдийн гишүүдээ нийгмийн амьдралд аль болох бүрэн оролцох, хүний эрхийг хамгаалах, хүртээмжтэй нөхцөл, үйлчилгээ хангамж бүрдүүлэх чиглэлээр хууль тогтоомж, бодлого зохицуулалтыг боловсронгуй болгоход голлон анхаарч ажилладаг. Түүнчлэн зохистой хангамж, үйлчилгээ хүргэх замаар хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх тухай сургалт, экспертийн туслалцаа үзүүлж, гишүүддээ ажил олох, амьдрах байртай болох, тээврийн хэрэгсэлтэй болоход нь туслах, түүнчлэн нийгэмшихэд нь тусалдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилдэг төрийн бус байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх экспертийн бөгөөд дэмжих арга хэрэгслийн сайн эх үүсвэр болдог. Зарим орон нутагт хараагүй иргэдийн байгууллагууд сургалтын байгууллагуудад тоног төхөөрөмжөө ашиглуулах сонирхолтой байдаг. Шаардлагатай үед брайль галигийн хэвлэх машин санал болгож хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад аль болох бүрэн, үр дүнтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх хүсэлтэй байдаг.

Жишээ нь Фижи улсад хараагүй оюутнууд ердийн сургууль, сургалтын байгууллагад элссэн тохиолдолд хараагүй оюутнуудад зориулж худалдан авах шаардлагатай тоног төхөөрөмж, технологи, программ хангамж бусад зохицуулалтын асуудлаар Фижигийн Хараагүй Иргэдийн Нийгэмлэгээс зөвлөгөө өгөх, оюутнуудад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг санал болгосон байна.

2.4 Зорилтоо тодорхойлох

Зорилт гэж таны хийхийг хүсч байгаа зүйлийн тодорхойлолт бөгөөд төлөвлөлтийн явцыг чиглүүлж өгдөг.

- Зорилтуудын жишээ:
- Таван жилийн хугацаанд байгууллагын сургалт үйл ажиллагааг оролцооны зарчимд тулгуурлан зохион байгуулна.
- Дараагийн гурван жилд хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийг албан бус сургалтад хамруулах.
- Дараагийн хоёр жилд зах зээлд эрэлт хэрэгцээтэй таван мэргэжлээр сургалтыг оролцооны зарчимд нийцүүлэн зохион байгуулах.
- Хөгжлийн бэрхшээлтэй 10 суралцагчийг мэргэжлийн сургалтын хөтөлбөрт хамруулж цаашдын сургалтын үе шатанд нь шаардагдах дэмжлэг туслалцаа үзүүлэх.

- Дараагийн гурван жилд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эзлэх ёстой 5 хувийн квотыг хангах.
- Хөдөлгөөний бэрхшээлтэй 10 хүнийг энэ жилийн сургалтад хамруулах.

Зорилт тодорхойлох нь стратегийн ба улс төрийн ач холбогдолтой үйл явц юм. Хуримтлуулсан мэдээллийг боловсруулах, зорилтоо тодорхойлох, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй зөвлөх багийг өөрийн байгууллага, орон нутгийн төлөөллийн оролцоотойгоор байгуулан ажиллуулж болно.

Мэдээлэл хуримтлуулж боловсруулах явцад судалж ойлгосон дүгнэлтүүд нь зорилтоо тодорхойлоход тань үндэс суурь болох ёстой. Танай мэргэжлийн сургалтын хөтөлбөрт оролцох сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо их байгаад нөөц бололцоо тань хангалттай бол зорилгоо өргөн цар хүрээтэйгээр дэвшүүлж болно. Хэрэв хүний тоо их боловч нөөц боломж хангалтгүй бол дутагдах нөөц бололцоог хайж олоход илүү цаг хугацаа зарцуулахаар төлөвлөх, юмуу зорилтын цар хүрээгээ багасгаж болно. Өргөн цар хүрээтэй томоохон зорилт дэвшүүлэх нь төлөвлөж хэрэгжүүлэх илүү их хугацаа шаардагдаж улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн сургалтад хамрагдах явдал удаширч болох талтай. Зорилтоо бага түвшинд тогтоосон нөхцөлд төлөвлөлт ба хэрэгжилтийн үйл явцад бага хугацаа шаардагдаж амжилт, үр дүнгээ эрт хангаж улмаар оролцооны зарчмыг дэмжих хандлага ажилтнуудын дунд, орон нутгийн хэмжээнд илүү өргөжих үндэс суурь тавигдана.

Таны зорилтууд хэмжигдэхүйц байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангасан ангиудын тоо, эсвэл тодорхой хугацаанд элсүүлэх сурагчдын тоо гм. Зорилтууд хэмжих үзүүлэлттэй байна. Оюутан элсүүлээд зогсохгүй тэднээс хэд нь амжилттай суралцаж хөдөлмөр эрхлэх боломжтой болох вэ? Зорилт хэрэгжиж дууссан гэдгийг хэрхэн мэдэх вэ?

2.5 Төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх

Төлөвлөгөө нь таны зорилтдоо хүрэх замын зураг юм. Төлөвлөгөөний олон аргууд байдаг. Зорилтоо тодорхойлсны дараа дор дурдсан зүйлийг хэрэгжүүлнэ:

- **Зорилго Тодорхойлох:** Зорилго нь – зорилтдоо хүрэхийн тулд ямар үр дүн гарахыг хүлээж эрмэлзэж байгааг тодорхойлно. Зорилго нь SMART- Тодорхой, Хэмжигдэхүйц, Хэрэгжихүйц (бодитой), Уялдаатай (зорилттойгоо уялдсан) ба Хугацаатай (хэрэгжих эцсийн хугацаа) байна.
- **Зорилгодоо хүрэх үе шатуудаа тодорхойлох:** Төлөвлөлтийн ямар систем хэрэглэж байгаагаас хамаарч зорилгод хүрэх үйл ажиллагаа нь үе шат, арга зам, стратегитай байж болно.
- **Зорилгыг хариуцах хүнийг томилох:** Зорилго, үйл ажиллагааг хариуцах хүн, эсвэл хэсэг хүмүүс (түнш эсвэл байгууллага)-ийг томилох шаардлагатай.
- **Цаг хугацааны хүрээг тодорхойлох:** Эхлэх хугацаа ба зорилгыг (эсвэл үйл ажиллагааны үе шатыг) ханган биелүүлэхээр төлөвлөж байгаа хугацаа.

-
- **Зардлаа тодорхойлох:** Зорилгоо биелүүлэхэд ямар өртөг, зардал гарахыг отоцоолох. Нөөц бололцоогүй (хүний болон санхүүгийн) бол зорилгоо хянаж өөрчлөх, хөрөнгө хуримтлуулах нэмэлт арга хэмжээг тусгах шаардлагатай болно.

Өмнө нь үр дүнтэй хэрэглэж байсан эсвэл сургалтын байгууллагаас санал болгосон төлөвлөлтийн аргыг ашиглаж болно, гол нь төлөвлөж бай! Юу хийх хэрэгтэй байна, хэрхэн хийх вэ, хэн түүнийг хийх ёстой вэ гэдгийг шийдэх хэрэгтэй.

Хэрэв та оролцоог дэмжих үйл ажиллагаагаа дөнгөж эхэлж байгаа бол төлөвлөгөөндөө тусгах шаардлагатай үйл ажиллагааны хэд хэдэн чиглэл байна. Үүнд:

- **Хүртээмжтэй байдал** ба мэргэжлийн сургалтын төвд, хэрэгжүүлэх шаардлагатай бодит, биет шинэчлэлт өөрчлөлт
- **Боловсон хүчний сургалт**, ба бусад түншүүдэд зориулсан хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалт
- **Сурталчлан таниулах ба Харилцаа холбоо тогтоох**, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй шууд ба бусдаар дамжих замаар харилцаа холбоо тогтоох.
- Урьдчилан тооцоолоогүй үүссэн ба дотооддоо зохицуулах боломжгүй оролцоотой холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор **Түншүүд ба экспертүүдээс зөвлөгөө, удирдамж авах.**
- **Тоног төхөөрөмж авах, шинэчлэх** – хичээлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг суралцагч тус бүрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ханган нийлүүлэх.
- **Сургалтын төлөвлөгөө, материалыг шинэчлэх** ялангуяа хэвлэмэл ба цахим мэдээллийг хүртээмжтэй, ашиглах боломжтой өөр хэлбэрээр бэлэн болгох заах аргын хэд хэдэн хувилбарыг ашиглах ба шаардлагатай бол шалгалт үнэлгээний ажилбарыг шинэчлэх.

Төлөвлөгөө тань ямар бүтэцтэй байх түүнд ямар зүйл туссан байх ёстой цаашид хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлох олон хүчин зүйл байдаг. Тухайлбал ажлын байран дахь сургалт зохион байгуулах бол ажил олгогчдыг татан оролцуулах хэрэгтэй болно.

Жишээ нь: Бангладешт үндэсний стратегийн төлөвлөгөөндөө мэргэжлийн сургалтад хамрагдаж буй нийт суралцагчдын 5 хувийн квотыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байхаар тусгасан байна. Тэдний төлөвлөгөөний бүтэц, гарчигууд нь танд сонирхолтой байж мэднэ.

Хүснэгт 3: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо бүхий мэргэжлийн сургалтын стратеги - Гарчиг

Бангладешийн ажлын хэсгийн жишээ – Системтэй хандлага

1. **Бодлого ба систем** – энд оролцоог хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түншүүдийн хамтын ажиллагаа, жендерийн асуудал зэрэг хянаж удирдах, үнэлж дүгнэх бүтэц орно.
2. **Оролцох** – хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн сургалтын талаар сурталчлан таниулахаар ажиллаж сургалтад хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ба тэдний байгууллагуудыг оролцооны бүхий л түвшинд (багшлах, шийдвэр гаргахад оролцох гм) идэвхтэй ажиллуулахыг хэлнэ.
3. **Мэдлэг ойлголт ба чадавхи** – хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний эцэг эх, ажил олгогч эзэд, ажилтнууд, үйлдвэрчний эвлэл, засгийн газар ба сургалтын байгууллагууд, олон нийтийн хүрээнд бүх альтернатив арга хэлбэрийг ашиглан, хэвлэл мэдээллээр хэлэлцсэн асуудлуудыг авч үзнэ.
4. **Хүртээмжтэй байдал ба Зохистой хангамж үйлчилгээ** – энд хичээлийн хөтөлбөр төлөвлөгөө, баригдаж суурилагдсан орчин, хүртээмж ба зохистой хангамж үйлчилгээний арга хэлбэр, тоног төхөөрөмж багаж хэрэгслүүдийн хангалт орно.
5. **Хөдөлмөр эрхлэлт ба Бизнес** – хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнесийн хөгжлийн үйлчилгээг хэрхэн хүргэх, ажил олгогчдын сонирхлыг дэмжих, сургалтын зорилгоор ашиглах бизнесийн газруудын хүртээмжтэй байх асуудлыг тусгана.
6. **Мэдлэг ба Судалгаа** – нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, ямар хангамж үйлчилгээ шаардагдах, тэдгээрийн арга хэрэгслийн эх үүсвэрийг тодорхойлох тухай мэдлэг хуримтлуулах асуудал орно.

2.6 Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх

Хэрэгжилтийн төлөвлөгөө нь таны хуримтлуулсан мэдээлэлд үндэслэн шинэчлэлт өөрчлөлт оруулж болохуйц баримт бичиг юм. Төлөвлөлтийн үйл явцын нэг хэсэг болохын хувьд хэзээ үнэлгээ дүгнэлт хийж, үүнд хэн оролцох вэ гэдгийг та шийдвэрлэх ёстой.

Таны зорилт SMART бөгөөд төлөвлөгөөний арга хэмжээ, үр дүн нь хэмжигдэх боломжтой, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах эзэд тодорхой бол хэрэгжилтийг үнэлж дүгнэх үйл явц хялбар байх болно. Арга хэмжээнүүд нэг бол таны төлөвлөсөн хугацаанд, төлөвлөсөн түвшин, хэмжээнд хэрэгжинэ эсвэл хэрэгжихгүй байна. Гол нь тухайн арга хэмжээ төлөвлөгөөний дагуу хэрэгжээгүй шалтгааныг тогтоох нь чухал. Магадгүй та зорилгоо илүү бодитой болгох, зарим зохицуулалт хийх, өөр мэргэжлийн хүмүүс томилж хариуцуулах, төсөв хөрөнгө хуваарилах, экспертиз хийх гм - шаардлагатай болно.

SMART зорилтуудын арга хэмжээ, үр дүнг үнэлж дүгнэх үндсэн үнэлгээний зэрэгцээ чанарын зарим үзүүлэлтүүдийг оруулах хэрэгтэй. Мэдээллийг багш, суралцагчдаас шууд авах нь нэг арга зам юм. Жишээ нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэлэхдээ жирийн иргэдийн нэгэн адил стандарт хэрэглэж, шаардлагатай хангамж үйлчилгээ үзүүлсэн эсэх?
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжлийн сургалтын хөтөлбөрт оролцохдоо жирийн иргэдийн адил мэргэжлээр суралцсан эсэх, шаардлагатай хангамж үйлчилгээ авч чадсан эсэх?
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төгсөж чадаж байна уу? Тэд бусад төгсөгчидтэй нэгэн адил түвшинд ажил, бизнесээ эхлүүлж байна уу?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч байгаа ангийн багш нарын хандлага ямар байна? Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллахад багш нар ямар бэрхшээл хүндрэлтэй тулгарч байна вэ? Саад бэрхшээлийг тэд давж гарч чадаж байна уу? Ямар амжилтын тухай тайлагнаж байна?
- Бусад суралцагчид оролцооны зарчимд ямар хувь нэмэр оруулж байна вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хичээл, сургалтын явцад хэрхэн хандаж байсан? Тэдний хэрэгцээ шаардлага бусдын нэгэн адил нөхцөл бололцоогоор хангагдсан гэж үзэж байна уу?

Дээрх жагсаалтад та өөр асуултууд нэмж баяжуулж болно. Түүнчлэн та эцэг эх, ажил олгогчид, сайн дурынхан зэрэг бусад түншүүдтэй уулзаж ярилцан тэдний оролцоо, санал бодлыг судалж болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дадлагажуулахаар авахдаа зохих ёсны дэмжлэг тусламж авсан эсэхийг ажил олгогч, бизнес эрхлэгчдээс асууж лавлах, мөн ажлыг гүйцэтгэхдээ хөтөч, уншигч зэрэг тусламж авсан эсэхийг сайн дурын туслагч нараас асууж судлах боломжтой.

Эдгээр асуултад авсан хариулт нь цаашид хөтөлбөрөө оролцооны зарчимд нийцүүлэх үйл ажиллагаанд тань удирдамж болох ач холбогдолтой. Үнэлгээ дүгнэлт хийсэн ажлын талаар тайлан гаргаж нийтийн хүртээл болгох, эсвэл гол түншүүддээ хүргэж болно. Гол нь сургалтын дараагийн шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж шинэчлэхэд чухал арга хэрэгсэл болно.

2.7 Удирдах ажилтан ба сургагч багш нарын анхааралд

Төлөвлөлтийг гол төлөв удирдлагын үүрэг гэж үздэг ба илүү үр дүнтэй болгохын тулд сургагч багш, сургалтын газрын ажилтнууд, байрны аюулгүй байдал, шинэчлэл хариуцсан ажилтнууд, түүнчлэн орон нутгийн удирдлага ба байгууллагууд, ажил олгогчдын ба хөдөлмөрчдийн төлөөлөл, эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын төлөөллийг төлөвлөлтөд оролцуулах шаардлагатай. Хөндлөнгийн ажилтнуудтай, ялангуяа түншүүдийн үндсэн бүлгийг төлөөлөх этгээдүүдтэй төлөвлөлтийн явцад зөвлөлдөх шаардлагатай. Ийм бүлгүүдийг түншийн хувьд оролцуулах асуудлыг төлөвлөлтийн арга хэмжээ болгон хэрэгжүүлж болно.

Удирдах ажилтны хувьд та төлөвлөгөөний үйл явцыг дэмжих үүднээс зөвлөлдөх баг байгуулж болно. Энэ багт үндсэн түншүүдийн төлөөлөл байх ёстой. Зөвлөлдөх ба төлөвлөгөөний багуудыг байгуулахдаа жендерийн асуудлуудыг бүрэн тусгаж, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн төлөөллийг нь хангах хэрэгтэй.

Хөрөнгө нөөц хангалтгүй байгаа бол төлөвлөлтийн явцад дутагдлуудыг илрүүлэн хөрөнгө олох, үүсгэх, тоног төхөөрөмж, экспертиз, хүний нөөцөөр хангах бүх талын аргуудыг судалж тусгах ёстой.

Харилцаа холбооны стратеги нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлд чиглэхээс гадна холбогдох бүх талуудтай харилцаа холбоо тогтоох хэрэгтэй, энэ нь нэмэлт нөөц бололцоо шаардлагатай үед чухал байдаг. Мөн оролцооны зарчмын хүрэх үр дүн, амжилтын талаар танилцуулж болно.

Сургагч багш нь суралцагчдын эрэлт хэрэгцээ, хичээлийн байдлыг сайн мэдэхийн хувьд төлөвлөлтийн үйл явцад ажил олгогчид, эцэг эхчүүдийн нэгэн адил идэвхтэй оролдох ёстой. Анги танхим, дадлагын газар, үйлдвэрлэл дээрх сургалтын орчны давуу талууд ба хүндрэл бэрхшээлийг бусдаас илүү олж харах боломжтой. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах ерөнхий төлөвлөгөөнөөс гадна анги танхимд чиглэсэн, тэргэнцэртэй иргэдэд зориулсан өөрчлөлтүүд, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт хийх зохицуулалт, багшийн туслах хэрэгсэл, сайн дурын туслахуудын хэрэгцээ зэрэг асуудлыг тусгаж болно.

Дадлагын газраас гадуур сургалт явагдаж байгаа бол сургалтын бусад байгууллагууд, field visit sites, бизнесийн байгууллагууд, ажил олгогчийн ажлын байр зэрэг сургалтын газруудыг төлөвлөгөөндөө тусгахыг орхигдуулж болохгүй.

2.8 Дүгнэлт

Энэ бүлэгт оролцоо бүхий сургалтын орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой төлөвлөлтийн үйл явцыг тоймлон тайлбарласан. Уг бүлэгт төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх асуудлуудыг авч үзсэн. Өмнөх болон энэ бүлгийн аль алинд нь хөтөлбөрийн түгээмэл загвар ба зохистой хангамж үйлчилгээний концепцийг тайлбарласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зааж сургах ба суралцах үйл явцын концепцийн онцлог шинжүүдийг дараагийн бүлгүүдэд авч үзнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ 3:

ОРОЛЦООГ ДЭМЖСЭН СУРГАЛТЫГ ХӨГЖҮҮЛЭХ

3.1 Бүлгийн зорилт

Энэ бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг жирийн хүмүүстэй хамт адил цаг хугацаанд адил үр дүнтэйгээр суралцах явдлыг зохион байгуулж дэмжих тухай танилцуулна. Ийм оролцоог жинхэнэ бодит оролцоо гэнэ.

Бүлэг гурван хэсгээс бүрдэх бөгөөд хэсэг тус бүрийн чиглэл нь:

1. Суралцах үйл явц – Мэдээлэл нь хэрхэн мэдлэг болж хөрвөдөг, мөн мэдлэг, чадвар эзэмших үйл явцыг дэмжих стратеги
2. Туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээ ба хөгжлийн бэрхшээлүүд
3. Сургалтын үйл явцаар дамжин – Элсэлтээс эхлэн сурлагын үнэлгээ, дүгнэлт гаргах үе шатанд - тусламж үйлчилгээг хэрхэн хүргэх

3.2 Суралцах үйл явц

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрэлт хэрэгцээг судлахдаа суралцах үйл явцыг бүхэлд нь авч үзэх хэрэгтэй. Гол санаа нь: Мэдээлэл нь хэрхэн мэдлэг болж хувирдаг вэ, тэр нь хэзээ ур чадвар болдог вэ? Мэдээллийг та хэрхэн, яаж ашиглахаа мэдсэн нөхцөлд мэдээлэл нь мэдлэг болдог. Мэдлэг эзэмшсэний дараа түүнийгээ та ямар нэг зүйл дээр харуулах чадвартай болно, харин тодорхой цаг хугацаанд дадлага хийж байж тухайн зүйлийг гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар суух болно. Мэдээлэл нь мэдлэг болж хувирах үйл явцыг дөрвөн үе шатанд хуваана. Энэ үйл явцыг суралцах үйл явц гэнэ.

1. **Та мэдээллийг хүлээн авна.** Таны үнэрлэх, амтлах, сонсох, харах, хүртэх мэдрэх мэдрэхүйгээр дамжин танд мэдээлэл хүрнэ.
2. **Мэдээлэл таны тархинд хадгалагдана.** Та мэдээллийг хаяглан бүлэглээд өмнө нь мэдэж байсан ямар нэгэн зүйлтэйгээ холбож уялдуулна. Яагаад ингэдэг вэ? - Дараа нь мэдээллийг сэргээхийн тулд.
3. **Мэдээллийг хадгалагдах сангаас нь сэргээнэ** – шаардлагатай үед.
4. **Мэдээллээ ямар нэг зүйл хийж гүйцэтгэх зорилгоор ашиглана.**

Энэхүү суралцах үйл явц, мэдээллийг мэдлэг болгон хувиргах үйл явц нь автоматаар явагддаг мэт ойлгогдох тал бий.

Гэхдээ таны аль нэг мэдрэхүй сул хөгжсөн эсвэл огт ажилладаггүй бол яах вэ? Та түүнийг орлуулан бусад мэдрэхүйгээ ашиглаж мэдээлэл авч болно. Хэрэв та мэдээллийг хэрхэн ангилж бүлэглэхээ мэдэхгүй байгаа бол яах вэ? Тэгвэл та мэдээллийг өмнө нь танил байгаагүй аль нэг зүйлтэй холбож ойлгоход туслалцаа авах шаардлагатай. Хэрэв мэдээллийг сэргээж чадсан хэдий ч түүнийгээ хэлж ярих, бичиж ойлгуулах чадваргүй бол яах вэ? Та харилцааны өөр арга хэлбэрийг ашиглаж багшдаа болон бусад хүмүүст мэдлэгээ дамжуулах боломжтой.

Мэдээллийг суралцагчдад “илгээсний” дараа лекц, даалгавар г.м, “тэд хүлээн авлаа” – тэд энэ юу болох, юунд хамааралтай, яагаад чухал болохыг - мэдлээ гэж та тооцдог. Тэд уг мэдээллийг оюуны санамжид хадгалаад хэрэгтэй үедээ сэргээж хэрэглэнэ гэж та бодож болох юм. Энэ бодлын зөв эсэхийг та сургалтын явцад асуулт тавих, сорих замаар “шалгаж” болно. Хэрэв суралцагчийн гүйцэтгэл муу байвал та шалтгааныг нь мэдэхгүй байх магадлалтай. Суралцагч мэдээллийг хараагүй эсвэл сонсоогүй юу? Суралцагч мэдээллийг хэрхэн ангилж бүлэглэхээ мэдээгүй юу, эсвэл мэдээллээ сэргээж чадаагүй юу?

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь сонсох, харах, ярих, явах, эсвэл бусад бэрхшээлийн улмаас дээрх хүндрэлүүдтэй тулгардаг байж болно. Жишээ нь, суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг хүлээн авч мэдлэг болгон боловсруулах чадваргүй байх тохиолдолд багшаас мэдээллийг ойлгоход дөхөмтэй арга хэлбэрээр танилцуулахыг хүсэх, юмуу туслах хэрэгсэлийн үйлчилгээ хүсч болно.

3.3 Мэдлэг эзэмших явцыг дэмжих стратеги

Нэг суралцагчид зааж сургахаар эрмэлзсэн зүйлийг бусад суралцагчид мөн адил сурах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй болон жирийн суралцагчдад заах хичээл тань адил байх ёстой. Таны хувьд “юу” заах нь өөрчлөгдөхгүй, харин “аяж” заах нь өөрчлөгдөж болно. Заах аргаа өөрчлөх зарим стратеги, арга техникийг дор тайлбарлав.

Сурах чадварыг сайжруулах тусгай стратеги хэрэглэж ажилласнаар хүн бүр амжилттай суралцах боломжтой юм. Хүн бүрт ашиг тустай, гадуурхагдахгүй тэгш оролцох орчныг бүрдүүлж чадна. Эдгээр стратеги нь хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран бүх суралцагчдад үр дүнгээ өгөх ба та заах ур чадварынхаа хэсэг болгон ашиглаж ирсэнээ ойлгоно.

Мэдрэхүйгээ ашиглах

Та заах олон төрлийн арга хэрэглэж байвал суралцагчид илүү анхааралтай байдаг. Зааж тайлбарласны дараа нь үзүүлэн таниулах арга хэрэглэх хэрэгтэй. Дүрс бичлэг үзүүлж (дүлий эсвэл сонсгол султай суралцагчидтай бол - субтитртай, хараагүй

суралцагчидтай бол - дуу бичлэг сонсгох, (ийм хүмүүс заавал байдаг) дараа нь асуулт асууна. Суралцагчидтайгаа харилцаатай байснаар хүн бүрийн анхаарлыг төвлөрүүлж чадна. Үзүүлэн таниулах хэсгийн дараа суралцагчдад даалгавар өгч өөрсдөө бодитоор хийж үзэх боломж олгоно. Ингэхдээ нүд, чих, гараа ашиглах олон төрлийн стратеги хэрэглэнэ. Олон төрлийн стратеги ашигласнаар таны хүргэсэн мэдээллийг суралцагчид ялгаж салган, холбон нэгтгэж, ашиглаж чадаж байгаа эсэхийг тодорхойлох боломжтой. Та хичээлийнхээ, лекц дадлагын явцыг хэд хэдэн мэдрэмж ашиглахаар зохион байгуулж байвал (харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүрч мэдрэх) суралцагчдад суралцахад нь тусалж байдаг.

Та хичээлийнхээ явцад материалаа хэрхэн танилцуулж байгаа, суралцагчдыг хэрхэн татан оролцуулж байна, мөн зарим мэдрэмж давуу ач холбогдолтой байгаа эсэх, өөрсдөөр нь практик дадлага хэр олон удаа хийлгэж байна гэх мэтчилэн өөрийнхөө ажлыг дүгнэж болно. Ангийн нөхцөлд та ярих, үзүүлэх хичээлийг түлхүү ороод харин дадлагын газарт даалгавар өгч болно.

Жишээ нь ширээ хийх ажлыг авч үзье. Ширээ хийх санааг тайлбарлахдаа ширээ олон зориулалтаар ашиглагддаг тухай ярьж ширээ хийхэд хамгийн тохиромжтой материал, ширээний загварууд, модны төрлүүдийг тайлбарлан ширээний загвар үзэж болох газар дагуулан очиж болно.

Багш тайлбарлах явцад суралцагчид ширээний загвар, модны төрлийг үзэж харах, мэдрэх, үнэрлэх боломжтой юм.

Дараа нь оюутнуудад ширээг хэрхэн хийж байгааг харуулсан дүрс бичлэг үзүүлж ширээ хийхтэй холбоотой мэдээллийн талаар ярилцаж болно. Үнэ өртөг, тогтвортой, бат бөх, чанар, эдэлгээ, хэмжээ, хэрэглээний ач холбогдол, үзэмж гм. Энэ шинжүүдээр ялгаатай ширээнүүдийн зураг олж бусад оюутнуудтай ярилцах даалгавар өгч болно. Энэ нь оюутнууд нүд, чих, хүрэх мэдрэмжээ ашиглан дүгнэлт хийж саналаа илэрхийлэх боломж олгоно.

Ширээ хийх үе шатанд багш эхлээд холбогдох ажилбаруудыг хэрхэн гүйцэтгэхийг тайлбарлаж үзүүлнэ. Дараа нь оюутнуудад ялгаатай даалгавар өгөх жишээ нь, ширээний загвар гаргах, мод зүлгэх, мод тайрах, модны хэсгүүдийг нийлүүлж хадах, будах, өнгөлөх, эсвэл ширээний хийцийг хийж дуусахаас хэд хэдэн ажилбарын өмнө дүгнэж үнэлэх хэрэгтэй.

Эдгээр үйл ажиллагаанд мэдрэмжээ ашиглах боломжтой – хүрч мэдрэх, харах, сонсох, үнэрлэх (модны олон төрлийг ялгаж салгахын тулд хаяг шошгыг уншихаас гадна үнэрлэж тодорхойлно).

Суралцагчид өөрийн илүү хөгжсөн мэдрэмжээ ашиглах боломжтой нөхцөлд мэдлэг олж авах, боловсруулж санах ба түүнийгээ хэрэглэх чадвар нь сайжирдаг.

Чухал мэдээллийг түгээх

Зарим суралцагч уншиж, бичиж чадах боловч мэдээллийн аль нь чухал болохыг ялгаж тодорхойлоход хүндрэлтэй байж болох юм. Ийм оюутнуудад туслахын тулд хичээл эхлэхээс өмнө чухал асуудлуудыг улаанаар зурж тодруулсан тэмдэглэлийг өгч болно. Хэрэв суралцагч бүрт сэдвийн чухал хэсгүүдийг ойлгуулах зорилт тавьж байгаа бол хичээлийн тэмдэглэлийнхээ хувийг хичээл эхлэхээс өмнө яагаад өгч болохгүй гэж? Ингэснээр та хүн бүрт адил тэгш хандаж хүн бүр таны хичээлийн чухал мэдээллийг ойлгож мэдэх магадлал нэмэгдэнэ. Суралцагчид тэмдэглэл хөтлөх шаардлагагүй болж таны ярьж байгаа зүйлд илүү анхаарах ба санал солилцож ярилцах цаг гарна.

Тэмдэглэлээ өгөх цаг хугацааны сонголт чухал байдаг. Лекц эхлэхээс өмнө мэдээллээ өгөх, суралцагчдад мэдээллийн талаар анхааруулсан бол тэд уг материалыг хичээлээс өмнө үзэх эсэхээ өөрсдөө шийднэ. Хэрэв тэд судалсан бол хичээлийн үеэр “хэрэв ингэвэл” гэсэн олон төрлийн хувилбар найруулгаар хүн бүр оролцож ажиллах бололцоотой. Хэрэв хичээлийн дараа өгвөл тэд өөрсдийн тэмдэглэлээ харьцуулж үзэх материалтай болох ба шалгалтад бэлтгэх материалтай болно гэсэн үг.

Чиг баримжаа олгох, яагаад чухал болох, хэрхэн хэрэгжүүлэх

Чиг баримжаа олгох гэж юу болох, тэднээс юу хүлээж байгаа тухай суралцагчдад ойлгуулахыг хэлнэ. Зөв чиг баримжаа олгох нь бүх хүний хувьд ашигтай байдаг. Ямар нэг зүйл хэзээ эхэлж хэзээ дуусч байгааг тодорхойлох, тэд ямар холбоотойгоор зохион байгуулагдсан, яагаад чухал болохыг ойлгох хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зөв чиглүүлэх явдал маш чухал. Хэрэв тэднийг зөв чиглүүлж өгвөл, тэд юу болж байгааг ойлгож хичээлийн явцыг дагаж идэвхтэй оролцдог.

Агуулга ач холбогдлыг ойлгуулах

Хичээлийн хамгийн чухал хэсэг нь агуулга, ач холбогдол байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс хамаарахгүйгээр суралцагчид – Яагаад үүнийг сурах ёстой вэ? Яагаад одоо сурах ёстой вэ? – гэх мэт эргэлзээтэй байж болох юм. Хэрэв та эдгээр асуултуудад нь хариулж дор дурдсан арга техникийг ашиглавал сайн үндэс суурь тавигдаж, өөртөө итгэх итгэлтэй болохоос гадна оролцоог мэдрэхэд нь суралцагчдад туслах болно.

Дараалал

Хичээлийн сэдвүүдийг дугаарлах нь бас нэг шинэлэг санаа юм. Ингэснээр суралцагчид нэг сэдэв хаана дуусаад дараагийн сэдэв хаанаас эхэлж байгааг мэдэх боломжтой болно. Мөн хичээл дуусахаас өмнө хэр их материал үлдэж байгааг мэднэ. Сэдвүүдийг дугаарласнаар суралцагчдыг сэдвүүдийн дотор баримжаатай байлгах, сэдвүүдийн хоорондоо ялгаатай ба адил талуудыг нь харьцуулах, улмаар нэгтгэж ойлгуулахад ач холбогдолтой.

Жишээ нь: Таны эхний сэдэв хүнсний ногоонуудыг хооронд нь хэрхэн ялгах тухай гэж үзье. Хоёрдахь сэдэв - ногоог хэрхэн жигнэх тухай. Гуравдахь сэдэв – ногооны нягтаршил зузааныг хэрхэн тогтоох. Дөрөвдэх сэдэв – ногоог чанаж болгох хугацаа. Хараа, сонсголын бэрхшээлтэй суралцагчдад хичээлийг ойлгоход хялбар дөхөмтэй болно.

Дугаарлалт, дохио тэмдэглэгээ

Ажлын дараалал тогтоохын үндсэн зорилго нь суралцагчдад тухайн үед хийвэл зохих зүйлээ зөв сонгож, дараа нь хийх ёстой зүйлээ мэдэж авах явдал юм. Дохио, тэмдэг, дугаарлалтыг ашигласнаар суралцагчдын сурах үйл явцыг хурцалж амжилтыг ахиулах ач холбогдолтой.

Дараалал хийх арга нь таны заах аргын зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Хичээлээ эхлэхдээ та “Эхлээд” гэх, эсвэл дуусах үед “Энэ бол сүүлчийн хэсэг байлаа, одоо ингээд дуусгая” гэх мэтээр хэлж болно. Цаг хугацаагаар хязгаарлагдсан, хугацаа товлосон аливаа нөхцөлд та хэр хугацаа үлдэж байгааг суралцагчдад анхааруулж хэлэх ёстой. Ингэж суралцагчдаа, олон чиглэлд байнга идэвхжүүлж байх боломжтой. Хараагүй, сонсголгүй, мэдээлэл боловсруулах чадвар сул, удаан бичдэг, бусдаас удаан хүмүүст дараалал маш чухал байдаг.

Хэвлэсэн гарын авлага, тараах материалыг дор дурдсан байдлаар хийж болох юм.

- Гол санаануудыг тодруулах
- Адил төстэй баримтуудыг өнгөөр ялгаж тэмдэглэх
- Тэмдэг хаяг таб (догол мөр) ашиглах
- Бичмэл материалыг дагалдуулан зураг, график ашиглах
- Нэгтгэн дүгнэх

Энэ аргуудыг өөрийн тэмдэглэл, номондоо хаана, хэрхэн яаж ашиглаж болох хувилбаруудыг суралцагчиддаа санал болгох

Харааны бэрхшээлтэй суралцагчдад брайлийн галиг, компьютерийн файл зэрэг мэдээлэл хүлээн авах бусад тусгай хэрэгсэл шаардлагатай байвал дохионы тэмдэглэгээг хэрэглэхдээ бүтээлч санаачлагатай байх шаардлагатай болно.

- Суралцагчдаас асуулт асуухдаа дараах арга хэрэглэж болно:
- Цухас санаа дохио өгөх
- Логик дарааллаар асуултаа тавих (жишээ нь: яагаад, хэзээ, хэрхэн г.м)
- Хариулт бүрийн дараа тайлбар, дүгнэлт өгөх
- Хэсэгчилсэн зөв хариултыг хүлээн зөвшөөрөх

Эрэмбэлэх

Сэдэв заахдаа дэд сэдвүүдийг дотор нь логик дараалалд оруулна. Агуулга ач холбогдлыг тайлбарлахдаа энгийн санаанаас эхэлж болно. Сурах бэрхшээлтэй суралцагчидтай ажиллахад эрэмбэ, логик дарааллыг хангах явдал чухал байдаг. Хичээлийн дэд сэдвүүд, санааг эрэмбэлсний үр дүнд мэдлэг, ур чадвар эзэмшинэ. Энэ арга нь нарийн төвөгтэй хэд хэдэн үе шаттай бөгөөд харилцан уялдаа бүхий цогц мэргэжлээр сургаж байгаа нөхцөлд тодорхой эрэмбэ цэгцийн дагуу гүйцэтгэхэд маш чухал хялбар болно.

Ажлаа дүр зургийн дагуу зааж тайлбарлаж ойлгуулсаны дараа жижиг сэдэв, дэд хэсгүүдэд задлах хэрэгтэй. Эхний дэд хэсгээс эхлээд дараагийн дэд хэсэг тус бүрийг дэс дараатайгаар тайлбарлан үргэлжлүүлж аажмаар сүүлчийн сэдэв хүрэхэд ерөнхий дүр зураг тодорхой болохоор зохион байгуулах хэрэгтэй. Нарийн төвөгтэй сэдэв эсвэл мэргэжлийн ур чадварын хичээл заахад эрэмбэлэх асуудлыг зорилгын шинжилгээ хийх дэд хэсгүүдэд хуваагаад нэг удаа нэг дэд хэсгийг заах гэж ойлгоно.

Гол төлөв таны заах сэдвүүдийг урьдчилан эрэмбэнд оруулж дэд хэсгүүдэд зохион байгуулсан байдаг. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүний сургалтын хэрэгцээ шаардлагын үүднээс сэдвийг цаашид эрэмбэлэх дэд сэдвүүдэд хуваах шаардлага гарах эсэхийг шийдвэрлэх асуудал таны үүрэг болно.

Оюун ухааны бэрхшээлтэй иргэдийг сургахад эрэмбэлэх арга илүү ач холбогдолтой. Сургалтын үйл явцад бусад тохиромжтой заах арга хэлбэрийг хэрэглэж болно. Тухайлбал дараалал, дохио, тэмдэглэгээ, үзүүлэн таниулах, дадлага гм. Дэд сэдэв бүрийг танилцуулж үзүүлэнгээр тайлбарласны дараа сэдвийг үргэлжлүүлэн заахаас өмнө суралцагчдыг үзсэн сэдвээр дадлага хийлгэнэ. Зарим суралцагчдад дохионы тэмдэглэгээгээр цаашид дэмжлэг үзүүлэх шаардлагатай байж болно. Та энэ бүх аргуудаас-хамгийн тохиромжтой, үр дүнтэй арга хэлбэрийг сонгохын тулд суралцагчдын саналыг судлан бүтээлч санаачлагатай ажиллах шаардлагатай.

Уялдаа холбоог ойлгуулах

Мэдээллийн нарийн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог ойлгох чадварт сургаснаар суралцагчид илүү өндөр түвшинд мэдлэг эзэмшихэд нь тус дөхөм болно. Мэдлэгээ хэрхэн хэрэглэх, түгээж уламжлах, нэгтгэх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадвартай болоход чухал нөлөө үзүүлдэг.

Зарим суралцагчдад мэдлэгийн өндөр түвшинд хүрэхэд бага заавар удирдамж шаардагддаг. Зарим нь уялдаа холбоог олж харахын тулд тусламж авах хэрэгтэй байдаг. Та хаанаас эхлэх нь зүйтэй вэ? Амжилтаа ойртуулахын тулд эхнээс нь заагаад таны суралцагчид дадлага хийх шаардлагатай болох хүртэл ажлаа үргэлжлүүлнэ.

Чухал асуултууд

- Хэрэв би аль нэг зүйлд нэр, хаяг, гарчиг өгвөл суралцагч маань түүнийг дараа үзүүлэхэд санах уу?
- Хэдэн хаяг, нэрийг санаж чадах вэ?
- Адил төстэй зүйлүүдийг хооронд нь тохируулан тааруулж чадах уу? Тийм бол хэдийг?
- Олон янзын олон тооны зүйл дотроос миний шаардсан тухайн нэг зүйлийг олж сонгож чадах уу?
- Эд зүйлсийг зориулалтын дагуу хослуулах эрэмбэлүүлэх үүргийг суралцагч гүйцэтгэж чадах уу?
- Түүний хувьд шинэ танил биш эд зүйлийг харуулахад аль анги бүлэгт хамаатайг оноож мэдэх үү?
- Аль нэг үүргийг гүйцэтгэхийн тулд ямар эд зүйлс хэрэг болох вэ гэх асуултад тэр эд зүйлсийг нэрлэн жагсааж зориулалтыг нь тайлбарлаж чадах уу?
- Даалгавар өгөхөд түүнийг биелүүлэхийн тулд шаардагдах эд зүйлсийг сонгон хэрэглэж амжилттай зөв гүйцэтгэж чадах уу?
- Саад бэрхшээлтэй асуудал дэвшүүлэхэд суралцагч түүнийг хэрхэн давж шийдвэрлэх тухайгаа тайлбарлаж чадах уу?
- Төвөгтэй байдал үүсгэхэд түүнийг суралцагч зохицуулан шийдвэрлэж чадах уу?
- Эд зүйлс ашиглаад нэг өвөрмөц зүйл бүтээж бий болгох даалгавар өгвөл түүнийг гүйцэтгэж чадах уу?

Эдгээр асуултын хариултауд суралцагчдын эд зүйлийг нэрлэх, санах, тохируулж оноох, ялгах зааглах, таньж мэдэх, нэгтгэж бүлэглэх, үнэлж дүгнэх, мэдээллийг ашиглах чадварын тухай мэдээллийг танд өгнө. Зарим суралцагчдын хувьд эд зүйлсийн хоорондын уялдаа холбоог ойлгохын тулд тусгай хичээлүүд, зарим хэсэгт илүү дадлага шаардагдаж болох ба эцэст нь бүх суралцагчдын адил түвшинд чадвар эзэмших боломжтой юм.

Нэг хүнд зааж эзэмшүүлэх мэдлэг чадварыг бусад бүх суралцагчид эзэмших ёстой гэх хандлага нь таны заах аргын хамгийн чухал зарчим байх ёстой. Таны заах сэдэв, агуулга нь хөгжлийн бэрхшээлтэй ба жирийн иргэдийн хувьд адил байх ёстой. Суралцагч бүр таны заах зүйлийг сурах чадвартай болох ёстой. Таны хувьд юу заах нь өөрчлөгдөхгүй боловч хэрхэн яаж заах нь өөрчлөгдөж болно.

Хүснэгт 4: Түгээмэл шийдлийн зарчмыг хичээл зааварчилгаанд нэвтрүүлэх

- Сэдвийг танилцуулахдаа олон хэлбэрийн арга барил, нөхцөл ашиглах
- Суралцагчдад слайд, тэмдэглэл, гарын авлага тараах
- Суралцагчдад эрэмбэ, дарааллын дагуу баримжаа чиглэл тогтмол өгч байх эхлээд бид үүнийг хийнэ, дараа нь түүнийг хийх болно гм
- Энгийн хялбар асуудлаас эхлээд нарийн төвөгтэй сэдэв рүү шилжих
- Суралцагчид таны хичээлийг ойлгож байгааг үе үе шалгаж байх
- Суралцагчдад шинэ мэдээллийг боловсруулж шаардлагатай үед өмнөх материалтай нэгтгэн ойлгох цаг хугацаа өгч байх
- Шалгалт үнэлгээндээ уян хатан хандах

Дадлагажих боломж олгох

Хурд нарийвчлал, арга хэлбэр зэрэг хүчин зүйлийн нэгдлээр хэмжигдэх мэргэжлийн ур чадварыг сайжруулахын тулд хийгдсэн зүйлийг дадлага гэнэ. Ихэнхи тохиолдолд суралцагчид дадлагыг бие даан удирдагчгүй хийдэг. Зарим хүнд бусдаас илүү дадлагын хугацаа шаардагдана. Заримд нь бусдаас илүү удирдлага зааварчилгаа шаардагддаг юм.

Дор дурдсан асуултуудад хариулах нь дадлагын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж дэмжих тухай шийдвэр гаргахад чухал болно.

- Хичээлийн аль сэдвүүдэд дадлага шардлагатай байх вэ?
- Тухайн дадлагыг удирдагчгүй эсвэл зааварчилгагүй хийж чадах уу?
- Дадлага хийлгэхийн тулд тусгай нөхцөл (дадлагын байрны зохион байгуулалт гм), Эсвэл эд зүйлс (багаж хэрэгсэл, хангалт, бэлэн загвар гм) шаардагдах уу?
- Суралцагчийг аль болох олон удаа дадлага хийх боломжтой болгохын тулд багш зааварлагчийн оролцоог бууруулах арга зам байгаа эсэх?
- Суралцагч өөрийн дадлагын оролцоогоо хүлээн зөвшөөрөгдөх түвшин байх ёстой стандарттай харьцуулж дүгнэх арга зам байгаа эсэх?
- Суралцагч хэзээ дадлага хийх ёстой вэ (тайлбар танилцуулгын өмнө, зааварчилгааны дараагийн хэсэгт бэлтгэхийн тулд хийх)?

Дадлага хийх боломж бүрдүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог дэмжих үр дүнтэй арга болдог. Нэг суралцагч өөр нэг суралцагчийн дэмжлэг авч ажиллах андын систем нь зарим дадлагыг илүү үр дүнтэй болгоно. Дадлагын үеэр хослон хамтрах арга нь илүү чөлөөтэй хэлбэр ба мэргэжлийн янз бүрийн түвшний суралцагчид бие биенээ илүү таньж мэдэх бололцоо олгодог юм.

3.4 Хариу санал дүгнэлт

Хариу санал дүгнэлтийг зохистой цаг хугацаанд тохирсон арга хэлбэрээр гаргаж байвал нийт суралцагчдын хувьд чухал байдаг. Хариу санал дүгнэлт нь тодорхой байх ёстой. “Сайн байна!” гэх нь хангалтгүй. Харин “Сайн байна, компьютерийн файлуудыг хураангуйлах бүх үе шатыг зөв гүйцэтгэлээ!” гэвэл илүү үр дүнтэй байна. Хангалтгүй гүйцэтгэлд мөн тодорхой дүгнэлт өгөх нь чухал байдаг.

Суралцагчийн эсвэл нийт суралцагчдын сайн гүйцэтгэлийг олны өмнө эерэгээр дүгнэхэд хялбар бөгөөд таатай байна. Харин хангалтгүй үр дүн үзүүлсэн тохиолдолд амаргүй байдаг. Бусдын өмнө муу гэсэн сөрөг үнэлгээ авах нь маш таагүй сэтгэгдэл үлдээдэг. Гэхдээ муу гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргах хүртэл аль болох бага хугацаа байвал таны дүгнэлт суралцагчийн цаашдын гүйцэтгэлд сайн нөлөө үзүүлэх магадлал өндөр байна. Суралцагч дараа нь дутагдлаа яаж “засаж залруулахаа” мэдэх болно.

Хариу санал дүгнэлт гаргахаас өмнө харгалзаж үзвэл зохих асуултууд

- Миний хариу санал дүгнэлт эерэг үү, сөрөг үү?
- Суралцагч тухайн санал дүгнэлтэд хэрхэн хандаж хүлээн авах вэ?
- Тухайн суралцагчийн талаар бусад нь хэрхэн ойлгож хандах вэ?
- Хариу санал дүгнэлтийг ганцаарчилж өгөх нь дээр үү?
- Тухайн суралцагчийн талаар өмнө нь тодорхой нарийн санал дүгнэлт гаргаж өгч байсан уу?
- Тийм бол өмнөх санал дүгнэлт ямар үр нөлөөтэй байв?
- Зохистой үр дүнд хүрэхийн тулд хариу санал хүсэлтийг яаж өөрчлөх боломжтой вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцооны асуудал алхам тутам тулгарч байгаа бол хариу санал дүгнэлттэй ажиллах нь таны хувьд илүү чухал ач холбогдолтой байдаг. Та шударга шүүгч байж таныг шударга шүүгч гэж дүгнэнэ. Иймд хариу санал дүгнэлтийг тухайн хүнтэй нь бус зөвхөн гүйцэтгэлтэй нь холбож өгөх хэрэгтэй. Жишээ нь “Жуан, та дахиад буруу хийлээ!” гэж бүү хэлээрэй, үүний оронд “Жуан,

дараагийн удаа компьютерээ унтраахын өмнө эхлээд бүх идэвхтэй программуудаа хааж байгаарай. Тэгвэл таны файлууд алдагдахгүй” гэх нь дээр. Хэрэв сөрөг утгатай санал дүгнэлтийг зайлшгүй хэлэх шаардлагатай бол ганцаарчилж хийх нь зөв байдаг. Тийм боломжгүй бол хийж гүйцэтгэсэн зүйл дотор нь нааштай эерэг санаа хэлж болох ямар нэг зүйлийг олж тэмдэглэх хэрэгтэй.

Үргэлж тууштай байгаарай.

3.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээ үзүүлэх

3.5.1 Үндсэн журам

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс анги танхим, дадлагын байр, ажлын байр сургалтын орчинд дор дурдсан боломжтой байх ёстой.

- Сургалтын орчинд хүрч ашиглах.
- Болох үйл явдлыг мэдэж хэрхэн оролцож хувь нэмэр оруулахаа мэдэх. Бие даан ажиллах боломжтой.
- Нийт суралцагчид зөвшөөрөгдөх түвшинд сонголт хийж нөхцөл байдлыг хянах боломжоор хангагдах замаар тодорхой хэмжээнд эрх мэдэлтэй байх.
- Жирийн суралцагчдын нэгэн адилаар ижил зорилго даалгавар, хичээл зааварчилгад хамрагдаж байх.
- Хичээлийн үеэр багш, суралцагчидтай хамт оролцох
- Бусадтай харилцаа тогтоож нийгэмших.
- Шаардлагатай үед ялангуяа бэлтгэл, шилжилтийн үед дэмжлэг авах.
- Шаардлагатай бол, мэдлэг олох ба илэрхийлж харуулах үедээ уян хатан нөхцөлөөр хангагдах.
- Шаардлагатай тохиолдолд жирийн суралцагчдын адил хийж гүйцэтгэх, адил үр дүн гаргахад шаардагдах туслах хэрэгсэлийн тусламж, үйлчилгээ авах.
- Шаардлагатай үед, ердийн бус харилцааны арга хэрэгслийн тусламжтайгаар харилцах.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид бусадын нэгэн адил тэгш оролцохын тулд тодорхой хэмжээний тусламж үйлчилгээ шаардагдана. Туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээний ерөнхий үзүүлэлтүүдийг Нэгдүгээр Бүлэгт авч үзсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцоог хангахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээ, стратегийн зарим жишээг дор дурдсан.

3.5.2 Стратегийн жишээнүүд

Харааны бэрхшээлтэй суралцагчид

Суралцагчийг байр, анги танхим, ариун цэврийн өрөө, хоолны газар, захиргааны оффист хүрэх замд нь чиглүүлэх, газарчлах.

Хараагүй хүн ямар технологи, туслах хэрэгсэл, төхөөрөмж (дуу бичлэгийн төхөөрөмж, брайль бичгийн хэрэгсэл, зөөврийн компьютер гм) авчрахыг тодорхойлох. Суралцагчдад өөр юу хэрэгтэй болохыг тодорхойлох?

Суралцагч мэдээлэл хүлээн авах илгээх ямар арга хэлбэрийг сонгохыг тодорхойлох.

Суралцагчийн ашиглаж байгаа бодит орон зайд ямар өөрчлөлт оруулах шаардлагатайг тодорхойлох.

Суралцагч нь орчиндоо бие дааж явахад ямар тусламж шаардагдахыг тодорхойлох.

Суралцагчдад тусламж шаардлагатай үед хандаж болох хүнийг хэлж мэдүүлэх.

Сонсголын бэрхшээлтэй суралцагч

Сонсголын бэрхшээлтэй хүмүүстэй харьцахдаа мэдээллийг давтаж хэлэхэд бэлэн байх. Хэрэв хүний хэлсэнийг ойлгоогүй бол давтан хэлэхийг хүсэх.

Ярьж эхлэхээсээ өмнө тухайн хүний анхаарлыг татах, дохио өгөх, мөрөнд нь хүрэх гм.

Уруулын хэт идэвхтэй хөдөлгөөн хэрэглэхгүй байх.

Амныхаа өмнө гараа барьж ярихгүй байх.

Дохионы хэлмэрч байсан ч харьцаж буй суралцагчтай харцаараа холбоотой хэвээр байх.

Суралцагчтай ярилцаж байх үедээ үзэгдэж сонсогдох бүх саадыг багасгах буюу зайлуулах.

Суралцагч таны хэлсэн зүйлийг ойлгоогүй бол давтаж хэлэх, өөрөөр хэлэх, бичих, эсвэл биеийн хэл, хөдөлгөөн, зураг дүрс ашиглан үзүүлж харуулах.

Хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчид

Суралцагч нь хүрэх газраа хугацаандаа хүрч чадах эсэхийг тодорхойлох.

Суралцагч нь хүрэх газраа очихын тулд бие даан зүг чигээ олж аюулгүй хүрч чадах эсэхийг тодорхойлох.

Хүрээлэх орчин (ариун цэврийн өрөө, цай хоолны газар, лаборатори, номын сан, лекцийн танхим гм)-ийг суралцагчид бие даан, аюулгүй байдлаар ашиглах нөхцөлийг хангахын тулд ямар өөрчлөлт шинэчлэл хийх шаардлагатайг тодорхойлох.

Анги танхим, дадлагын газар, үйлдвэрлэлийн дадлагын байр ба хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцохын тулд суралцагчдад ямар эрэлт хэрэгцээ байгааг тодорхойлох.

Зан төлөв, сэтгэцийн өөрчлөлттэй суралцагчид

Суралцагчийг анги, сургалтын хөтөлбөртэй танилцуулахдаа дор дурдсан зүйлийг тайлбарлаж өгөх:

- Цагийн хуваарь
- Үүрэг хариуцлага, дүрэм журам
- Хүлээгдэж буй өөрчлөлт, тодорхойгүй байдлын түвшин
- Суралцагчийн сэтгэл санааны таагүй байдалд хүргэж болох хүлээлт, шаардлагуудыг тодорхойлж тэдгээрийг хэрхэн зохицуулах талаар шийдвэр гаргах.

Сүрах чадварын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид

- Мэдээллийг хүлээж авах ямар аргыг илүүтэй сонгож байгааг тогтоох (амаар, бичгээр гм).
- Суралцагчдад ямар аргаар мэдээлэл өгөх хүсэлтэйг тодорхойлох.
- Суралцагчдад дараах чиглэлээр тусгай байгууллагуудын туслалцаа, ганцаарчилсан сургалтын стратеги шаардагдах эсэхийг тодорхойлох. Үүнд:
- Мэдээллийг хүлээн авах ба ангилж бүлэглэх (үгээр илэрхийлэхийн оронд өнгөөр тэмдэглэх гм.)
- Мэдээллийг хэзээ, хэрхэн ашиглахыг мэдэх (дохио тэмдэглэгээтэй карт, зураг тараах гм)
- Цагаа зохицуулж үйл явцыг дагаж мөрдөх
- Үр дүн буюу мэдээлэл гаргах
- Эрэмбэ дараалал шаардсан үйл явц, зорилгыг хангах (дохио өгөх, зураг бусад зохих арга хэрэгслээр хангах)
- Шаардлагатай үед бусад мэдрэхүйг ашиглах
- Хүрээлэн буй орчны орон зайг ашиглах, зүг чиг олох хэрэгцээг хангах
- Хүмүүсийн хоорондын харилцааны нөхцөл байдлыг тайлбарлаж ойлгох
- Бусдын зүгээс хэзээ тусламж, дэмжлэг хэрэгтэй болохыг тогтоох.

Оюуны ухааны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид

- Суралцагчдад ямар төрлийн туслалцаа удирдамж шаардлагатай болохыг тодорхойлох –чиглэл, зөвлөгөө, сануулга, олон удаа санал дүгнэлт гаргах, бодитоор үзүүлж таниулах, дадлага, хэд хэдэн хэсэгт задалж хуваасан даалгавар.
- Анги танхимд байхгүй үед нь ямар төрлийн туслалцаа дэмжлэг хэрэгтэй болохыг тодорхойлох. Жишээ нь сургалтын төв рүү ирэх ба буцахад, завсарлагын үеэр, хувийн ариун цэврийг сахих гм
- Суралцагчаас аль нэг зүйл хийхийг хүсэхдээ хэрхэн хийж гүйцэтгэх ёстойг харуулах буюу тайлбарлах.
- Хэрэв даалгавар нь хэд хэдэн хэсгээс бүрдсэн бол хэсэг тус бүрийг тайлбарлаад мэдэх чадах зүйлээ харуулах, дадлагажих боломжийг суралцагчдад олгох.
- Хариу санал дүгнэлтийг тодорхой ойлгомжтой хэлбэрээр цаг хугацаанд нь гаргах.
- Шаардлагатай үедээ даалгавар тус бүр дээр хэнээс тусламж авч болохыг суралцагчдад хэлж өгөх.

Тухайн нөхцөл байдал сургалтын орчин зэргээс хамаарч туслах үйлчилгээ, хангамж шаардагддаг олон төрлийн хөгжлийн бэрхшээл байдаг. Жишээ нь хөл гаргүй, эсвэл хуруугүй хүнд тоног төхөөрөмжийг зөв бөгөөд төвөггүй ажиллуулахын тулд зарим тохируулга, зохицуулалт хийх хэрэгтэй. Амьсгалын замын согогтой хүмүүс амьсгалах чадварт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй зарим орчноос зайлсхийх шаардлагатай байдаг. Тухайн хүнд зориулан ямар үйлчилгээ хангамж, зохицуулалт шаардлагатай болохыг тодорхойлохын тулд өөртэй нь ярилцах нь чухал юм.

3.6 Сургалтын туршид туслах хэрэгслэлийн тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх

Танай байгууллагын байранд орох боломжгүй бол суралцах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд зохих ёсны бодит өөрчлөлт оруулах хэрэгтэй. Зарим нь харьцангуй энгийн хялбар байх (анги танхим дотор тодорхой орон зай гаргах) ба Зарим нь нарийн төвөгтэй байж болох (ариун цэврийн өрөөнд шаардлагатай өргөтгөл хийх гэрээт гүйцэтгэгчийг олох, тэргэнцэртэй хүмүүст зориулж ажлын байран дахь сургалт явуулах газар олох гм) юм. Хүртээмжтэй хэрэгцээг судлаад түүнийг хэрэгжүүлэх цаг хугацаагүй бол хоёр асуудал танд тулгарна. Хэрэгжүүлэх хүртлээ тухайн хүний сургалтыг хойшлуулах, эсвэл түр хугацаанд өөр байдлаар шийдэх. Эдгээр нөхцөлд зохих бодлого, журам дүрэм байх ёстой. Бодлого, дүрэм журамд хэн ямар асуудал хариуцах хийсэн өөрчлөлтүүд, нөлөөлөх хүмүүст мэдэгдэх зэрэг асуудал туссан байх ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд туслах хэрэгслэлийн тусламж, үйлчилгээ шаардагдах хүмүүсийг үйл явцын бүх шатанд оролцуулах хэрэгтэй. Ялангуяа ямар туслах

хэрэгсэлийн тусламж үйлчилгээ хэрэгтэй байгаа, хийсэн өөрчлөлтүүд тохирч байгаа эсэхийг тогтооход тус дөхөм болно. Хүртээмжтэй үйлчилгээ нь анхнаасаа хичээлийн хэсэг байсан бол тэдгээрийн үүргээ гүйцэтгэж байгаа эсвэл өөрчлөх хэрэгтэй эсэхийг тогтоох үндсэн арга зам нь суралцагч ба багш хоорондын харьцаа байна.

Элсэлт, сургалт, ба үнэлгээний гурван үе шатанд хүртээмжтэй үйлчилгээ маш чухал ач холбогдолтой байдаг.

3.6.1 Сурталчлан таниулах, элсүүлэх, хүсэлт гаргах, хүлээн авах

Сурталчлан таниулах ба элсүүлэх

Оюутнуудыг одоо хэрхэн татаж байгаагаа авч үзэх. Суралцагчдыг эрж хайхад зарим нийтлэг арга зам байж болно:

- Сургуулиудаас
- Хэвлэл мэдээллээр сурталчлах замаар
- Ам дамжсан яриа
- Радио Телевизийн сурталчилгаа
- Интернет
- Хувь хүний сайн дурын лавлагаа
- Нээлттэй хаалганы өдөр, өдөрлөг
- Орон нутгийн удирдлага, суурийн газрын дарга нартай ажиллах
- Орон нутгийн захиргааны ажилтнууд, холбогдох яамдын албадтай ажиллах

Энэ нь элсэгчдэд хүрч ажиллах тохиромжтой аргууд ба олон төрлийн арга техник хэрэглэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэх магадлал өндөр байна. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй олон хүн гадуурхагдаж байсан үеийн сэтгэлгээгээр тэднийг хүлээн авна гэдэгт эргэлзэж байдаг. Иймд хөгжлийн бэрхшээлтэй оюутан элсүүлэхийн тулд тусгай арга хэмжээ авах хэрэгтэй болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэхийн тулд дэмжих бодлого, эсвэл урьж байгаа тухай тунхаглах явдал хангалтгүй юм. Сурталчилгааны тусгай арга зам шаардлагатай. Үүнд дараах аргууд байж болно:

- **Мэссэж-** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс танай сургалтын хөтөлбөрт хамрагдах сонирхол, итгэл үнэмшилтэй болж тэдэнд шаардлагатай дэмжлэг, үйлчилгээ хангагдах болно гэсэн санааг тодотгох ёстой.
- **Мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс, тусгай бүлгүүдээр дамжин хүрэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ерөнхий боловсролын тусгай сургуулиудад явах нь элбэг тул холбоо барих хаягуудын жагсаалтад нэмэх.** Хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг, сэргээн засалтын төв, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс цугларч уулздаг, нийгэмшдэг байгууллага, газруудад очих, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн, эцэг эх, асран хамгаалагчидтай нь холбоо тогтоох.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг засгийн газрын байгууллага, орон нутгийн захиргааны ажилтнууд, удирдлагууд, түүнчлэн тухайн орон нутгийн нийгмийн байдлыг сайн мэддэг албан бус удирдагчидтай уулзах.

- **Хэвлэл мэдээлэл.** Сурталчилгаанаас гадна элсэлтийн арга хэмжээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл (орон нутгийн радио, телевиз, сонин хэвлэл)-ийг ашиглах хэрэгтэй. Мэдээллийг гол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүргэсэн байх ёстой. Зарим оронд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан радио, телевиз, хэвлэлтэй байдаг тул үүнийг сургалтын сурталчилгаанд ашиглах нь чухал юм.

Сурагч элсүүлэх, хөтөлбөрөө сурталчлах зорилгоор ашиглах аливаа мэдээллийг нэмэлт эсвэл тусгай арга форматаар хийж түгээх шаардлагатай байдаг. Жишээ нь бэлэн байгаа материалыг цахим хэлбэрээр, том үсгээр хэвлэж, эсвэл дуу бичлэгээр тарааж болно. Ингэж тусгайлан бэлтгэсэн материалыг өөрийн оролцож байгаа *fairs* –д өдөрлөг, үзэсгэлэн худалдаагаар тарааж болно. Түүнчлэн танай төв рүү шууд хандаж болох ба энэ тохиолдолд хэрэгцээг хангаж шуурхай ажиллах нь чухал байдаг. Тухайлбал хувь хүний хүссэн материалыг хэвлэж өгөх, танилцуулга мэдээллийг илгээж болно. Хэлбэр форматаас гадна уг материал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг идэвхжүүлж сурах сонирхлыг нь татах, сургалтын явцад тэдний онцлог эрэлт хэрэгцээг хангахын төлөө анхаарч ажиллана гэдгийг тайлбарласан агуулгатай байх нь чухал.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс элсэх хүсэлт гаргахаар оффис, сургалтын байгууллагад ирэхэд нь бэлтгэлтэй байх хэрэгтэй. Дор дурдсан асуудлыг зохицуулах бэлтгэлтэй байх шаардлагатай.

- **Хөгжлийн бэрхшээлийн тухай мэдээлэл.** Хүмүүсийг угтаж авч үйлчилгээний талаар асуултад хариулах хүн бэлэн байх. Танай багууллагад харааны болон сонсголын бэрхшээлтэй ~~еул~~ хүмүүстэй харьцах чадвартай хүн ажиллах ёстой. Харилцах аргууд: бичгээр, и-мэйл хаягаар, эсвэл компьютер ашиглах (тухайн хүн, ажилтан хоёр нэг газарт байх нөхцөлд), эсвэл гар утсаар мессэж илгээх, дохионы ~~хэлний~~ хэлмэрчийн орчуулагчийн тусламжтайгаар хүлээн авах ажилтнууд сонсголын-бэрхшээлтэй хүн ирэхэд байгууллага дотор хэнд хандахаа мэддэг байх ёстой.
- **Бодит хүртээмж.** Энэхүү удирдамжид бодит хүртээмжтэй байдлыг хангах асуудлыг нарийн авч үзсэн. Сургалтын эхний үе шатанд ~~нь~~ хөдөлгөөний бэрхшээлтэй хүн холбогдох ажилтнуудтай очиж уулзах боломжийг та хангах үүрэгтэй. Мэргэжлийн сургалтын асуудлаар нээлттэй хаалганы өдөр гэх мэт арга хэмжээ зохион байгуулахдаа тээврийн хэрэгслээр хангах арга хэмжээг урьдчилан хэрэгжүүлж бэлтгэл хангах ёстой. Аюулгүй, хүртээмжтэй байдлыг

хангах үүднээс барилга дотор хариуцсан хүн томиж гол хаалга хаана байрлаж байгааг зааж өгөх хэрэгтэй. Аливаа арга хэмжээг хүртээмжтэй байранд зохион байгуулах шаардлагатай болно. Төдийлөн зохимжтой гэж үзэхгүй арга хэлбэр бол хүрч чадах газарт нь очиж уулзаад мэдээллийг танилцуулах явдал юм.

Жишээ нь: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургалтад хамруулахын тулд тэдэнтэй хүрч ажиллах зорилгоор Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Байгууллага (ХБХБ)-тай хамтран ажиллах нь хамгийн түгээмэл арга юм. Зарим ХБХБ идэвхтэй бүтээлч ажилладаг ба зарим аргууд нь соёл зан заншлаар тодорхойлогдсон байдаг. Жишээ нь Руанда дахь институтууд оролцоог илүү хангадаг болж эхлэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ам дамжсан яриагаар мэдээлэл хүрсэн байсан хэдий ч, институтээс тусгай сургалчилгааны арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна. Харин ХБХБ-аас сургалтын оролцооны арга хэмжээг дэмжиж, хүн амын дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, боломжийн тухай ойлголт мэдлэг олгох талаар арга хэмжээ авч ажилласан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургалтын үйл явцад оролцуулахгүй байх явдлын нийгэм - эдийн засгийн сөрөг үр дагаврыг харуулсан, мөн уламжлалт ажил үүргийг ердийн бус, уламжлалт бус арга замаар хэрхэн гүйцэтгэж болдог тухай театрчилсан үзүүлбэр зохион байгуулсан байна. Жишээ нь, нарийн бичгийн даргын ажил хийдэг гаргүй хүн хөлөөрөө компьютер дээр ажиллаж байгааг харуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадвар чадавхи нь тухайн нутгийн иргэдэд өндөр сэтгэлдэл төрүүлж Руандагийн сургалтын төвүүдийн оролцоог хангах зорилтоо хэрэгжүүлэхэд түлхэц болсон байна.

Хүсэлт гаргах ба элсүүлэх

Элсэх хүсэлт гаргагчдын хувьд үйлчилгээ, хангамжийн талаар үүсч болох асуудлууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн өргөдлийн маягт авах, бөглөх, хугацаанд нь буцааж өгөх чадвар байгаа юу? Зарим тохиолдолд, танай ажилтнууд тусалж болох юм. Нээлттэй хаалганы өдөр, өдөрлөг гм үеэр. Хэрэв та орон нутгийн захиргаа, нийгмийн холбоо сайтай, сайн дурын туслагч нартай холбоотой, элсэлтийн ажлыг зохицуулах, шаардлагатай үед хөгжлийн бэрхшээлтэй хүсэлт гаргагчидтай хүрч ажиллах үүрэг бүхий ажилтнуудтай бол саад бэрхшээл тулгарахад асуудлыг шийдвэрлэх танай бололцоо өндөр байх болно.

Хүсэлт гаргасан хүмүүсийн талаар үнэлгээ дүгнэлт гаргахдаа сурах чадвартай, сургалтын явцад өгсөн даалгаврыг гүйцэтгэж чадах хүнийг хөтөлбөртөө элсүүлж оролцуулах сонирхолтой байна. Албан ёсны сургалтын хөтөлбөрт дүн, үнэмлэх, сертификат зэрэг шалгуурыг шаарддаг. Мөн хөндлөнгөөс тодорхойлох хүмүүстэй уулзах, хөдөлмөрийн намтарыг нь үзэх, зарим ур чадвар, чадавхийг нь тестээр шалгах, хүсэлт гаргачтай ярилцлага хийх гм арга байж болно. Танай үйл явц хүсэлт гаргагчийг ялган гаргаж байгаа эсэхийг харах хэрэгтэй.

Эхлээд элсэлтийн шаардлага, шалгуураа хянаж үз. Эх үүсвэр, үндэслэл нь юу вэ? Суралцагчийн эзэмших мэргэжилд хамааралтай эсэх? Хөтөлбөрийг амжилттай төгсөхийг урьдчилан төсөөлөх үндэслэл болж чадах эсэх?

- Анхааралдаа авч болох элсэлтийн үндсэн гурван шалгуур байна. Боловсролын тодорхой түвшин, ажлын туршлага, мөн унших, бичих, тоо бодох чадвар. Хөгжлийн бэрхшээлтэй зарим хүсэлт гаргагчид дипломгүй, ердийн боловсролын системд суралцах боломжгүй, зарим нь ажил хийж байгаагүй, эсвэл тусламж авалгүйгээр уншиж бичиж, тоо бодож чаддаггүй байж болно. Энэ хүмүүсийн талаар та ямар шийдвэр гаргах вэ?
- Хэрэв элсэх хүсэлт гаргагч нь тодорхой түвшний боловсролгүй, та тэдний чадварын талаар эргэлзэж байгаа бол тэднээс шаардлагатай түвшинд уншиж, бичиж, тоо бодож чаддагаа харуулахыг хүсэх нь зүй ёсны шаардлага байна. Ийм бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадварыг нь шалгахдаа шаардлагатай үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй.
- Брайлиар “унших”, эсвэл бичмэл материалыг уншиж өгөхөд ойлгох, Компьютер дээр “бичих” эсвэл өөр хүнд хэлж бичүүлэх, тооны машинаар “тоо бодох” гм бусад даалгавар.

Жишээ нь: Иракийн сургалтын хөтөлбөрийг илүү оролцоотой болгоход Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс тусалцаа үзүүлсэн юм. Тэр үед нийт элсэгчид анхан шатны боловсролтой байх ёстой гэсэн шаардлагыг хянаж үзсэн байна. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр ийм шаардлагыг тэр бүр хангаж чаддаггүй. Ингээд түүний оронд унших, бичих шаардлага нэмж оруулсан ба энэ нь хөгжлийн бэрхшээлтэй олон хүн хамрагдах боломжийг нээж өгсөн.

Энэ тохиолдолд бичиг үсгийн талаар тавигдах стандарт шаардлагыг орхигдуулаагүй. Сургалтын тогтолцоондоо унших, бичих чадваргүй хүмүүст нэмэлт сургалт зохион байгуулах үйлчилгээг нэвтрүүлж шаардлага хангах хүртэл нь сургаж болно.

Жишээ нь: АНУ-ын Хьюстоны Орон Нутгийн Коллеж олон чиглэлээр мэргэжлийн сургалт явуулдаг ба унших, бичих чадвар, математикийн мэдлэгээрээ элсэлтийн шаардлага хангаагүй хүмүүст (хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг харгалзахгүй) Коллежийн тусгай курсэд суралцах боломж олгодог байна. Мөн сурах чадварын курсэд шалгалт өгөх, тэмдэглэл хийх, зорилго тодорхойлоход суралцдаг байна. Үүнээс гадна, Мэргэжлийг Зүгшрүүлэх ба Ур Чадварын Сургалтын ангиудад (МЗУЧС) оюун ухааны бэрхшээлтэй суралцагчид ч нэмэлт дэмжлэг тусалцаа авч үндсэн эрдмийн, нийгмийн, харилцааны ба компьютерийн ур чадвараа дээшлүүлэх боломжтой байдаг.

Ажлын туршлагын хувьд элсэх хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийх чадвартай хэдий ч хязгаарлагдмал бололцоо, тээврийн гачигдал зэргийн улмаас хэзээ ч ажиллаж байгаагүй байж. Ярилцлагын явцад та ажилтай холбоотой хийсвэр жишээ өгч ажил хийх явцдаа хүмүүсийг ажиглаж асуудал шийдвэрлэх, үнэлж дүгнэх чадвар, биеэ авч яваа байдлын талаар ойлголт авч болно. Эсвэл та түншийн холбоотой ажил олгогчтой тохирсоноор тодорхой хугацаанд ажил хийлгэх, эсвэл дадлагын газар тухайн хүнийг ажиглаж сургалтын хөтөлбөрт элсүүлэх эсэхээ шийдэж болно. Ярилцлагын үеэр суралцагчтай ярилцаж шалгалт, хичээлийн үеэр ямар нэмэлт дэмжлэг тусламж шаардагдахыг тодорхойлж болно.

Үнэлгээний явцад өөр тест, арга хэрэгслийг ашигласан бол энэ гарын авлагын тестийн хэсэгт дурдсан тусламж дэмжлэг хангамж үйлчилгээг хамааруулан хэрэглэх боломжтой.

Оюутныг элсүүлсэн тухай мэдэгдэл өгөх нь энгийн ажилбар юм. Гэхдээ энд бас тусгай хэрэгсэлийн тусламж шаардагдаж мэднэ. Хэрэв тухайн хүн хараагүй гэдгийг мэддэг бол угсаар ярьж баяртай мэдээг дуулга. Шинэ элсэгчдэд мэдэгдлийн захидал илгээж түүндээ хичээл эхлэхээс өмнө хийвэл зохих зүйлс: хэрхэн бүртгүүлэх, чиг баримжааны арга хэмжээнд хэзээ оролцох гэх мэт мэдээлэл өгч болно. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлийн газар очиж бүртгүүлж чадах эсэх, чиг баримжааны арга хэмжээнд үр дүнтэй оролцож чадах эсэхийг магадлах ёстой.

3.6.2 Заах үйл явц

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохих хангамж үйлчилгээг бүрдүүлэх сургалтын арга барилын жишээнүүдийг энэ бүлэгт дурдсан байгаа. Боломжтой бол сургалтаас өмнө туслах хэрэгсэлийг бэлэн болгосноор бүх хүний хувьд зөрчилтэй, цэгцгүй байдлыг багасгана. Төлөвлөлт, элсэлтийн явцад хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүн хөтөлбөрт хамрагдахаар элсээд байгааг мэдсэнээр тэдэнд шаардагдах туслах хэрэгсэлийн талаар мэдээлэлтэй болно. Тухайлбал, бүрэн хараагүй оюутнууд компьютерийн ангид элсэхийг мэдэж байхад хэл ярианы зохих программ бэлэн байлгах ёстойг анхаарна.

Хөгжлийн бэрхшээлтэй олон хүнд нэмэлт тусламж үйлчилгээ шаардагдахгүй. Тэдэнд нэг удаагийн зарим зохицуулалт шаардагдаж болно: гагнуурын аппаратын баруулыг өөрчлөх, дадлагын байрнуудын хооронд явах илүү цаг, эсвэл аль нэг зүйлийг хөдөлгөөнгүй барьж наах хэрэгсэл гм. Эдгээр гурван жишээнд дэвшүүлсэн асуудлуудыг сургалт эхэлж суралцагчдад хэрэг болохоос өмнө зохицуулагдсан байвал зохино. Зарим суралцагчдад нэмэлт туслах хэрэгсэл байнга шаардагдаж болно. Том үсгээр хэвлэсэн материалыг хичээл эхлэхээс өмнө тараах, тэмдэглэл хөглөх хүн гм. Дурдсан бүх жишээнүүдэд хэрэгцээ шаардлага үүсэхээс өмнө тэр тухай мэдэж байх шаардлагатай гэсэн санаа агуулагдаж байгаа. Бусад тохиолдолд ямар туслах хэрэгсэл оюутанд шаардлагатай болох, сургалтын явц өөрчлөгдөхийн хэрээр ямар эрэлт хэрэгцээ шинээр бий болохыг урьдчилан мэдэх хэцүү байж болно. Гэсэн хэдий ч боломжтой хэмжээнд тооцож төлөвлөх хэрэгтэй юм.

Урьдчилан төлөвлөхөөс гадна, нөхцөл байдлын талаар хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай хэлэлцэж ярилцах шаардлагатай, учир нь тэд өөрсдийн эрэлт хэрэгцээний талаар хамгийн сайн мэдээлэлтэй байна. Зарим тохиолдолд тэд хамгийн сайн туслах хэрэгсэлийг мэдэхгүй байж болох талтай. Энэ нөхцөлд таны асуултууд болон мэдлэг, идэвх санаачлага чухал үүрэгтэй байх болно. Зарим ажил олгогчид сургууль дээр туслах хэрэгсэлийн бүртгэл хөтөлдөг тул тэд ямар тохиолдолд тохиромжтой байсан, ямар нөхцөлд үүргээ гүйцэтгэж чадаагүй тухай мэдээлэлтэй байдаг. Ийм бүртгэлд үндэслэн адил төстэй бэрхшээлтэй суралцагчийн асуудлыг шийдэх тодорхой санал гаргаж болно.

Өөрсдийгөө хөгжлийн бэрхшээлтэй болохыг мэдээгүй оюутнуудтай ч таарах тохиолдол байна. Жишээ нь, сурах чадварын зарим хөгжлийн бэрхшээл нь: мэдээллийг боловсруулах, хадгалах, санаж дамжуулан уламжлах гм төдийлөн мэдэгдэхгүй явагдах тал бий. Ийм оюутнуудтай уулзаж асуултаа анхааралтай тавьж зөвлөлдөх замаар тэдний хэрэгцээг тодорхойлж болно. Хавсралт 1-д өгсөн зохиомжийг суралцагчидтай уулзахдаа ашиглаж тэдний туслах хэрэгсэлийн хэрэгцээг тодорхойлж болох юм.

Хөтөлбөрийн цар хүрээ, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тооноос хамаарч туслах хэрэгсэлийг хариуцсан зохицуулагчийг томилж болно. Тэр нь суралцагч ба багштай ажиллаж тусламж үйлчилгээг бүрдүүлэх, шинэчлэн өөрчлөх зэргээр зохицуулж суралцагч хичээлийн явцдаа бүрэн оролцох боломжийг хангана.

Жишээ нь: Мэргэжлийн сургууль, коллежүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээг хариуцсан алба байгуулж ажиллуулах туршлага олон оронд түгээмэл болсон байна. Канадын Онтарио дахь Сенег Коллежийн Хөгжлийн Бэрхшээлийн Үйлчлэх Албанаас нэмэлт туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээ шаардлагатай гэж үзэж байгаа оюутнуудад шийдвэр гаргахад тусалдаг байна. Тус коллеж 1,700 мэргэжлийн курс ажиллуулдаг ба коллежийн оюутнуудын 10 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд байна. Руандагийн Кидалийн Боловсролын Институт нь Боловсролын Яамны тусламжаар харааны бэрхшээлтэй оюутнуудад зориулсан туслах төв байгуулж орон нутгийн мэргэжлийн сургалтын байгууллагууд, дээд сургуулийн оюутнууд тусгай программ хангамж, туслах хэрэгсэл ашиглах ба мэргэшсэн боловсон хүчний туслалцаа авах боломжтой болсон байна.

3.6.3 Үнэлгээ ба шалгалт, тест

Шалгалтын үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх туслах хэрэгсэлийн үйлчилгээний стратегийг боловсруулж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохих ёсоор хандах, ур чадвар, мэдлэгээ бүрэн харуулах боломжийг бүрдүүлэх нь чухал. Шалгалт тест тус бүрээр тухайн суралцагчийн туслах хэрэгсэлийн үйлчилгээний асуудлыг тодорхойлсон (үндэслэсэн гм), баталсан ба бүрдүүлсэн болохыг бодлого, журамдаатодорхойлж өгөх ёстой. Шалгалтын үйл явцад аливаа өөрчлөлт оруулах нь шалгалт үнэлгээний нэгдмэл шинжийг алдагдуулна гэсэн үзэл байж болно. Иймд, мэргэжлийн магадлал сертификатчлал хийгдэх нөхцөлд суралцагч бүр

зохих стандартын шаардлагыг хангах зарчмыг баримтлах нь зүйтэй. Гэхдээ ихэнх тохиолдолд хангамж үйлчилгээ нь систем дотроо хангагдах боломжтой байдаг

Хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд туслах хэрэгсэл шаардлагатай эсвэл шаардлагагүй суралцагчдыг бусад суралцагчдын нэгэн адил шалгуураар үнэлж дүгнэх ёстой. Хүмүүсийн юу мэдэх, юу хийх чадвартайг шалгахын тулд тодорхой туслах хэрэгсэл шаардагдаж болно – хүрээлэх орчинд тохируулга, зохицуулалт хийх, формат өөрчлөх, гүйцэтгэлийн талаарх зохицуулалт, хөдөлгөөний хурдыг уян хатан тогтоох гм. Гол нь суралцагчийн юу мэдэж байгааг тодорхойлох нь таны зорилго ба үүнийг хэр хурдан эсвэл хэрхэн тогтоох асуудал тийм чухал биш юм. Эсвэл та суралцагчийн юу хийх чадвартайг мэдэх шаардлага гарсан тохиолдолд тухайн хүн чадвараа харуулах нэгээс илүү арга хэлбэр байж болдог. Харин ямар хурдтайгаар гүйцэтгэх нь танд төдийлөн ач холбогдолгүй байж болно. Гэхдээ зарим тохиолдолд хурд ач холбогдолтой байх тохиолдол байна.

Орчны зохицуулалтын жишээ

Хөгжлийн бэрхшээлтэй зарим хүмүүст шалгалтын байршлыг өөрчлөх, гэрэлтүүлгийг нэмэх, бууруулах, өөр гэрэлтүүлэгтэй болгох, ажлын болон шалгалтын ширээний өндрийг өөрчлөх, дадлагын ажлын тест авахдаа протез, ширээн дээр цаас тогтоох туслах хэрэгсэл ашиглах өөр хүн цаасны хуудсыг нь эргүүлж өгөхийг зөвшөөрөх

Формат өөрчлөх жишээ

- Хэвлэх машины тохируулга – хэмжээ, зай, өнгө гм
- Унших төхөөрөмж ашиглахыг зөвшөөрөх
- Бичлэг хийхийг зөвшөөрөх
- Дохионы болон туслах хэрэгсэлийг зөвшөөрөх
- Гүйцэтгэлийн зохицуулалт
- Хүний юу хийж чаддагийг шалгахдаа бичиж харуулахаас илүү хийж үзүүлэхийг зөвшөөрөх

Хариултыг нь тэмдэглэх хүний тусламж авах эсвэл дуу дүрс бичлэгийн төхөөрөмж, тооны машин, харилцаа холбооны хэрэгсэл, компьютер эсвэл бусад тусгай хэрэгсэл (оёдлын машины даавуу чиглүүлэгч гэх мэт) ашиглаж даалгавраа хийж гүйцэтгэх боломж олгох.

Хүрдцын уян хатан байдлын жишээ

- Тестийн үргэлжлэх хугацааг өөрчлөхийг зөвшөөрөх
- Шалгалтын үеэр завсарлага хийхийг зөвшөөрөх
- Харьцангуй урт хугацаанд шалгалт өгөхийг зөвшөөрөх, хоёр өдөрт гэх мэт

Шалгалтын зарим асуудлаар санамж дэмжлэг өгөх

Суралцагчийн ажлыг дүгнэхдээ бусад бүх суралцагчидтай адил шалгуурыг хэрэглэх. Тухайлбал чанар, тоо хэмжээ, хурд гм. Энэ хүрээнд үнэлж дүгнэх үүрэгтэйн хувьд сургагч багш нар шаардлагатай бусад зохицуулалтын талаар шийдвэр гаргах ерөнхий зарчмыг баримтална.

3.7 Багш, удирдах ажилтнуудын анхааралд

Энэхүү бүлэгт суралцах, зааж сургах үйл явцтай холбоотой асуудлыг авч үзсэн ба зорилго нь сургагч багш нарт чиглэгдсэн юм. Гэхдээ удирдах ажилтнууд ба ажил олгогч, бизнес эрхлэгч зэрэг туслах багш нартай ажиллах бусад хүмүүст мөн чухал байдаг. Учир нь ажил олгогчдыг сургалтын үйл явцад татан оролцуулахдаа энэ бүлэгт тусгасан асуудлыг уламжлан хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Харин хэнд ийм үүрэг хариуцуулах тухай шийдвэрийг удирдах ажилтан гаргах эрхтэй байна.

Эдгээр асуудлуудын ихэнх нь бодлогод өөрчлөлт оруулах, эсвэл байгууллага, хөтөлбөрийн ажилтнуудын зүгээс гарах эсэргүүцэлтэй тулж ажиллах асуудалтай холбоотой байдаг. Жишээ нь, энэ бүлгийн хэд хэдэн хэсэгт бодлогын тухай авч үзсэн ба удирдах ажилтнууд бусад ажилтнуудтай хамтран шалгалтын болон бусад нөхцөл байдалд баримтлах бодлого боловсруулах шаардлага гарч болно.

Туслах хэрэгсэлийн үйлчилгээг зохион байгуулах ажилд хөрөнгө шаардагдана. Анги танхим, хөтөлбөрийг хүртээмжтэй болгож зохион байгуулахын тулд мэдлэг санаачлагатай удирдлага хэрэгтэй. Энэ бүлэгт хавсаргасан хоёр асуулга нь сургалтын өмнө ба сургалтын үеэр шаардагдах хангамж үйлчилгээг хэрхэн тодорхойлох талаар танд удирдамж болох юм.

3.8 Дүгнэлт

Энэ бүлэг нь сурах, суралцах үйл явцад чиглэсэн ба мэдээлэл нь хэрхэн мэдлэг болж хөвөрдөг, мэдлэг олох явцыг дэмжих стратеги, хөгжлийн бэрхшээлийн онцлог ба туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээ хаана, хэзээ хэрэгтэй болох асуудлуудыг авч үзсэн. Ийм мэдээлэлтэй байснаар та хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг (суралцах хүсэлт гаргагчид ба суралцагчид) энгийн суралцагчидтай адил нөхцөлөөр хангахад чиглэсэн стратегийн талаар оновчтой сонголт хийх боломжтой юм.

Нийгмийн оролцоог хангах нь сургалтын болон ажлын орчинд амжилтад хүрэх чухал хүчин зүйл юм. Энэ асуудлыг дараагийн бүлэгт авч үзнэ.

Хавсралт 1

Туслах хэрэгсэлийн үйлчилгээний хэрэгцээг сургалт эхлэхээс өмнө тодорхойлох зорилгоор ашиглаж болох асуултын жишээ.

Туслах хэрэгсэлийн үйлчилгээг төлөвлөх үндэс суурь				
Хүсэлт гаргагч, элсэгчидтэй хийх анхны ярилцлагын үеэр удирдах ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй оюутны зөвлөл ба томилогдсон бусад ажилтнууд ашиглаж болно. Ярилцлагын дэг: Манай хөтөлбөр (эсвэл сургалтын байгууллагад) таны оролцоог хэрхэн эерэг туршлага болгох талаар ярилцах уу? [Хөтөлбөрөө тайлбарла, ялангуяа суралцагчдын зүгээс хийвэл зохих зүйлсийг танилцуул. Суралцагчийг дагуулж танилцуул эсвэл дүрс бичлэг үзүүл.] Амжилттай суралцахын тулд танд нэмэлт туслах хэрэгсэлийн үйлчилгээ шаардагдах эсэх, тийм бол ямар туслах хэрэгсэл шаардагдахыг тодорхойлоход та бидэнд тус болох зарим асуултад хариулж өгнө үү. Тайлбар: Тухайн орон нутаг, сургалтын нөхцөл байдлаас хамаарч тээврийн холбогдолтой асуулт, хэрэв дотуур байртай буюу байраар хангах боломжтой бол тэр тухай асуултууд нэмж болно. Туршлага хуримтлуулахын хэрээр та хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хэрэгцээнд нийцэх туслах хэрэгсэлийн үйлчилгээг тодорхойлоход тань тус дөхөм болох өөр асуултууд нэмж болно.				
Тийм	Үгүй	Асуултууд	Ярилцлагыг үргэлжлүүлэхэд тус дэм болох арга, санаанууд	Авсан арга хэмжээ
		Лекц, танилцуулгын үеэр чухал мэдээллийг хүлээн авч ялган тогтооход танд юу тус болох вэ?	Боломжтой дэмжлэг: дуу хураагуур, тэмдэглэл хөтлөгч, компьютер	
		Та тэмдэглэл хөтөлж чадах уу?	Танд бид хэрхэн туслах вэ? Боломжтой дэмжлэг: Дээрхийн адил	
		Лекц, хичээлийн үеэр дараах асуудлын аль нэг нь танд ойлгоход бэрхшээлтэй байх уу? Багшийн ярьж байгаа зүйл, бусад суралцагчдын хэлж байгаа зүйл, дэлгэцэн дээрх мэдээлэл г.м?	Танд хүндрэлгүй болгохын тулд бид юу хийвэл зохих вэ? Боломжит дэмжлэг: Урд эгнээнд суулгах, хичээлээс өмнө хичээлийн тэмдэглэл өгөх, гол санаануудыг бичгээр буюу амаар танилцуулах	

Тийм	Үгүй	Асуултууд	Ярилцлагыг үргэлжлүүлэхэд тус дэм болох арга, санаанууд	Авсан арга хэмжээ
		Үзүүлэн танилцуулах үеэр та сонсож, харж ойлгож чадах уу? Танд хүндрэлгүй болгохын тулд бид хэрхэн туслах вэ?	Боломжтой дэмжлэг: Үрд суух, сонсголын аппарат зүүх, багш өөдөөс чинь харж дэлгэцэн дээрх танилцуулгын үеэр юу хийж байгаагаа хэлж байх (байдлаас хамаарна)	
		Хичээл дээр асуултанд хариулж чадах уу? Хариулахын тулд танд ямар нэг хангамж үйлчилгээ хэрэгтэй юу?	Юу хийж болох вэ? Боломжтой дэмжлэг: Та хариултаа бичээд хэн нэг нь түүнийг унших, хариултад хугацаа өгөх	
		Хичээлийн хөтөлбөрөөр танаас дараах зүйл гүйцэтгэхийг хүснэ (даалгаврыг тайлбарлах: үүнд биеэр гүйцэтгэх, өргөх, бөхийх, зогсох, тоног төхөөрөмжийн тусгай хэсгүүдийг ажиллуулах)	Туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээний боломжит дэмжлэг нь тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, онцлог, сургалтын чиглэл зэргээс хамаарна.	
		Энэ нөхцөлд тусламж хэрэгтэй юу? Сургалтын энэ хэсэгт тусгай хангамж үйлчилгээ шаардагдах уу?		
		Анги дотор хаана суухыг хүсч байна вэ?	Энэ нь танд дэмжлэг болов уу?	
		Багаар ажиллахад дуртай юу?	Үгүй бол, багаар ажиллахад танд ямар дэмжлэг хэрэгтэй вэ?	
		Шалгалт өгөхийн тулд танд тусламж хэрэгтэй юу? Тийм бол ямар?	Бид хэрхэн шийдвэрлэж чадах вэ? Боломжтой шийдлүүд: шалгалтын асуултуудыг өөр форматаар бэлтгэх, илүү цаг өгөх, хариултыг тань тэмдэглэх хүн, эсвэл хуурцаг г.м	

Хавсралт 2

Сургалт эхэлсний дараа туслах хэрэгсэлийн үйлчилгээг тодорхойлоход чиглэсэн асуултууд ба ярилцлагын дэг

Сургалтын орчинд шаардагдах тусламж үйлчилгээг тодорхойлох үндэслэл

Сургалт эхлэхийн өмнө эсвэл эхэлсний дараа ямар тусламж үйлчилгээ шаардагдахыг тодорхойлох зорилгоор багш, ажилтнууд ашиглаж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад юу гэж хэлэх вэ? Миний хичээлд хөтөлбөр (эсвэл сургалтын байгууллагад) дахь таны оролцоог эерэг туршлага болгох талаар ярилцах уу? Хичээлийн талаар танилцуул. Хичээл дээр цагаа дараах байдлаар хуваарилах болно (дадлагын газар, ажлын байранд байх тодорхой хугацаа заах г.м). Суралцагчын хөдөлмөрийг ингэж үнэлдэг (мэдээллээ өгөх). Ингээд амжилттай суралцахын тулд танд тусламж үйлчилгээ шаардагдах эсэхийг тодорхойлоход та бидэнд туслах асуултуудад хариулаарай.

Тайлбар: Эдгээр асуултууд нь сургалтын орчинд бэрхшээлтэй тулгарч байдаг хүмүүст хэрэгтэй байж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах туршлага хуримтлуулж сургалтын нөхцөл байдалд ямар тусламж үйлчилгээ шаардагдах талаар илүү сайн ойлгохын хэрээр та уг жагсаалтад асуултууд нэмж болно.

Шийдвэр гаргахад танд тус болох асуултууд ба хэнд хамгийн их ашиг тустай байх вэ?	
Асуултууд	Арга хэмжээ/Шаардагдах туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээ
Сургуульд сурч байхад танд ямар бэрхшээлтэй асуудлууд тулгарч байсан бэ? Ямар арга хэмжээ авч байсан бэ?	
Миний хичээл дээр чухал мэдээллийг ойлгож ялган тодорхойлоход танд ямар туслах хэрэгсэл хэрэгтэй вэ?	
Та өөрөө тэмдэглэл хөтөлж чадах уу?	
Хичээл, лекц, танилцуулгын үеэр танд аль зүйл бэрхшээлтэй байх вэ? Миний хэлсэн мэдээлэл, бусад суралцагчдын хэлсэн зүйл, шохойгоор бичсэн зүйл, дэлгэцэн дээр проектороор тусгасан мэдээлэл г.м? Бидний зүгээс юу хийвэл танд бэрхшээлгүй байх вэ?	

Асуултууд	Арга хэмжээ/Шаардагдах туслах хэрэгсэлийн тусламж үйлчилгээ
Хичээл дээр танд тавьсан асуултад хариулж чадах уу? Хариулахын тулд танд аливаа туслах хэрэгсэл шаардлагатай болох уу?	
Миний хичээл дээр та хаана сүүх сонирхолтой байна вэ?	
Та хичээл дээр тусгай хэрэгсэл (гар тооны машин, компьютер, дуу хураагуур) ашиглахыг хүсч байна уу?	
Та багаар ажиллах сонирхолтой юу?	
Танд шалгалт яаж өгвөл илүү тохиромжтой вэ? Шалгалт өгөхөд танд аливаа тусламж үйлчилгээ шаардлагатай юу? Тийм бол ямар?	
Та сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийг ашиглаж чадах уу? Ашиглахын тулд тусламж үйлчилгээ хэрэгтэй юу?	
Та сургалтын агуулгын дагуу суралцагчдаас гүйцэтгэхийг шаарддаг зүйлсийг хийж чадах уу? Танд тусламж хэрэгтэй болох уу?	
Асууж ярилцахыг хүсч байгаа зүйл байна уу?	



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

НИЙГМИЙН ОРОЛЦООНЫ АСУУДАЛ

4.1 Зорилт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хангамж үйлчилгээ бодит хүртээмжтэй байхаас гадна анги танхим, дадлагын газар, төвийн ажилд оролцож чадаж байна гэсэн мэдрэмж чухал байдаг. Энэ бүлгийн зорилт нь нийгмийн оролцоог дэмжихэд тус болох гурван хүчин зүйлийг танилцуулахад оршино.

1. Нийгмийн оролцоог дэмжих харилцан үйлчлэл\нөлөөлөл
2. Нийгмийн оролцоог дэмжих нөхцөл байдал\хүрээ
3. Хөгжлийн бэрхшээлийн ёс зүй

4.2 Нийгмийн оролцоог дэмжих харилцан үйлчлэл\нөлөөлөл

Нийгмийн эерэг харилцан үйлчлэлийг дэмжиж нийгэмшүүлэх замаар нийгмийн оролцоог хөгжүүлэх нь бүгдийг хамарсан, оролцоо бүхий сургалтын орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэ нь сургалтын дараах амжилтад шууд нөлөө үзүүлдэг. Ажил олгогчдын дунд бусадтай харилцах чадвартай ба техникийн бус “софт” мэргэжлийн хүмүүсийг ажилд авахыг илүү сонирхох болсон. Суралцагчдын ихэнх нь ажил дээрээ хамт олонтойгоо, дарга удирдлагатай, үйлчлүүлэгчидтэй, олон нийттэй харилцаанд орох шаардлагатай байдаг. Хувиараа хөдөлмөр эрхэлдэг зарим нь худалдан авагч, үйлчлүүлэгч, бараа нийлүүлэгч зэрэг түншүүдтэй шууд тулж ажиллах\харилцах шаардлагатай байдаг тул тэдэнд нийгэмших ур чадвар чухал гэж үздэг.

Ангид, дадлагын газарт та тодорхой байр суурь, нэр хүндтэй хүн, дүр төрхийн загвар байдаг. Суралцагчид таны үйлдэл биеэ авч явах байдлыг даган дууриах хандлага өндөр, иймд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ангид, дадлага дээр хэрхэн харьцаж байгаа нь оролцооны ерөнхий орчин, сургалтын хүлээн зөвшөөрөгдсөн байдал, нийгмийн нөхцөлд чухал нөлөөтэй байдаг. Бусдын хувьд та үлгэр дууриал болох эерэг загвар байх олон хэлбэрийн бололцоо байна.

4.3 Нийгмийн оролцоог дэмжих нөхцөл байдал

Суралцагчид танай төвд ирэхдээ бие биенээ урьд нь мэддэг байж болно. Гэсэн хэдий ч, олон оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэргэжлийн сургалтын төвд элсэхээс өмнө өөр өөр боловсролтой байдаг ба ийм нөхцөлд хоорондоо танил байх магадлал бага юм.

Нийгэмшүүлэх энгийн арга хэмжээ, сэдэвчилсэн үйл ажиллагаа зохион байгуулахад хүмүүс хоорондоо танилцан ойртож улмаар хичээл дадлагын үеэр, ялангуяа танай

төвийн сургалт багаар ажиллах зарчимд түшиглэсэн бол, илүү үр дүнтэй ажилладаг байна. Нийгмийн оролцоог сургалтын эхний үе шатанд дэмжих нь чухал ба энэ ажлыг сургалтын туршид түүгээр зогсохгүй сургалтын дараа үргэлжлүүлж болох ба ингэснээр төгсөлтийн дараах амжилтыг ажиглах чухал үр дүнтэй юм.

4.4 Хөгжлийн бэрхшээлийн ёс зүй

Ёс зүй гэж бид бусад хүмүүстэй хэрхэн харьцаж байгаа тухай ойлголт юм. Та зөв төлөвшилтэй бол хүмүүсийг хүндэлж эерэг байдлаар харьцана. Хэрэв төлөвшил муутай бол хүмүүсийг гомдоож, уурлуулна, магадгүй тэд холдон явна. Хөгжлийн бэрхшээлийн ёс зүй нь бид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хэрхэн хандаж харьцаж байгаа тухай асуудал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцахдаа бид зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлийн асуудалд хэт анхаараад бусад талаараа зохисгүй хандлага гаргаж байдаг. Ингэж хандвал бид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдаас маш их ялгаатай гэж хардаг. Тэднийг жирийн хүн гэж хүлээн авахаас илүү өрөвддөг, жийрхдэг эсвэл зарим зүйлийг хийж гүйцэтгэх чадваргүй гэж ойлгох тал бий.

Ийм мэдрэмжийн тухай та мэддэг, өөрөө тулгарч байсан, эсвэл бусдын жишээн дээр ажиглаж байсан бол оролцоог хөгжүүлэх замд маш том саад бэрхшээл учруулахыг ойлгож байгаа. Энэ бэрхшээлийг арилгах олон арга зам бий. Ийм мэдрэмжийг арилгах, даван туулах хамгийн үр дүнтэй аргын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хувь хүнийх нь хувьд үнэлэх, бусдын нэгэн адил хүн эсвэл удирдагч болохыг хүлээн зөвшөөрөх явдал юм. Орон нутгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Байгууллагуудад очиж тодорхой хугацааг өнгөрөөх, эсвэл төвөө ирж үзэхийг урьж болно. Өөрийн таньдаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдэнтэй тогтоосон харилцааныхаа тухай сана. Өөрийн хүндэлж явдаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэйгээ уулзаж аль нэг хэлбэрээр ажилдаа оролцохыг санал болгох хэрэгтэй.

4.5 Багш, удирдах ажилтнуудын анхаарал

Төсвийн боломжтой бол та удирдагчийн хувьд нийгмийн харилцаа холбооны асуудлыг, ялангуяа өнөө үед эрэлт хэрэгцээ нь улам ихээр өсч байгаа нийгмийн “софт” ур чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг тул, сургалтын ерөнхий үйл явцын нэгэн хэсэг болгон нэгтгэх шаардлагатай. Энэ үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцох боломжтой байх ёстой.

Мөн удирдагчийн хувьд та дарамтлах, доромжлох асуудлыг зохицуулах бодлогоо анхаарах хэрэгтэй. Ийм бодлого байгаа бол хөгжлийн бэрхшээлийн асуудлыг бусад асуудлын нэгэн адил зохицуулах зарчмыг хангах үүрэгтэй. Ийм бодлого байхгүй бол боловсруулж батлах талаар бодох нь зүйтэй.

Боловсон хүчний сургалттай холбогдуулан, нийгэмшил, хөгжлийн бэрхшээлийн ёс зүй, харилцааны асуудлууд нь энэхүү гарын авлагад туссан бусад зорилтын адилаар сургалтын үйл явцын салшгүй хэсэг байх ёстой. Энэ бүлгийн ард өгөгдөж байгаа саналууд эдгээр асуудлын хүрээнд ажиллах удирдамж болж болох юм.

Багш, сургагчийн хувьд та сургалтын орчноо хянаж суралцагчдын хувьд тодорхой дүрийг илэрхийлж байдаг. Түүнчлэн та бусад ажилтнууд, туслах багш нар, үйлдвэрлэлийн сургалт явуулах ажил олгогчид зэрэг хүмүүсийн хувьд мөн загвар дүрийг илэрхийлнэ. Та суралцагчдыг бүгдийг нь хүндэтгэж нэгэн адил шударгаар харьцах ёстой. Хэрэв та хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй анх удаа ажиллаж байгаа бол өөрийн үйл хөдлөл, хэл яриагаа анзаарч энэ хэсэгт авч үзсэн хөгжлийн бэрхшээлийн ёс зүйн асуудлыг сайтар анхаарах хэрэгтэй.

Оролцоог дэмжих үйл ажиллагааг төлөвлөх хэрэгтэй. Ялангуяа дадлагажих сургалт, орон нутагт ажиллах зэрэг сургалтын циклээс гадуурх аливаа бусад үйл ажиллагааны явцад чухал үүрэгтэй байх болно.

Танай хөтөлбөрт оролцож болох хөндлөнгийн илтгэгч идэвхтэнгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хэрхэн ажиллаж нийгмийн оролцоог хангах тухай танилцуулж улмаар тэдний зүгээс хөгжлийн бэрхшээлийн ёс зүйг зохистойгоор баримтлан нийгмийн оролцоог дэмжих болно.

4.6 Дүгнэлт

Энэхүү бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын нийгмийн оролцооны асуудалд хэрхэн хандах, дэмжих талаар саналууд дэвшүүлсэн. Мөн хөгжлийн бэрхшээлийн иргэдийн оролцоо, оролцоог дэмжих нийгмийн нөхцөл утга агуулга ба хөгжлийн бэрхшээлийн ёс зүйн асуудлуудыг авч үзсэн юм. Энэ мэдээлэл нь танай төв, анги, дадлагын газрын сургалтад оролцож байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тооноос үл хамаарч, оролцоог хангах үйл ажиллагааны аль ч түвшинд байсан үнэтэй, чухал байх болно.

Та хөгжлийн бэрхшээлийн бүх асуудлаар мэргэшсэн байх албагүй гэдгийг ойлгох нь чухал. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар хандаж тусалцаа авах түншүүд байна. Мөн суралцагчдыг дадлагажуулах ажил олгогчид, сургалтын бусад чиглэлд тантай хамтарч буй бусад түншүүдийг та хөгжлийн бэрхшээлийн оролцооны асуудлаар, тухайлбал тусламж үйлчилгээ, хэл, нийгмийн харилцан үйлчлэл харилцаа зэрэг асуудлаар сургаж мэдлэг олгох шаардлагатай болдог.

Хавсралт 3

Хөгжлийн бэрхшээлийн ёс зүй, оролцооны нийгмийн талтай холбогдох практик санамжууд	
Тэмдэглэл: Биеэ авч явах байдал, ёс зүйг ихэнхдээ соёл, зан заншил тодорхойлж байдаг, ялангуяа нүдээр харилцах ба мэндчилгээнд, дараах жагсаалтыг авч үзэхдээ соёлын нөлөөллийг анхаарах хэрэгтэй.	
Нөхцөл байдал	Санал болгох шийдэл
Мэндлэх	
Хэрэв суралцагч гараа бүрэн буюу хязгаарлагдмал байдлаар ашиглах чадваргүй бол гараа барих уу?	Эдгээр бүх тохиолдолд: Хэрэв харьцах хүн гараа сунгахгүй эсвэл сунгаж чадахгүй байвал гарт нь эсвэл мөрөнд нь хүрч мэндчилж болно. Гол нь гар хүрч мэндчилэх хүсэлтэй байх нь чухал.
Хэрэв суралцагч маш богино гартай бол гар барих уу?	
Хэрэв суралцагч протезтэй бол гар барих уу?	
Хэрэв суралцагч гаргүй бол түүнтэй мэндлэхдээ аль нэг байдлаар гар хүрэх уу?	
Хэрэв суралцагч хараагүй бол гар барих уу?	
Нүдээр харилцах ба харааны түвшин	
Хөгжлийн бэрхшээлийнх нь төрөл шинжээс хамаарахгүйгээр ийм хүнтэй харилцахдаа харааны нэг түвшинд байж нүдээр харилцсан хэвээр байхыг хичээх ёстой юу?	Тийм, бүх тохиолдолд. Нүдээр харилцсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд чухал ойлголт өгдөг. § Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харьцахад тухайн хүнд аятай байна § Харьцаж байгаа хүн нь хөгжлийн бэрхшээлийг нь анзаарахгүй, өөрт нь анхаарлаа хандуулж байна § Аль ч хүнтэй, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс шалтгаалахгүйгээр, хүндэтгэн хандахад бэлэн § Адил төстэй нөхцөлд тухайн хүн бусад бүх хүнтэй нэгэн адил хүндэтгэж харьцах
Хараагүй хүнтэй нүдээр харилцах уу?	Тийм, хараагүй хүмүүс таны дуу хоолой хаанаас, аль чиглэлээс гарч байгааг маш сайн мэдрдэг.

Сонсголын бэрхшээлтэй хүнийг хэлмэрч дагалдаж яваа тохиолдолд хэлмэрч орчуулж байх хооронд нөгөө хүн нь дүлий хүнтэй нүдээр харилцсан хэвээр байх ёстой юу?	Тийм. Сонсголгүй хүнтэй ярилцахдаа харьцаж буй хүн дор дурдсан нөхцөлд үргэлж нүдээр харилцах ёстой. Үүнд: § Сонсголын бэрхшээлтэй хүн, хэлмэрч рүү харж байх § Та өөрөө ярьж байх § Хэлмэрч сонсголын бэрхшээлтэй хүний яриаг танд орчуулж өгч байх Эхэндээ хэрэгжүүлэхэд амаргүй ч, хэлмэрчийг өрөөнд хамт байхгүй байна гэж төсөөлөх нь хамгийн зөв арга байдаг.
Харааны бэрхшээлтэй эсвэл тэргэнцэртэй хүнтэй харааны нэг түвшинд харьцах явдал чухал уу?	Анги танхимаас гадуур нийгмийн харилцаанд оролцохдоо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй үргэлж нүдээр харилцаж байх ёстой.
Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харьцахдаа хэрэв тэр хүн сууж байгаа бол заавал суух ёстой юу?	Боломжтой бол, дэргэд нь хамт суух нь хүндэтгэлтэй байна.
Тусламж хүсэх ба туслах	
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж хэрэгтэй байгаа бол хүсэх ёстой юу?	Тийм, ихэнх тохиолдолд. Ихэнх тохиолдолд тусламж хэрэгтэй бол хүмүүс тэр тухай хэлдэг. Хэн нэгэн «Танд тусламж хэрэгтэй юу?» гэж асуухад «Үгүй» гэж хариулж мэднэ.
Хөгжлийн бэрхшээлтэй хүнээс тусламж хэрэгтэй эсэхийг нь асууж болох уу?	Хэрэв «Тийм» гэж хариулвал «Би яаж танд туслах вэ?» гэж хэлэх нь зүйтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар тусламж хэрэгтэй тухай мэдэмхийрч тэргэнцэрийг нь түрэх, хараагүй хүний гарнаас барьж авах зэргээр авирлаж болохгүй. Энэ үйлдлүүд тань хүмүүсийг цочирдуулж гайхширлийг нь төрүүлэн тэнцвэр алдагдуулж мэднэ.
Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харьцах явцдаа бусад хүмүүс тэдгээрт хэзээ, хаана, хэрхэн туслах хэрэгтэй тухай мэдлэгтэй болох уу?	
Нэр томьёо	
Дараах хэллэгийг хэрэглэх нь зохистой юу? «тахир дутуу, эрэмдэг», «татаж унадаг өвчтэй», эсвэл «хавдарт өртсөн, хохирогч, гм?	Үгүй. Сөрөг тодорхойлолтгүйгээр цэвэр баримт дурдаж байх нь зүйтэй, тухайлбал, тэр явж чаддаггүй, тэр эпилепситэй, тэр хавдартай гм.
Дараах хэллэгийг хэрэглэх нь зохистой юу? – «тэргэнцэрт хүлэгдсэн! баригдсан?», эсвэл «гадуур явахдаа хөтөч нохойны тусламж авах хязгаарлалттай» гм	Үгүй. Сөрөг тодорхойлолт хэрэглэх-гүйгээр, тэргэнцэр ашигладаг, хөтөч нохой, эсвэл таяа, тулгуур гм баримтыг тэмдэглэж ярих хэрэгтэй.

Нийгмийн харилцааны бусад асуудал	
Нийгмийн арга хэмжээнд сонсголын бэрхшээлтэй хүмүүс оролцож байгаа нөхцөлд орчуулагч байлгах шаардлагатай юу?	Үгүй. Бүх хүнд орчуулагч хэрэг болдоггүй, зарим нь уруулаар унших? эсвэл бичгээр харьцаж чаддаг. Хэрэгцээг тодорхойлох нь чухал. Олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээний үеэр дохионы хэлний хэлмэрч ажиллаж байдаг. Сонсгол султай хүмүүст зориулж субтитр ашиглахад бусад хүмүүст бас хэрэгтэй байдаг.
Сонсгол султай хүнтэй ярилцахдаа дуугаа өндөрсгөх эсвэл уруулаа илүү идэвхтэй хөдөлгөх ёстой юу?	Үгүй. Ердийн дуу хоолойгоор ярьж яриагаа гарын хөдөлгөөн, нүүрний илэрхийллээр дэмжих, гэхдээ анхаарлыг сарниулахгүй байх хэрэгтэй. Гараараа амаа хаахаас зайлсхийх хэрэгтэй.
Ярианы бэрхшээлтэй хүнээс юу хэлсэнээ давтан хэлээч гэж хүсэхгүй байх нь зөв үү?	Үгүй. Хэн ч гэсэн тэднээс юу хэлсэнээ давтахыг хүсч болно. Тэд өөрийн хэлсэнийг нь бусад хүмүүс ойлгоосой гэж хүснэ.
Хүний хэлсэнийг давтаж зөв ойлгосон эсэхээ магадлах нь тохиромжгүй юу, гомдоох үү?	Үгүй. «Та ингэж ... хэлсэн үү» гэж асуух нь зүйтэй.
Арга хэмжээний орон зайг бэлтгэх	
Олон нийтийг хамарсан нийгмийн арга хэмжээнүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэлцэн очих боломжтой газарт зохион байгуулах ёстой юу?	Тийм.
Ширээ, сандлыг байрлуулах тусгай арга хэлбэр байх үү?	Тийм. Юуны өмнө, ширээ сандлууд бат бэх байх ёстой, хоорондын зай нь тэргэнцэртэй хүмүүс чөлөөтэй зорчих боломжтой байх, таяг тулгуур ашиглаж явдаг хүмүүст аюулгүй нөхцөлөөр хангагдах ёстой. Ширээ, сандлуудыг нэг газарт бүгдийг нь байрлуулах хэрэггүй, харин өрөөнд тарааж байрлуулна. Хэрэв ийм хүмүүс ирэх бол ширээ бүрд тэргэнцэртэй хүмүүст зориулсан нэгээс хоёр хоосон зай байх ёстой.
Шаардлагатай үед тусламж үзүүлэх тусгай хүмүүс бэлэн байх ёстой юу?	Тийм. Хүн бүрээс тусламж хэрэгтэй эсэхийг асууж тодруулах хэрэгтэй. Ялангуяа арга хэмжээ болох газрын орц шаттай байх, хоолны өөртөө үйлчлэх ширээтэй, эсвэл нэг газраас нөгөөд хүрэх зүг чиг олоход хүндрэлтэй нөхцөлд ийм тусламж чухал байна. Томоохон арга хэмжээний үеэр сайн дурын туслагчдыг энгэрийн зүүлтээр харж ялгах боломжтой байдаг.

Нэг буюу хэд хэдэн илтгэгч байгаад нэг нь хөгжлийн бэрхшээлтэй ба зогсож чадахгүй хүн байвал бүх илтгэгчид сууж ярих нь дээр үү?	Ингэх шаардлагагүй, гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй урьдчилан зөвлөлдөж хэрэгцээг нь тодорхойлох хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй илтгэгч бүрээс ямар тусламж хэрэгтэйг нь урьдчилан тогтоох нь чухал. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс тогтвортой тулгууртай индэртэй бөгөөд хэн нэг нь түүний цаас материалыг индэр дээр тавьж өгч туслах нөхцөлд зогсож ярихаар шийдэж болно. Хэрэв тайз өндөрлөгөөтэй бол түүн дээр тэргэнцэрээр гарах зам, налуу гарц төхөөрөмжтэй байх ёстой. Явах хөдөлгөөний бэрхшээлгүй хүмүүс тайзан дээрээс үгээ хэлж, тэргэнцэртэй хүмүүс «шалан дээрээс» ярих нөхцөл гаргаж болохгүй. Хөгжлийн бэрхшээлтэй ба бусад бүх илтгэгчид шаардлагатай бүх нөхцөлөөр хангагдах ёстой. Үг хэлж байгаа хүн илтгэлийн үеэр ашиглах материалаа тавих тавиуртай байх ёстой.
Илтгэгч хүн хараагүй эсвэл сонсголгүй байвал тусгай журам зохицуулалт байгаа юу?	Тийм. Харж чадахгүй байгаа хүнд өрөөний зохион байгуулалтыг дүрсэлж тайлбарласан танилцуулга өгөх хэрэгтэй. Ийм хүмүүсийг дагалдаж хоол идэх үеэр туслах хүн томилох нь зохимжтой байна. Сонсголын бэрхшээлтэй хүмүүст дохионы хэлний хэлмэрчийн тусламж авах боломж олгох ёстой.
Арга хэмжээ зохион байгуулахад бэлдсэн байвал зохих зүйлс	
Гуурс	Гараа ашиглах бэрхшээлтэй хүмүүс бусдын тусламж авахгүйгээр юм уухдаа хэрэглэхэд зохимжтой байдаг.
Цахилгааны залгуур уртасгагч	Цахилгаан хэрэгслүүдийг цэнэглэх, ашиглахад хэрэгтэй.
Бүдүүн үзэг, харандаа	Гараа бүрэн ашиглаж чаддаггүй хүмүүс бүдүүн үзэг, харандаа ашиглах нь илүү дөхөмтэй байдаг.
Ширээний гэрэл	Харааны бэрхшээлтэй зарим хүмүүст (гэрэлтүүлгийн түвшин, чиглэл) хэрэгтэй байдаг.
Тогтоох тууз	Цаас бусад материалыг ширээн дээр гулгуулахгүй тогтоох зориулалттай.
Дуу хураагуур	Бичиж чадахгүй хүмүүст туслах хүн байхгүй нөхцөлд чухал юм.
Томруулагч, өсгөгч шил	Сул хараатай хүмүүст чухал юм.
Бичгийн тавиур, суурь	Сонсголын бэрхшээлтэй хүмүүс бусадтай харилцахдаа хэрэглэдэг.
Бариултай цүнх	Арга хэмжээний үеэр материалууд ашиглагдах бол тэднийг хийж явахад хэрэгтэй.
Нэрийн хуудас, зүүлт ба цэвэр хуудас	Энэ нь хүмүүсийн дүр төрх, царайг нэртэй нь (мөн харъяалал, сонирхол гм) холбож харьцахад чухал байдаг.

НОМ ЗҮЙ

International Labour Office. 2008. “Count us in! How to make sure that women with disabilities can participate effectively in mainstream women’s entrepreneurship development activities”. International Labour Office, Geneva.

- 2008. “Getting Hired: A guide for job-seekers with disabilities”. ILO Regional Office for Asia and the Pacific, Bangkok.
- 2008. “Getting Hired: A trainer’s manual for conducting a workshop for job-seekers with disabilities”. ILO Regional Office for Asia and the Pacific, Bangkok.
- 2008. “ILO Vocational rehabilitation and employment (disabled persons) Convention (No. 159) and Recommendation (No. 168) – United Nations Convention on the rights of persons with disabilities”. International Labour Office, Geneva.
- 2008. “Link and Learn: Inclusion of women with disabilities in the ILO WEDGE Programme. Progress assessment in four African countries”. International labour Office, Geneva.
- 2008. “Managing success: An instruction manual for the APPT database and management information system”. ILO Subregional Office for East Asia, Phnom Penh.
- 2008. “Skills development through community-based rehabilitation (CBR): A good practice guide”. Skills and Employability Department. International Labour Office, Geneva.
- 2008. “Training for success: A guide for peer trainers”. ILO Subregional Office for East Asia, Phnom Penh.
- 2009. “Rural skills training: A generic manual on training for rural economic empowerment (TREE)”. International Labour Office, Geneva.
- 2010. “Disability in the workplace: Company practices”. Skills and Employability Department, Bureau for Employers’ Activities. International Labour Office, Geneva.
- 2011. “Decent work for people with disabilities: Moving towards disability inclusion”. ILO, Irish Aid Partnership Programme, International Labour Office, Geneva.
- 2012. “TVET Reform: Designing and inclusive skills development program”. ILO Country Office for Bangladesh, Dhaka.

Parmenter, T.R.2011. “Promoting training and employment opportunities for people with intellectual disabilities: International experience”. Skills and Employment Department, Employment working paper No. 103, International Labour Office, Geneva.

-
- Perry, D.A. 2003. "Moving forward – Toward decent work for people with disabilities: Examples of good practices in vocational training and employment from Asia and the Pacific". ILO Regional Office for Asia and the Pacific, Bangkok.
- 2007. "Employability: A resource guide on disability for employers in Asia and the Pacific". ILO Regional Office for Asia and the Pacific, Bangkok.
- Powers, T. 2008. "Recognizing ability: The skills and productivity of persons with disabilities: Literature review". Skills and Employability Department, Employment working paper No. 3, International Labour Office, Geneva.

ОУХБ нь олон жилийн турш хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрх, тэгш боломж, тэдний ур чадварыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. ОУХБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 1983 оны 159 дүгээр конвенц нь тэгш эрхийн зарчмын үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, ажил хөдөлмөр эрхлэлтийг хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрт нээлттэй гэдгийг баталгаажуулсан.

2012 оны 11 дүгээр сард, ОУХБ-ын Удирдах Зөвлөлөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах санаачлагыг хэрэгжүүлж улмаар ОУХБ-ын бүхий л чиглэл, үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахаар шийдвэрлэсэн. Жендер, тэгш эрх болон олон талтын асуудал хариуцсан газар хэлтсүүд нь энэхүү санаачлагыг хэрэгжүүлэхэд мөн чухал үүрэгтэй.

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг олон орон баталснаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлтийн асуудалд ихээхэн анхаарал хандуулах болсон.

Та энэхүү Мэргэжлийн сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах нь: Практик гарын авлагаар зөвлөгөө, арга барилыг олж мэдэх бөгөөд таны сургалтын хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй дадлагажигчдыг бүрэн хамруулж, тэдэнд хэрэгтэй байгаа дэмжлэгийг өгөхөд чухал үүрэг гүйцэтгэнэ.